

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2018 №01 (63)
16 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР
ЗӨВЛӨХ

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Хүчитбаатар БАДНААЖОНОН

Гарчиг.....

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Монгол Улс дахь нуугдмал гэмт хэргийн түвшин: субъектив аргачлалаар тооцсон байдал.....Б.Энхболд, Б.Соронзонбаатар
- Хууль зүйн судалгаанд математик статистикийн аргыг ашиглах нь.....Б.Мөнхдорж
- Монгол Улсын гэмт хэргийн статистикийн үүсэл хөгжил, уламжлал.....Б.Мягмарсүрэн
- Тоон мэдээлэл боловсруулах ухаан ба гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх менежмент.....Л.Цогтбаяр
- Улаанбаатар хотод үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээБ.Соронзонбаатар

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- “Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээний талаарх цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хэрэглээ” судалгааны тойм.....Л.Бат-Очир
- Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулж буй эрх зүйн зохицуулалт, онцлог.....Б.Одонгэрэл
- Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн ойлголт, ангилалтын асуудал.....Б.Мөнхзаяа

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Цагдаагийн албан хаагчийн сахилга, ёс зүйн төлөв байдал.....Л.Нямдаваа
- Цагдаагийн албан хаагч нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодис хэрэглэх аргачлал, анхаарах зарим асуудал.....Ш.Чулуун
- Нийгмийн хэв журам хамгаалахад орчин үеийн техник, технологийг ашиглах нь.....Б.Мэндбаяр

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ НУУГДМАЛ ГЭМТ ХЭРГИЙН ТҮВШИН: СУБЪЕКТИВ АРГАЧЛАЛААР ТООЦСОН БАЙДАЛ ¹

Б.Энхболд

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч

Б.Соронзонбаатар
ХСИС-ийн магистрант

Нуугдмал гэмт хэргийг тодорхойлох субъектив аргачлалын ойлголт

Нуугдмал гэмт хэрэг гэж “Цаг хугацаа орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсэж бий болсон төрийн бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг хэлнэ²”. Нуугдмал гэмт хэрэг үүсэн бий болох шалтгаан нь объектив субъектив шинжээр тодорхойлогдсон эдийн засаг улс төр, үзэл суртал ухамсарын, эрх зүйн болон бусад нийгмийн харилцаан дахь нөхцлүүдээр нөхцөлдсөн нууц далд үйл явцуудын адил нийгмийн харилцааг удирдах төрийн сул дорой байдал алдаанаас үүдэлтэй байна гэж хэлж болохоор байна³.

Нуугдмал гэмт хэргийг объектив нуугдмал, субъектив нуугдмал гэмт хэрэг гэж ангиж болохоор байна⁴. Объектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт “нуун дарагдуулсан” өөрөөр хэлбэл хууль сахиулах байгууллагад ямар нэг хэлбэрээр мэдэгдсэн боловч нэгдсэн тоо бүртгэлд ороогүй гэмт хэрэг. Субъектив нуугдмал гэмт хэрэг гэдэгт “нууц далд” гэмт хэрэг өөрөөр хэлбэл, бодит байдал дээр үйлдэгдэж хэн нэгэн этгээд хохирсон боловч хууль сахиулах байгууллагад огт мэдэгдээгүй гэмт хэрэг.

Субъектив нуугдмал гэмт хэргийн талаар барууны хөгжингүй орнуудад 1940–өөд оноос эхлэн эрчимтэй судалгаа хийж эхэлсэн. Энэхүү судалгаануудын үндсэн чиглэл нуугдмал гэмт хэргийн тоон хэмжээг хэмжих арга аргачлал боловсруулахад чиглэгдэж байсан. Энэ үйл ажиллагаанд барууны оронд түгээмэл хэрэглэгддэг “Гэмт хэрэгт хохирох явдлын судалгаа”⁵ (National crime victimization survey), хамаардаг бөгөөд энэхүү судалгаа дээрх аргачлалын дугуу хисэн болно.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Нуугдмал гэмт хэргийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгаанд Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Дундговь, Завхан, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 14 аймгийн иргэд болон Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Багахангай, Сүхбаатар, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх зэрэг 8 дүүргийн иргэдийг оролцуулан нийт 1449 иргэнээс авсанаас 916 буюу 63.2 хувь орон нутгаас, 533 буюу 36.8 хувь Улаанбаатар хотоос хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдын 660 буюу 45.5 хувь эрэгтэй, 789 буюу 54.5 хувь нь эмэгтэй байна. Дээрх иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 21 хувь нь 18-25 нас, 37 хувь нь 26-35 нас, 24 хувь нь 36-45 нас, 12 хувь нь 46-55 насны иргэд байна. /График №1/

¹ Энэхүү судалгааг “Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн тогтолцоог боловсронгуй болгох нь” шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд гүйцэтгэв.


² Сазонова Н.В. “Латентная преступность: понятие, причины, измерение” дисс.. канд юрид наук. Красноярск.. автореферат с.9. 2004

³ Д.Мягмарцэрэн “Нуугдмал гэмт хэрэг, ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал”, Хууль сахиулахуй сэтгүүл, УБ., 2015 №1

⁴ Д.Мягмарцэрэн “Нуугдмал гэмт хэрэг, ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал”, Хууль сахиулахуй сэтгүүл, УБ., 2015 №1

⁵ Roberson Wallace, introduction to criminology., New York, 2009

График №6. Судалгаанд оролцогчдын насны байдал



Боловсролын түвшингээр нь авч үзвэл, 59 буюу 4.1 хувь нь боловсрол эзэмшээгүй, 210 буюу 14.5 хувь нь бүрэн бус дунд, 463 буюу 32 хувь нь бүрэн дунд 690 буюу 47,6 хувь нь дээд боловсролтой иргэд байна. /Хүснэгт №1/

Хүснэгт №1 Боловсрол эзэмшсэн байдал

Боловсролын түвшин	Тоо	Хувь
Боловсрол эзэмшээгүй	59	4.1%
Бүрэн бус дунд боловсролтой	210	14.5%
Бүрэн дунд боловсролтой	463	32.0%
Дээд боловсролтой	690	47.6%
Нийт	1449	100.0%

Судалгааны түүврийн хэмжээ, оролцогчдын хүн ам зүйн шинжээс үзвэл судалж буй асуудлын талаар бодитой мэдээлэл өгөх боломжтой нийгмийн гишүүдийн төлөөлөл оролцсон байна.

Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл

Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлоход тухайн нутаг дэвсгэр дахь гэмт хэргийн нөхцөл байдлын талаарх иргэдийн төсөөлөл чухал үүрэгтэй байдаг. Хэрэв иргэд гэмт хэргийн нөхцөл байдлын талаар сөрөг төсөөлөлтэй байвал тухайн нутаг дэвсгэр дэх гэмт хэргийн түвшин өндөр байх магадлалтай гэж үздэг. Энэ нөхцөл байдлыг тодруулах зорилгоор судалгаанд оролцсон иргэдэд “Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх вэ?”, “Миний оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн түвшин ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэсэн асуулт тавьж хариултыг 1-5 үзүүлэлтээр хэмжихэд дундаж үзүүлэлт 2.82 гарч байна./ Хүснэгт №2/

Хүснэгт №2 Гэмт хэргийн талаарх иргэдийн төсөөлөл

	Их буурна	Буурна	Тодорхой бус	Өснө	Их өснө	Дундаж
Улсын хэмжээнд гэмт хэргийн түвшин	3.2%	28.4%	48%	17.6%	2.8%	2,88
Миний оршин сууж буй нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэргийн түвшин	4.6%	32.6%	47.3%	13.4%	2.3%	2,76

Гэмт хэргийн чиг хандлагын талаарх мэдрэмж улсын хэмжээнд **2.82** коэффициентийг илэрхийлж байна

Дээрх судалгаанаас үзэхэд улсын хэмжээний гэмт хэргийг нийт судалгаанд оролцогчдын 31,6 хувь нь буурна гэж үзсэн бол өөрийн оршин сууж буй нутаг дэвсгэрийн гэмт хэргийг буурна гэж 37,2 хувь нь тус тус хариулсжээ. Улсын хэмжээнд гэмт хэрэг өснө гэж судалгаанд оролцогчдын 20,4 хувь, орон нутгийн хэмжээнд 15,7 хувь нь хариулснаас үзэхэд иргэд гэмт хэрэг буурна гэсэн хандлагатай байна. Харин аль аль үзүүлэлт дээр нь судалгаанд оролцогчдын 45-аас дээш хувь нь тодорхой бус гэсэн хариултыг сонгосон нь иргэд энэ талаар өөртөө итгэлгүй байгааг илэрхийлнэ. Судалгааны үр дүнгээр 1 гэсэн үнэлгээ рүү ойртох тусам гэмт хэргийг буурна гэж үзэх боломжтой бөгөөд энэ хандлага нь нуугдмал гэмт хэргийн түвшин бага байгааг илэрхийлдэг. Бидний судалгааны үр дүнгээр дундаж үзүүлэлт 2.82 гарч байгаа нь иргэд гэмт хэргийг буурна гэж үзэхгүй байгааг илэрхийлэх бөгөөд нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байгааг харуулж байна.

Гэмт хэргийн чиг хандлагын талаарх төсөөлөл

Нуугдмал гэмт хэргийн түвшинг хэмжих өөр нэг аргачлал нь гэмт хэргээс түгших, айх явдал. Гадаадын зарим оронд явуулсан гэмт хэрэгт хохирох эрсдлийн судалгааны дүнгээс үзэхэд тодорхой төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй гэж айдас нэмэгдэх тусам тухайн нийгэм дэх нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр гэж үздэг. Өөрөөр хэлбэл, иргэд гэмт хэргээс айх, түгших хандлага өндөр байх нь хууль сахиулах байгууллага гэмт хэргийг бүрэн хяналтандаа авч чадаагүйгээс гэмт хэрэг нуугдмал шинжтэй болж, цагдаагийн байгууллагад бүртгэгдэхгүй байгааг илэрхийлдэг. Нөгөө талаар нийгэмд түгээмэл үйлдэгддэг хэдий ч цагдаагийн байгууллага бүрэн хяналтандаа авч чадаж байвал гэмт хэргээс иргэд түгших хандлага бага байдаг.

Энэ асуудлыг тодорхойлох зорилгоор тодорхой төрлийн 8 гэмт хэргээс түгших хандлагыг дараах асуултаар шалгасан болно. Хүснэгт №3-т үзүүлсэн дүнгээс үзвэл “Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ” гэхээс айдаг гэсэн асуултанд хариулсан байдлын дундаж нь 3.18 бол дараагийн дугаарт “Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна” гэхээс айдаг гэсэн асуултын дундаж хариулт 3.14 гэсэн үзүүлэлттэй байна. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн төрөлд бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.94 гэсэн дундаж үзүүлэлтээр орж байгаа бол хууль бусаар мөрдөж гэмт хэргийн 2.96 гэсэн үзүүлэлттэй байна. Бусад гэмт хэргийн дундаж үзүүлэлт 3,0 байгаа нь тийм ч сайн үзүүлэлт биш.


Хүснэгт №3 Гэмт хэргээс түгших хандлагын үзүүлэлт

Асуулт	Огт айдасгүй байдаг	Айдасгүй байдаг	Тодорхой бус	Айдастай байдаг	Их айдастай байдаг	Дундаж
Миний амь нас, эрүүл мэндэд хэн нэгэн халдаж хохироож болзошгүй гэж	6.4%	22.5%	37.4%	30.4%	3.3%	3,01
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт зүйлсийг хүч хэрэглэж авна гэхээс	5.7%	23.8%	34.9%	32.2%	3.5%	3,04
Хэн нэгэн миний мөнгө болон үнэт эдлэлүүдийг хулгайлна гэхээс	5.5%	20.8%	32.6%	36.1%	5.1%	3,14
Хэн нэгэн миний эд хөрөнгийг залилан мэхлэж авна гэхээс	5.2%	22%	38.7%	30.2%	3.8%	3,05
Хэн нэгний бэлгийн халдлагад өртөгдөнө гэхээс	8.7%	24.6%	36.1%	25.1%	5.4%	2,94
Хэн нэгэн миний эд хөрөнгийг санаатай устгаж, гэмтээж болзошгүй гэхээс	3.7%	22.4%	39%	30%	4.9%	3,09
Хэн нэгэн миний орон байранд хууль бусаар нэвтэрнэ гэхээс	3.8%	21.1%	33.7%	35.4%	6%	3,18
Хэн нэгэн намайг мөрдөж сэтгэл санааны дарамтад оруулна гэхээс	6.5%	26%	36.6%	26.3%	4.5%	2,96

Тодорхой төрлийн гэмт хэргийн айдас улсын хэмжээнд **3.05** коэффициентийг илэрхийлж байна.

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд Монгол Улсад бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг, ялангуяа орон байрнаас эд зүйлийг хулгайлах гэмт хэргээс иргэд хамгийн их түгших хандлагатай байна. Судалгааны хариулт 1 рүү дөхөх тусам эерэг үзүүлэлтийг илэрхийлэх бөгөөд судалгааны дундаж дүнг үзэхэд 3.05 тай байгаа нь гэмт хэргийн төсөөлөлөөс илүү өнөө цагт гэмт хэрэгт өртнө гэдгээс айдастай байгааг харуулж байна. Судалгааны нарийвчилсан дүнгээс үзэхэд “Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, “Хууль бусаар мөрдөх” гэмт хэргээс бусад бүх төрөлд “Айдас байдаггүй” гэсэн хариултаас “Айдастай байдаг” гэсэн хариултын хувь их байгаа нь гэмт хэргийн нуугдмал байх шинжийг бататгаж байна. /График №2/.

График №2 Гэмт хэргээс айх болон айдасгүй байдлын харьцуулалт



Дээрх судалгааны дүнгээс үзвэл бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг хамгийн их нуугдмал шинжтэй байгаа бол залилан мэхлэх, дээрэмдэх гэмт хэргүүдийн хувьд ч нуугдмал байх магадлал өндөртэй байна. Түүнчлэн хүчиндэх болон бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг нуугдмал байдаг гэсэн таамаглал энэ судалгааны хувьд үгүйсгэгдэж байгаа нь сонирхол татаж байна. Гэхдээ энэ судалгааны хувьд бусад гэмт хэргийн төрөлтэй харьцуулахад харьцангуй доогуур үзүүлэлттэй боловч дангаар нь авч үзвэл хоорондын зөрүү маш бага, дундаж үзүүлэлт 36.6 хувийг эзлэж байгаа нь тайвшрах үзүүлэлт биш. Харин хууль бусаар мөрдөх гэмт хэргийн хувьд Монгол Улсад түгээмэл биш байдагтай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргээс түгших хандлага бага байх боломжтой.

Гэмт хэрэгт шүүд болон шүүд бусаар хохирсон байдал

Хохирогчоор дамжуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлдог аргачлалын дагуу судалгаанд оролцогчдоос Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгддэг 15 төрлийн гэмт хэрэгт хохирч байсан туршлагыг асууж, хариултад дүн шинжилгээ хийсэн болно. Эх олонлогоос түүвэрлэлт хийх замаар судалгаанд оролцогчдыг сонгож авсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын нөхцөл байдлыг илэрхийлэх чадвартай гэж үзсэн болно.

Хүснэгт №4-т гэмт хэргийн улмаас сүүлийн 2 жилийн хугацаанд хохирсон гэж өөрсдийгөө үзсэн иргэдийн хариултыг эрэмблэн харуулав. Судалгаанд оролцсон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэргийн улмаас хохирсон нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бол хоёрдугаарт 389 буюу 26.9 хувь нь ямар нэгэн байдлаар хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авах замаар хохирсон гэж тус тус хариулжээ. Харин хамгийн бага үзүүлэлттэй байгаа гэмт хэргийн хувьд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хууль бусаар мөрдөх гэмт хэргүүд орж байгаа нь өмнөх асуулгын үр дүнтэй нийцэж байна.

Хүснэгт №4 гэмт хэрэгт шүүд хохирсон байдал

№	Гэмт хэргийн төрөл	Тийм	Үгүй
1	Эд хөрөнгөө хулгайд алдаж	32.0%	68.0%
2	Хуурамч бараа бүтээгдэхүүн худалдан авч	26.9%	73.1%
3	Эд хөрөнгөө залилан мэхлүүлж	17.8%	82.2%
4	Гүтгэгдэж, доромжлогдож	16.3%	83.7%
5	Зам тээврийн осолд өртөж	15.1%	84.9%

6	Эд хөрөнгөө дээрэмдүүлж	14.5%	85.5%
7	Бусдын халдлагад өртөж	14.3%	85.7%
8	Эд хөрөнгөө булаалгаж	11.8%	88.2%
9	Авилгын улмаас эрх ашиг хөндөгдөж	10.1%	89.9%
10	Цахим гэмт хэрэгт өртөж	8.0%	92.0%
11	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж	6.5%	93.5%
12	Хилсээр хэрэгт шийтгэгдэж	6.3%	93.7%
13	Хүн барьцаалагдаж эсвэл хулгайлагдаж	5.4%	94.6%
14	Бэлгийн дарамт, хүсээгүй бэлгийн харьцаа	4.8%	95.2%
15	Хууль бус мөрдлөгийн улмаас	4.7%	95.3%

Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлоход шууд бусаар хохирсон байдлыг тодруулах нь ач холбогдолтой байдаг. Иймээс судалгаанд оролцогчдоос “Өнөөрсөн нэг жилийн хугацаанд таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан уу?” гэсэн асуулт тавихад бие махбодын хувьд хохирсон гэж 17.6 хувь нь, авилгын улмаас хохирсон гэж 8.5 хувь нь, эд хөрөнгийн хувьд хохирсон гэж 29.9 хувь нь, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэж хохирсон гэж 4.9 хувь нь тус тус хариулжээ. /График №8/

График №8. Шууд бусаар гэмт хохирсон байдал



Дээрх судалгаанаас үзэхэд бусдын эд хөрөнгийг хулгайлах, бие махбодын хувьд хохирох гэмт хэргийн нуугдмал байх магадлал өндөр байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд авилга, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг өсч байгаа талаар эрдэмтэн судлаачид мэдээлэл хийж байгаа боловч энэ судалгааны үр дүнгээр тийм ч өндөр үзүүлэлттэй биш.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүс ямар арга хэмжээ авсан талаар тодруулах зорилгоор “Хэрэв та өөрөө эсвэл таны гэр бүлийн гишүүд, төрөл садан, эсвэл сайн таньдаг хүмүүсийн хэн нэгэн гэмт хэрэгт хохирч байсан бол ямар арга хэмжээ авсан бэ?” гэсэн асуулт гэмт хэрэгт шууд байдлаар хохирсон 463 иргэний 184 буюу 39,9 хувь нь цагдаагийн байгууллагад мэдэгдсэн, 178 буюу 38,5 хувь нь гэр бүлийн гишүүдэд мэдэгдсэн, 133 буюу 26,6 хувь нь бусад хүмүүст мэдэгдсэн гэж тус тус хариулсан байна. /Хүснэгт №5/

Хүснэгт № 5 Гэмт хэрэгт хохироод мэдээлсэн байдал

	Тийм	Үгүй
--	------	------

Цагдаад мэдэгдсэн	39.9%	60.1%
Гэр бүлийн гишүүдэд мэдэгдсэн	38.5%	61.5%
Бусад хүмүүс мэдэгдсэн	26.6%	73.4%

Гэмт хэрэгт хохирсон хүмүүсээс дөнгөж 39.9 хувь цагдаагийн байгууллагад мэдэгдэж байгаа нь нэг талаас нийт гэмт хэргийн 60.1 хувь нь нуугдмал байгааг илэрхийлэх боломжтой, нөгөө талаас иргэд цагдаагийн байгууллагад итгэхгүй байгааг харуулж байгаа нь 2008 онд Максима судалганы төвөөс “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, менежментийн үр нөлөөг сайжруулах, иргэд олон нийт болон цагдаагийн байгууллагын харилцааг сайжруулах нь” сэдэвт судалгааны дүнтэй ойролцоо гарч байна. Тус судалгааг Улаанбаатар хотын 1000 оршин суугчдын дунд санал асуулга болон ярилцлагын аргаар явуулсан бөгөөд судалгаанд оролцогчдын 35 хувь нь гэмт халдлагад өртсөн боловч цагдаагийн байгууллагад хандаагүй гэж хариулсан байна⁶. Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд гэмт хэрэгт хохирогчдын цагдаад мэдээлэл өгөх хандлага 4 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Судалгааны үр дүнд үндэслэн нуугдмал гэмт хэргийг тооцоолсон байдал

Судалгаанд оролцсон 1449 хүнээс гэмт тодорхой төрлийн хэрэгт хохирсон гэж хариулсан /хүснэгт №4/ хүмүүсийн хувь хэмжээгээр хохирсон хүмүүсийн тоог гаргаж, гарсан тоог 100 хувь гэж үзвэл түүний 39,9 гэмт хэрэгт хохирсон талаараа цагдаагийн байгууллагад мэдэгддэг бол 60,1 хувь нь нуугдмал байх боломжтой гэж тооцсон. Жишээлбэл, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг тооцож үзье. судалгаанд оролцосон 1449 хүний 463 буюу 32 хувь нь хулгайлах гэмт хэрэгт хохирсон гэж хариулсан байна. нийт хулгайлах гэмт хэрэгт хохирсон 463 хүний 100 хувь гэж үзвэл тэдний 184 буюу 39.9 хувь нь цагдаад мэдэгдсэн бол 278 буюу 60.1 хувь мэдээлээгүй байна. /Хүснэгт №5/.

Хүснэгт №5. Нуугдмал гэмт хэргийн тодорхойлох судалгааны дүн

Нийт хүн	Хулгайлах гэмт хэрэгт өртсөн хүн	Цагдаад мэдэгдсэн хохирогч	Нуугдмал байх магадлал	Цагдаад мэдэгдсэн хэргээс хэд дахин их
1449	463 буюу 32.0%	184 буюу 39.9%	278 буюу 60.1%	1.5 дахин их

2016 оны байдлаар улсын хэмжээнд нийт 9065 хулгайлах гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байгаа нь нийгэмд бодитоор үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэргийн 39.9 хувь гэж дээрх аргачлалын дагуу тооцож болно. Хэрэв 9065 нь нийт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 39.9 хувь бол 100 хувь нь хэд гэсэн тоон үзүүлэлт гарахыг пропорцын аргаар тооцож, гарсан тооноос бүртгэгдсэн гэмт хэргийг хасах байдлаар нуугдмал гэмт хэргийн түвшинг тодоройлж болно. /Хүснэгт №6/

Нуугдмал гэмт хэргийг тооцоолох аргачлал

Томьёо 1.

⁶ Максима судалгааны төв. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, менежментийн үр нөлөөг сайжруулах, иргэд олон нийт болон цагдаагийн байгууллагын харилцааг сайжруулах санал” сэдэвт судалгааны тайлан, УБ., 2008, 39 дэх тал.

$$Y = \frac{X(100\%)}{K}$$

X - Цагдаад бүртгэгдсэн гэмт хэрэг

Y - Нийт бүртгэгдсэн байх магадлалтай гэмт хэрэг

K- Гэмт хэрэгт өртөөд цагдаагийн байгууллагад мэдэгдсэн коэффициент, "K"-г тодорхойлохдоо гэмт хэрэгт хохирох эрсдлийн судалгааны асуулгад хохирсон гэж хариулт өгөөд, тэднээс цагдаад мэдэгдсэн хүмүүсийн хувь хэмжээгээр (0-1) үнэлгээгээр тодорхойлно.

Томьёо 2.

$$S=Y-X$$

S- Цэвэр нуугдмал байх гэмт хэргийн тоо

Хүснэгт №6. Хулгайлах гэмт хэргийн нуугдмал байх магадлал

1 жилд үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэрэг	Нуугдмал гэмт хэрэг	Бүртгэгдсэнээс хэд дахин их
$\frac{9065 \times 100\%}{39.9\%} = 22662$	$22662 - 9065 = 13597$	1.5

Дээрх аргачлалын дагуу улсын хэмжээний гэмт хэрэг, хулгайлах гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг тооцож үзье. Хүснэгт №7 үзүүлснээр улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргээс нуугдмал байх гэмт хэргийн тоо хамгийн багадаа 1,5 дахин их байна. Улсын хэмжээнд авч үзвэл нуугдмал байх гэмт хэргийн тоо 40750 гэсэн үзүүлэлт гарч байгаа нь өнөөгийн гэмт хэргийн түвшингээс 1,5 дахин их байгааг илтгэж байна. Энэ аргачлалын дагуу тодорхой төрлийн гэмт хэргийн нуугдмал байх магадлалыг тооцож болох хэдий ч гэмт хэрэгт хохироод цагдаагийн байгууллагад мэдэгдсэн хүмүүсийн хувь хэмжээг гэмт хэрэгт хохирох явдлын судалгаагаар тодорхойлох шаардлагатай. энэ судалгаанд ерөнхий байдлаар авч үзсэн тул бусад төрлийн гэмт хэргүүдийг нарийвчлан гаргах боломжгүй байлаа.

Хүснэгт №7. Гэмт хэргийн нуугдмал байх магадлал

№	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн гэмт хэрэг /2016/	Нийт үйлдэгдсэн байж болох гэмт хэргийн тоо	Нуугдмал байх магадлалт тоо	Бүртгэгдсэнээс хэд дахин их
1	Бусдын эд хөрөнгийг хулгайлах (ЭХТА 145)	9065	22663	13597	1.5
2	Нийт гэмт хэрэг	27167	67917	40750	

Дүгнэлт

1. Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Аюулгүй орчинд амьдрах эрхэтэй", 19 дүгээр зүйлийн 1 дахь хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна", мөн 38 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга

- хэмжээ авч хэрэгжүүлэх” нь засгийн газрын үүрэг мөн гэж тодорхойлсон нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй цогцолбор байдлаар авч хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор тогтоох зүй ёсны шаардлагатай холбогдно.
2. Цаг хугацаа орон зайн хүрээнд нийгэмд аюултай үзэгдэл болох нийгмийн болон эрүүгийн эрх зүйн шинжийг агуулсан тодорхой нөхцөлд үүсэж бий болсон төрийн бүртгэлийн системд ороогүй байдлаар илэрхийлэгдсэн бодит гэмт хэргийн нэг хэсгийг нуугдмал гэмт хэрэг гэж тодорхойлж болно. Нуугдмал гэмт хэргийн түвшин өндөр байх тусам, иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, нийгмийн дэг журам алдагдаж, иргэд гэмт хэргээс түгших хандлага нэмэгддэг.
 3. Хохирох явдлын судалгааны дүнгээс үзвэл субъектив нуугдмал гэмт хэргийн түвшин цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргээс 1.5 дахин өндөр үзүүлэлттэй байна. /Хүснэгт №7-г үзнэ үү/
 4. Нуугдмал гэмт хэргийн түвшинг тодорхойлох субъектив аргачлалын дагуу 1449 иргэнээс авсан судалгааны дүнгээс үзэхэд эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэг хамгийн их нуугдмал шинжтэй байгаа бол залилан мэхлэх, дээрэмдэх гэмт хэргүүдийн хувьд ч нуугдмал байх магадлал өндөр байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Сазонова Н.В. “Понятие латентной преступности” Уголовное право и современность: Межвуз. Сб. Науч.тр. Вып. 6. Красноярск: СибЮИ МВД, 2002.-С.8-180-184.
2. Д.Мягмарцэрэн “Нуугдмал гэмт хэрэг, ойлголт, шалтгаан, тооцоолол, өнөөгийн байдал”, хууль сахиулахуй сэтгүүл, УБ., 2015 №1
3. Ли.Д.А. Уголовно-статистический учёт: структурно-функциональные закономерности: моногр.М.:Русский мир, 1997. 21 хуудас.
4. Roberson Wallace, introduction to criminology., New York, 2009
5. Максима судалгааны төв. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, менежментийн үр нөлөөг сайжруулах, иргэд олон нийт болон цагдаагийн байгууллагын харилцааг сайжруулах санал” сэдэвт судалгааны тайлан, УБ., 2008, 39 дэх тал.
6. Цагдаагийн Ерөнхий Газар. “Монгол улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2016”, УБ. 2017 он.
7. Цагдаагийн Ерөнхий Газар. “Монгол улс дахь гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2003-2013”, УБ. 2017 он.

ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНД МАТЕМАТИК СТАТИСТИКИЙН АРГЫГ АШИГЛАХ НЬ

Б.Мөнхдорж

ХСИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цагдаа судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
докторант, цагдаагийн хошууч

Хууль зүйн чиглэлийн суурь болон хавсарга, бодлогын судалгаа хийх, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичихэд тоон мэдээлэл цуглуулах, чанарын судалгаа авах, цуглуулсан судалгааны үр дүнг боловсруулах, дүн шинжилгээ анализ хийх зэргээр статистикийн аргыг зохих түвшинд ашиглаж байна. Шинжлэх ухааны харьцуулах, түүхчлэх, таамаглал шалгах, социологийн зэрэг түгээмэл аргуудтай уялдаатайгаар статистикийн арга хэрэглэгддэг. Иймд статистикийн ойлголт, арга зүйн талаар авч үзье.

Статистикийн аргыг нийгэм, эдийн засаг, мэдээллийн технологи, анагаах ухаан, биологи, астрономи, хөдөө аж ахуй, газар зүй, археологи зэрэг төрөл бүрийн салбар шинжлэх ухаанд өргөнөөр ашиглаж байна. Хүн ам зүйн статистик, эдийн засгийн статистик, физикийн статистик, эрүүл мэндийн статистик, хууль зүй, эрүүгийн, гэмт хэргийн статистик гэх мэтээр салбарлан судлагдаж, боловсронгуй болж байна. Ялангуяа бизнес, маркетинг, үйлдвэрлэл, зах зээлийн шинжилгээ хийх, чанарын хяналт, зах зээлийн ханшны байдлыг урьдчилан прогнозчлох зэрэгт ашиглагдаж байна.

Орчин үед аливаа бодлого боловсруулах, шийдвэр гаргахад статистикийн аргын хэрэгцээ, шаардлага улам нэмэгдэж байна. Тухайлбал, хуульт ёс, шударга ёсыг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах талаарх төрийн бодлогыг тодорхойлох, зөвлөмж өгөх зорилгоор хийгдсэн судалгааны ажлуудад статистикийн арга зайлшгүй ашиглагддаг.

Статистикийн ойлголт

Хүн төрөлхтөн хийж бүтээсэн баялаг, хэрэглэж буй зүйлээ бүртгэн тооцох зайлшгүй шаардлагаар практик статистик манай эрний өмнөх 2200-аад оны үед эртний Вавилон, Египед, Римд үүсжээ. Эхний үед засаг захиргаа, нутаг дэвсгэр, хүн ам, цэргийн зориулалтын чиглэлээр тоон мэдээллийг нэгтгэн гаргадаг байв. Практик статистик 4000 гаруй жилийн түүхтэй байхад онолын статистик сүүлийн 300 гаруй жилийн хугацаанд үүсэн эрчимтэй хөгжжээ. Статистик хэмээх нэр томъёо нь “status” гэсэн латин үгээс гаралтай юмс үзэгдлийн төлөв байдал гэсэн утгатай. Германы эрдэмтэн Г.Ахенваль “статус” гэх латин үгнээс гаралтай статистикийг 1746 онд анх удаа “Хүн ам, эдийн засгийн хүчин зүйлс судлал” гэсэн үгний утгаар илтгэл, өгүүлэл бичиж, хичээл заах замаар шинжлэх ухааны эргэлтэд оруулжээ⁷.

Эрдэмтэн, судлаачид нийгэм, эдийн засгийн үзэгдэл, процессын тоон мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр цуглуулж, боловсруулан шинжилгээ хийж, түүний зүй тогтол, харилцан хамаарлыг тооны аргаар нээж үнэлэлт, дүгнэлт гаргадаг шинжлэх ухааныг статистик гэж тодорхойлсон байдаг.

Орчин үед статистикийг 1-рт: Хүн ам зүй, эдийн засгийн хөгжлийн талаарх тоон мэдээг цуглуулан, боловсруулж, шинжилгээ хийхэд чиглэгдсэн хүмүүсийн үйл ажиллагааны салбар, 2-рт: Статистикийн практикт ашиглагдах онол, арга зүйг боловсруулдаг шинжлэх ухааны салбар, 3-рт: Аливаа тоо мэдээ, үүний дотор статистикийн эмхэтгэл, лавлах, тогтмол хэвлэлүүдэд нийтлэгддэг тоон мэдээллийг статистик гэж нэрлэж хэвшжээ.

Статистик бол бодит нөхцөл байдалд тохирсон, оновчтой шийдвэр гаргахад “шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, тайлбарлах, танилцуулах” арга зүйн тухай шинжлэх ухаан юм. Статистикийг хэрэглээ талаас нь өгөгдлүүдийг зохион байгуулж, цэгцтэй хэлбэрт үзүүлж, шинжилгээ хийдэг шинжлэх ухааныг хэлдэг⁸.

⁷ Gottfried Achenwall (20 October 1719–1 May 1772) was a German philosopher, ARA historian, economist, jurist and statistician. He is counted among the inventors of statistics. “Statistic, status” гэсэн нэршлийг шинжлэх ухаанд анх хэрэглэсэн түүхтэй

⁸ Д.Чимгээ. SPSS нийгмийн статистикийн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах нь. УБ., 2014. 8 дахь тал

Статистик шинжлэх ухаан нь бүтцийн хувьд 1) статистикийн ерөнхий онол⁹, 2) эдийн засгийн статистик¹⁰, 3) салбарын статистик¹¹ гэж хуваагддаг.

Статистикийн судлах зүйл, арга зүй

Статистикийн шинжлэх ухаан нь нийгэм, эдийн засгийн юмс, үзэгдлийн тоо мэдээллийг чанарын агуулгатай нь нягт холбоотойгоор тодорхой орон зай (улс орны, тодорхой бүс нутаг), цаг хугацаанд судалдаг.

Статистикийн арга зүй гэдэг нь нийгэм, эдийн засгийн бүтэц, динамик болон хамаарлын зүй тогтлыг судлахад чиглэгдсэн арга, аргачлалын тогтолцоо юм.

Статистик нь задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хийсвэрлэх, түүхчлэх, ерөнхийгөөс тодорхой, тодорхойгоос ерөнхийд хандах зэрэг шинжлэх ухааны түгээмэл аргыг шууд баримтлан хэрэглэдэг.

Аливаа шинжлэх ухаан өөрийн судлах зүйл, зорилго, өвөрмөц онцлог бүхий боловсруулалт, шинжилгээний арга зүй, аргачлалтай байдаг. *“Тоон мэдээлэл цуглуулан боловсруулах, нэгтгэх нь статистикийн зөвхөн нэг хэсэг”*.

Статистикийн аргыг гүйцэтгэх үүргийг нь харгалзан боловсруулалт, шинжилгээний гэсэн хоёр бүлэгт хуваадаг.

Хүснэгт.1. Боловсруулалт, дүн шинжилгээний аргын бүлэглэл

Боловсруулалтын арга:	Дүн шинжилгээний арга:
<ul style="list-style-type: none"> • Тоо мэдээллийг бүлэглэлт, товчоололт хийх; • Тархалтын цуваа байгуулах; • Статистик хүснэгт зохиох; • График дүрслэлээр илэрхийлэх; • Үзүүлэлтүүдийг харьцуулах, зэрэгцүүлэх; • Дундажлах, нийлбэрийг тооцох; • Үзүүлэлтүүдийн хэлбэлзлийг тооцох гэх мэт. 	<ul style="list-style-type: none"> • Динамик эгнээний шинжилгээ; • Корреляцийн шинжилгээ; • Регрессийн шинжилгээ; • Түүвэр судалгааны арга; • Дисперси; • Индекс; • Магадал таамаглал дэвшүүлэх гэх мэт.

Үүнээс гадна статистикийн арга техникүүдийг дүрслэн тодорхойлох статистик (Descriptive statistics) ба шинжилгээний статистик (Inferential statistics) гэж ч нэрлэгдэг тал бий.

Тоон мэдээллийг бүлэглэлт, товчоололт хийх, тархалтын цуваа байгуулах, статистик хүснэгт, график дүрслэлээр илэрхийлэх, харьцуулах, зэрэгцүүлэх, дундажлах, хэлбэлзэл тооцох аргуудыг статистикийн боловсруулалтын бүлэгт хамруулна. Дүрслэн тодорхойлох статистик аргуудад статистик боловсруулалтын энгийн аргууд, тухайлбал, тоо мэдээ цуглуулах, цуглуулсан мэдээллээ цэгцлэн бүртгэх, тархалтын цуваа байгуулах, нэгтгэх, хүснэгт, график, гистограм, хистограм хэлбэрээр илэрхийлэх, дундаж үзүүлэлтийг тооцох зэрэг арга байдаг.

Харин дүн шинжилгээ анализийн аргуудад боловсруулалтын аргаас илүү өндөр түвшиний статистик аргуудыг хэрэглэн зохих дүн шинжилгээнд үндэслэн логик оюун дүгнэлтийг гаргадаг. Энэ аргын бүлэгт боловсруулсан тоо мэдээллээ ашиглан индекс, түүвэр судалгааны арга, динамик эгнээний, дисперси, нөлөөлж буй хүчин зүйлсийн корреляци, регрессийн шинжилгээ, магадал таамаглал дэвшүүлэх зэрэг арга багтана.

Мөн статистикийн хэрэглээ 1) тойм (дескриптив) статистик¹², 2) нарийвчилсан (Inferential) статистик¹³ гэж хоёр ангилдаг.

⁹ Статистикийн ерөнхий онолд статистикийн судалгаа, шинжилгээний ерөнхий онол, арга зүй, аргачлал, зарчим, статистикийн ерөнхий үзүүлэлтүүдийг боловсруулах асуудал хамаардаг.

¹⁰ Эдийн засгийн статистик бол улс орны эдийн засгийн байдлыг тусгаж байгаа үзүүлэлтийг боловсруулан шинэчлэх, салбар хоорондын харилцан хамаарал, үйлдвэрлэл, материал, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн бэлэн байгаа нөөц, зарцуулалт, ашиглалтын байдал, үр дүнг судалдаг.

¹¹ Нийгмийн статистик буюу салбарын статистикт тээвэр, холбоо, хүн ам, соёл, боловсрол, эрүүл мэнд, шүүх, гэмт хэргийн статистик гэх зэрэг орно.

¹² Тоо мэдээллийг цуглуулах, зохион байгуулах, илтгэх, дүгнэх зорилготой байдаг,

¹³ Түүврийн тусламжтайгаар эх олонлогийн талаар дүгнэлт гаргах, мэдэгдэхгүй байгаа параметруудийг үнэлэх, дүгнэлт өгөх, шийдвэр гаргах

Статистикийн юмс, үзэгдэл нь статистикийн хэмжигдэхүүнээр тодорхойлогддог. Статистикийн хэмжигдэхүүн гэдэг нь судлагдаж буй юмс, үзэгдлийн шинж чанарын “тоон үнэлгээ” юм. Статистикийн үзүүлэлтийн тусламжтайгаар судлагдаж байгаа үзэгдлийн цар хэмжээ, тэдгээрийн харилцан уялдаа хамаарал, өөрчлөлтийн зүй тогтлыг тодорхойлдог. Гэмт хэргийн тоон үзүүлэлт бол гэмт хэргийн статистикийн хэмжигдэхүүн гэж ойлгож болно.

Санамсаргүй буюу болгоомжгүй, тохиолдлын байдлаар илэрч байгаа нэгжүүдээс бүрдэх адил чанарын юмс, үзэгдлийн нийлбэр хэмжээг статистик олонлог гэдэг. Тэгвэл санаатай болон болгоомжгүй үйлдэгдсэн гэмт хэргүүдийн нийлбэр хэмжээ нь гэмт явдлын олонлог болдог. Олонлогийн аль нэг тогтвортой байдлаар илрэх шинж байдал буюу мөн чанарыг статистикийн зүй тогтол гэнэ. Статистикийн олонлогийг бүрдүүлж байгаа нэгж бүр тодорхой агуулга бүхий мөн чанартай, төрх байдлыг харуулсан нийтлэг үзүүлэлтүүдийг статистикийн онолд шинж тэмдэг гэж нэрлэдэг. Бүх төрлийн шинж тэмдгүүдийг тооны болон чанарын шинж тэмдэг гэж нэрлэдэг. Шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан төлөвлөсөн тодорхой программын үндсэн дээр зохион байгуулалттайгаар тоо мэдээллийг цуглуулах ажлыг статистик ажиглалт гэдэг. Тухайлбал, Гэмт хэргийн байдлыг статистикийн аргаар судлан боловсруулахын тулд урьдчилан төлөвлөсөн тодорхой программын дагуу зохион байгуулалттайгаар гэмт хэргийн талаарх тоо мэдээллийг цуглуулах үйл ажиллагааг статистик ажиглалт гэж ойлгож болно. Статистик ажиглалт явуулан гэмт хэргийн тоо мэдээллийг цуглуулах дөрвөн үндсэн арга хэрэглэдэг. Энэ нь шууд биечлэн бүртгэх, баримтын арга, асуулгын арга, анкетын арга гэж хуваадаг.

Хууль зүйн судалгаанд хэрэглэгдэж буй аргууд бол социологийн судалгааны үндсэн аргууд ашиглаж мэдээлэл цуглуулдаг. Харин судалгаа хийснээр хэрэгцээт үр дүнгээ гаргаж авахын тулд цуглуулсан мэдээллийг боловсруулах, улмаар дүн шинжилгээ хийхэд математик статистикийн аргыг судлаач бид ашигладаг гэдгийг санахад илүүдэхгүй. Үүгээрээ хууль зүйн судалгаанд ашиглагдах социологи, математик, статистикийн аргын ялгаа, онцлог харагддаг.

Статистикийн програм ашиглах нь

Орчин үед мэдээллийн технологи, компьютер, техникийг өргөн хэрэглэх болсонтой холбогдож статистикийн хөгжил дэх математик, статистикийн хэрэглээ улам нэмэгдэж, техник үйл ажиллагааг хөнгөвчилж, програмчлагдаж байна. Математик статистикийн аргыг програмчлалд оруулсанаар их хэмжээний өгөгдлийг боловсруулах, түүнд дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа судлаачдад боломжийг бий болгодог.

Хууль зүйн судалгаанд статистикийн аргыг хэрэглэх, тодруулбал санал асуулгын үр дүнг шивэх, үр дүнг нэгтгэх, боловсруулахад EViews¹⁴, CSPRO, SPSS¹⁵, Stata¹⁶ зэрэг программыг өргөнөөр ашигладаг.

Ялангуяа санал асуулга, түүврийн судалгааны үр дүнг нэгтгэхэд статистикийн дүн шинжилгээний аргыг хэрэглэхэд эдгээр программ чухал ач холбогдолтой, хууль зүйн судалгаанд өргөнөөр ашиглах боломжтой.

Хууль зүй, эрүүгийн эрх зүйн статистикийн ойлголт, практик

¹⁴ EViews програм нь Econometric Views гэсэн үгний товчлол бөгөөд эконометрикийн судалгаа, шинжилгээг хийхэд зориулагдсан програм юм. Бусад шинжилгээний програмын адил тооцооллыг хийдэг ч өөрийн гэсэн давуу талтай байдаг. Орчин үед өргөн ашиглагдаж байгаа судалгааны тоон болон чанарын өгөгдлийг боловсруулах MSEXcel, dBase, SAS, TSP, SPSS зэрэг програмын файлд буй өгөгдлийг ашиглан шинжилгээг хийх боломжийг олгодог. Товчоор хэлбэл, эдгээр програмд нийтлэг тооцогддог ерөнхий статистик үзүүлэлт гэх мэтээс гадна илүү өндөр түвшний регрессийн болон симуляцийн шинжилгээг кросс секшон, хугацааны цуваа, панел тоо мэдээнд тулгуурлан хялбар хийх боломжтой. Програмын талаар илүү дэлгэрэнгүйг <http://eviews.com> хаягаар орж авах боломжтой.

¹⁵ SPSS програмын гол давуу тал нь нийгэм хүмүүнлэгийн ухааны судлаачдад зориулагдсан учир хэрэглэхэд хялбар (SPSS -нь Statistical Packages for Social Science гэсэн үгний товчлол), Windows-ын орчинд ажилладаг болсон (SPSS 7.0 –оос эхлээд), Windows-ын орчинд ажилладаг бусад программтай цонхны бүтэц, үндсэн үйлдлүүд нь ижил, өгөгдлийн сантай ажилладаг ихэнх програмтай мэдээлэл солилцох өргөн боломжтой байдаг оршино.

¹⁶ Stata програм нь StatCorp компанийн бүтээгдэхүүн бөгөөд статистик болон график арга ашиглан тоо мэдээг шинжлэх зориулалт бүхий програм юм. Компаний зүгээс програмыг бүхий л төрлийн шинжилгээ судалгаанд маш тохиромжтой гэдэг боловч судлаачдын зүгээс статистикийн шинжилгээ, микро эконометрик, түүвэр судалгааны өгөгдлийг боловсруулах зэрэгт тохиромжтой гэж үздэг.

Олон улсын практикаас үзэхэд хууль зүйн статистикийг эрүүгийн, шүүхийн, иргэний, захиргааны эрх зүйн статистик гэж ангилдаг.

Хууль зүйн статистикийг ОХУ-д ёс суртахууны статистик, эрх зүйн статистик, Англи улсад шүүхийн статистик, барууны орнууд, Америкт гэмт хэрэг, эрүүгийн эрх зүй, шударга ёсны (crime statistics, criminal justice statistics) статистик гэж ангилдаг. Харин Монгол Улсын хувьд эрүүгийн тоо бүртгэл, шүүхийн статистик, эрүүгийн хэргийн статистик гэх мэтээр нэрлэж ирсэн байдаг.

Криминологийн шинжлэх ухааны хөгжилтэй зэрэгцэн эрүүгийн буюу гэмт хэргийн тоо бүртгэл 1966 оноос хөтлөгдөж, албан ёсны статистик мэдээлэл гарч, нийтэд танилцуулагдаж эхэлсэн байна. Үүнээс өмнө гэмт хэргийн тоон мэдээллийг нууцалдаг байсан холбоотой.

Монгол Улсын өнөөгийн практик, туршлагаас үзэхэд байгууллагаар нь 1) цагдаагийн статистик, 2) прокурорын статистик, 3) шүүхийн статистик, 4) шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн статистик, 5) шүүхийн шинжилгээний статистик гэж ангилж болно.

Монгол Улсад хууль зүйн статистикийн илүү өргөн хүрээнд судлан үзэх шаардлага өсөн нэмэгдэж байгаа ба эрүүгийн буюу гэмт хэргийн статистикийг нарийвчлан судлах ажил хийгдэж байна.

Хууль зүйн судалгаа хийхэд статистикийн мэдээлэл цуглуулж авах асуудал

Хууль зүйн судалгаанд статистикийг ашиглахад эхний ээлжинд мэдээлэл цуглуулах ажил чухал байдаг. Хууль зүйн аливаа төрлийн судалгаанд тоон мэдээллийг цуглуулахын тулд Үндэсний статистикийн хорооноос гаргадаг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг цаасаар болон цахим хэлбэрээр авч ашиглах боломжтой. Түүнчлэн, тухайн судалгаанд шаардлагатай Улсын Их Хурал, Засгийн газар, яамд, шүүх, прокурор, авлигатай тэмцэх, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээ, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо, бусад салбар, яам, агентлаг, нутаг дэвсгэрийн байгууллага, төрийн бус, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны тоон үр дүнгүүдийг авч ашиглаж болно.

Статистикийн мэдээллийг www.1212.mn, www.nso.mn, www.ubstat.mn болон холбогдох байгууллагуудын цахим хуудсаас авахаас гадна Үндэсний статистикийн хорооны сар бүрийн танилцуулга, улирал тутмын статистикийн мэдээлэл, жил бүрийн эмхэтгэл зэргийг ашиглах боломжтой.

Хууль зүйн судалгаан дахь статистикийн аргын хэрэглээ

Хамгийн эхэнд хууль зүйн судалгаанд шаардлагатай бүхий л тоон мэдээллийг цуглуулж авах ёстой. Үүний дараа цуглуулсан мэдээллийг бүлэглэн ангилах, судалгааны үр дүнг гаргахад хэрэгтэй байдлаар боловсруулалт хийх шаардлагатай. Өөрөөр хэлбэл өмнө дурьдсан статистикийн боловсруулалтын бүлэглэлт, товчоололт, статистик хүснэгт зохиох, график дүрслэл хийх, дундаж, нийлбэр, хэлбэлзлийн үзүүлэлтийг тооцох зэрэг аргыг өргөнөөр ашиглах нь зүйтэй.

Хоёрдугаарт, боловсруулсан дээрх мэдээллээ өөрийн судалгааны ажилд шууд ашиглаж болохоос гадна зарим санал, шийдэл гаргахад шаардлагатай нарийвчилсан дүн шинжилгээ хийх шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд статистикийн дүн шинжилгээний динамик эгнээний шинжилгээ, ирээдүйн төлөвийг прогнзочлох, корреляци, регресс, дисперс, индекс, түүврийн зэрэг арга ашиглах шаардлага үүснэ.

Хууль зүйн салбар эрдэмтэн, судлаач, практикийн ажилтнууд боловсруулалтын аргыг судалгааны ажилдаа зохих түвшинд ашигладаг. Харин статистикийн дүн шинжилгээний аргуудыг төдийлөн ашиглаж чадахгүй байна. Иймд хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачдад чиглэсэн энэ чиглэлийн сургалтыг явуулах, тэднийг чадавхжуулах ажлыг зохион байгуулах шаардлага байгаа нь ажиглагддаг.

Гуравдугаарт хууль зүйн салбарт шаардлагатай “тоон мэдээлэл” цуглуулахаас гадна түүврийн судалгаа, чанарын судалгааг явуулахад статистикийн аргыг өргөнөөр ашигладаг. Ингэхдээ CSPRO, STATA, SPSS, EVIEWS зэрэг програм хангамжийг хослуулан хэрэглэж байна. Тухайлбал, анкетаар авсан судалгааг шивэх, үр дүнг нэгтгэх, мөн гэмт хэргийг ажиглалтын аргаар тодорхой маягтын дагуу бүртгэж, улсын хэмжээнд нэгдсэн статистик гаргах зэргээр ашиглаж байна.

Хууль зүйн судалгаанд хэрэглэх үзүүлэлт тооцоолох зарим аргачлал

1. Хувь болон пунктийн ялгаа

Пункт: Гэмт хэргийн илрүүлэлт 2016 онд 60.5%, 2017 онд 64.5% болж нэмэгдсэн бол гэмт хэргийн илрүүлэлт $64.5 - 60.5 = 4.0$ пунктээр нэмэгдсэн гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хувийн абсолют өсөлт, бууралтыг пунктээр илэрхийлдэг.

Хувь: Дундаж наслалт 70-аас 77 болж 10 хувиар өссөн.

Гэмт хэргийн талаарх коэффициентээр илэрхийлэгдсэн тоон үзүүлэлтийн өсөлт, бууралтыг “хувь”-аар илэрхийлдэг бол хувиар илэрхийлсэн тоон үзүүлэлтийн өсөлт, бууралтыг “пункт”-ээр илэрхийлэн тооцоолдог.

2. Хүн амд ногдох гэмт хэрэг

Гадаадын ихэнх орон улс орныхоо эрүүгийн нөхцөл байдлыг үнэлэх дүгнэх, мөн бусад оронтой харьцуулах үүднээс нэг сая, 100000, 10000, 1000 хүн амд ногдох гэмт хэргийн тоог гарган, нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгдөг.

Гэмт хэргийн тархалтыг аймаг, дүүрэг, салбарын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог хот, сум, хороодоор задлан илэрхийлж, мөн 10000, 1000 хүн амд ногдох гэмт хэргийн тоогоор илэрхийлж байгаа нь гэмт хэргийн гаралтыг газар нутгаар хэрхэн тархаж үйлдэгдсэнийг харуулж буй үзүүлэлт.

Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг үндэслэн 16 ба 18-аас дээш насны хүн амд ногдох гэмт хэргийн тархалтыг тооцох нь оновчтой.

$$K = \frac{\text{Гэмт хэргийн тоо}}{16,18\text{-аас дээш насны хүн ам}} * 100.000 \quad (\text{Томьёо.1})$$

Гэмт хэргээс гадна тухайн байгууллагын алба хаагчдын дунд эзлэх сахилга, ёс зүйн зөрчил, хүүхдэд ногдох хүчирхийллийн тоо гэх мэтээр энэ аргачлалыг ашиглан гаргах боломжтой. Энэ нь аливаа үзэгдлийн тоон түвшинг чанарын үзүүлэлт болгон ашиглах давуу талыг олгодог.

3. Эрүүгийн хууль дах математик хэрэглээ: Хорих ялыг дүйцүүлэн хасаж тооцох жишээн дээр

Хууль зүйн шинжлэх ухаанд математикийн арга хэрэглэж байдлыг тодорхой жишээн дээр тайлбарлаж оруулья. 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн 1.9-д “...оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ” гэж заасны дагуу хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлал боловсруулсан.

Аргачлалын үндсэн томьёо:

X_1 –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	Y_1 –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
X_2 –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	Y_2 –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ
$\Delta X = X_2 - X_1$ –Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын интервал	$\Delta Y = Y_2 - Y_1$ –Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын интервал

Дээрх хувьсагчаар илэрхийлсэн үзүүлэлтүүдийг ашиглан хуучин ЭХ-ийн хорих ялын нэгж хэмжээнд харгалзах шинэ ЭХ-ийн хорих ялын хэмжээг илэрхийлэх хорих ял дүйцүүлэх коэффициентийг гаргана:

$$K = \frac{\Delta Y}{\Delta X} = \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} \quad (\text{Томьёо.2})$$

X^* –Тухайн ялтанд хуучин ЭХ-иар оногдуулсан хорих ял

Y^* –Шинэ ЭХ-иар буурах хорих ял

Шинэ Эрүүгийн хуулиар ялтны хорих ялын хэмжээ хэрхэн буурахыг томьёо.3-ыг ашиглан бодно.

$$Y^* = Y_1 + K * (X^* - X_1) = Y_1 + \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} * (X^* - X_1) \quad (\text{Томьёо.2})$$

Хуучин, шинэ ЭХ-иар хорих ялын доод, дээд хэмжээ өөрчлөгдсөн байдаг учраас 4 тохиолдолд томьёо.3-ыг ашиглан ялын хэмжээг бууруулна. ЭХ-ийг буцаан хэрэглэхэд ялтны эрх зүйн байдлыг дордуулахгүй ба харин дээрдүүлэх байдлаар үзүүлэлтийг ашиглана. Хуучин ЭХ-ийн ялын доод хэмжээнээс бага ял оногдуулсан тохиолдолд хуучин, шинэ ЭХ-ийн ялын өөрчлөлтийн коэффициентийг ашиглан шинэ ЭХ-ийн ялын доод хэмжээг олж тооцож бодно. Мөн тооцоолол хийхдээ хуучин ЭХ-ийн хуулийн ялын доод хэмжээг түүнээс багаар оногдуулсан ялын хэмжээгээр авна. Тохиолдол 1, 2, 3 дээр мөн адил бодогдоно.

Энэ нь шударга ёсыг тогтоох, хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд математик, статистикийн аргачлалыг хэрэглэх оролдлого хийсэн нь хууль зүй, криминологийн шинжлэх ухааны салбарт судалгааны арга зүй нэвтрүүлж, хуулийн практикт шинэ хэрэглээг оруулж байгаагаар онцлог.

Эрүүгийн хуулийн буцаан хэрэглэхэд “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга, энэрэнгүй ёсны” зарчмыг чанд баримтлахын тулд математик статистикийн аргачлалыг хэрэглэсэн. Өөрөөр хэлбэл, ойролцоо ялтай ялтнуудын нэг ялтны ял их хэмжээгээр, нөгөө нь бага хэмжээгээр хасагдах бус, зүй нь ихээс их, багаас бага ял хасагдах буюу математикийн их тооны хуулийн зарчмаар хасагдах ёстой гэсэн үг. Өмнө нь хэрэглэж байсныг аргуудаас сайжруулж, оновчтой болгож, математик загварт оруулсан.

Энэхүү аргачлалыг боловсронгуй болгох, шүүмжлэх талаар эрдэмтэн, судлаач, практикийн ажилтнууд судлах нь нээлттэй юм. Эрүүгийн хууль шинэчлэгдсэн тохиолдолд ялтны хорих ялыг дүйцүүлэн хасахад энэхүү математик статистикийн аргачлалыг бүх шатны шүүхэд нэг мөр ойлгож хэрэглэх, улмаар өршөөл үзүүлэх, уучлал үзүүлэхэд энэ төрлийн аргачлалыг хэрэглэх боломжийг дахин судлах, практикт хэрэглэх явдлыг стандарт болгон оруулах шаардлага байгааг үгүйсгэхгүй.

Дээрх аргачлалтай төстэй байдлаар математик статистикийн аргыг хууль зүйн судалгаанд ашиглах шинэ хувилбаруудыг бий болгох, турших нь судлаачдын хувьд нээлттэй.

Дүгнэлт

Олон улсын туршлагаа суралцан манай эрдэмтэн, судлаачид нийгэм, хууль зүйн шинжлэх ухааны хийсвэр ойлголтыг математик, статистикийн арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийх шинэ хандлага бий болгох эхлэлийг тавих идэвх гарган ажиллаж байгаа нь зарим докторын судалгааны ажил, мөн суурь, хавсарга, хэрэглээ, бодлогын судалгааны ажлуудаас ажиглагдаж байна.

Хууль зүйн салбарын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын профессор, багш, судлаачид судалгаанд суурилсан олон улсын шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх, бодлогын ажил гүйцэтгэхэд судалгааны арга зүйн мэдлэг, чадварыг бүрэн эзэмшсэн байхыг шаардаж байна.

Ялангуяа математик статистикийн аргыг ашиглан судалгааны үр дүнг боловсруулах, түүнд дүн шинжилгээ анализ хийж, дэвшүүлсэн таамаглалаа шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон, дүгнэлт, санал, зөвлөмж, шийдлээ дэвшүүлэх нь онолын болон практикийн чухал ач холбогдолтой.

Зөвлөмж

Хууль зүйн судалгаа хийж ихэнх судлаачид социологийн судалгааны үндсэн аргууд ашиглан мэдээлэл цуглуулж, улмаар үр дүнгээ математик статистикийн арга, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан хэрэгцээт үр дүнгээ гарган авдаг. Иймд судалгааны арга зүй хэсэгт зөвхөн социологийн анкет, асуулга, баримт бичигийн зэрэг аргуудыг дурьдахаас гадна математик статистикийн арга ашигласанаа дурьдаж хэвших нь зүйтэй.

Түүнчлэн, хууль зүйн судалгаанд шаардлагатай чанарын судалгаануудаас гадна тоон мэдээллийн цуглуулж, боловсруулалт, дүн шинжилгээ хийхэд математик статистикийн аргуудыг ашиглаж байх нь судалгааны ажлыг шинжлэх ухааны үндэстэй, чанартай, бодитой болгоно.

Ашигласан ном зүй

1. Ч.Авдай, Д.Энхтуяа, Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй. УБ., 2015
2. Я.Баатар, Д.Тархаашин, Гэмт хэрэг судлах статистикийн арга зүй. УБ., 1988

3. Ц.Баатартогтох, Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй, УБ., 2012
4. Я.Базарсад, Р.Энхбат. Магадлалын онол, математик статистикийн гарын авлага. УБ., 2002
5. Л.Дуламсүрэн. Статистикийн онол, УБ., 1980
6. Н.Жанцан, Криминологи. УБ., 2000, 2004
7. С.Жанцан. Гэмт явдал судлал. УБ., 1995
8. С.Жанцан, П.Ихзаяа, Б.Мөнхдорж, Гэмт хэргийн статистик. УБ., 2007
9. П.Жасрай. Эдийн засгийн мэдээлэл шинжилгээ. УБ., 2004
10. П.Ихзаяа, Б.Энхболд. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны албаны түүхэн замнал танилцуулга. УБ., 2007
11. Ч.Наранчимэг, Д.Ганзориг. Бизнесийн статистик. УБ., 2008
12. Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистикийн судалгааны арга, аргачлал. УБ., 2004
13. Б.Мөнхдорж, А.Түвшинтулга. Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал, эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2017
14. Р.Оюунбилэг. Математик статистик. УБ., 2009
15. Т.Сэнгэдорж. Хууль зүйн шинжлэх ухаан: Судалгааны арга зүй. УБ., 2001
16. Т.Сэнгэдорж. Хууль зүйн шинжлэх ухаан (Судалгааны арга зүй). УБ., 2015
17. Д.Таванжин. Монгол Улсын цагдаагийн эрх зүйн лавлах толь. УБ., 2008
18. С.Төмөр-Очир. Нийгмийн судалгаа, шинжилгээнд математик арга хэрэглэх онол, арга зүйн асуудал. УБ., 2012
19. Д.Цэвээннамжил, Я.Эрдэнэсүрэн. Статистикийн онол-II. УБ., 2016
20. Ө.Цэрэн, До.Нямсүрэн. Магадлалын онол, математик статистик. УБ., 2012
21. Д.Чимгээ. SPSS нийгмийн статистикийн шинжилгээ хийх, үр дүнг тайлбарлах нь. УБ., 2014
22. Ц.Цэрэндорж, Г.Элдэв-Очир, С.Хандсүрэн, Ч.Даваасүрэн, Г.Цагаач. Статистикийн онол. УБ., 2005
23. Үндэсний статистикийн хороо. Эдийн засгийн статистикийн аргачлалууд. Цуврал-II. УБ., 2011
24. Үндэсний статистикийн хороо. Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх гарын авлага. УБ., 2017
25. Блувштейн Юрий Давыдович, Криминология и математика, Москва., 1974
26. Лудеев.В.В, Юридическая статистика, Москва., 1999
27. Савюк.Л.К, Правовая статистика, Москва., 2003
28. R. A. Carr-Hill Crime, The police and criminal statistics, 1979
29. DeGroot, Morris H. Statistics and the law, 1986
30. Finkelstein, Michael O. Quantitative methods in law, 1978
31. Fararo, Thomas J. Mathematical ideas and sociological theory, 1984
32. Bachman, Ronet Statistics for criminology and criminal justice, 2004
33. Walker, Jeffery T. Statistics in criminology and criminal justice, 2005
34. David Weisburd, Statistics in Criminal Justice, 2007
35. С.Цэндбаатар. Гэмт явдлын статистикт математикийн арга хэрэглэх нь, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2004.№01;
36. Т.Ёндон. Эдийн засаг ба хуулийн математик. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2010.№01;
37. Б.Мөнхдорж. Монгол Улс дахь гэмт хэргийн статистик: Өнөөгийн байдал, түүнийг сайжруулах асуудал. “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2016 оны №04(59).
38. Б.Мөнхдорж. Гэмт хэргийн статистик зүйн онол, практикийн тулгамдсан асуудал. “Шинжлэх Ухааны Академийн Мэдээ” сэтгүүл (өгүүлэл реер review буюу хянан магадлагаа хийгдэн нийтлэгдэж, онлайн өгүүлэлд DOI:<http://dx.doi.org/10.5564/pmas.v57i221.758> дугаар олгогдсон). 2017.№01(221).
39. Б.Мөнхдорж. 2017 онд БСШУСЯ, ШУТС, МЗЭХ, НШУЭХ, НЗХГ-аас 12 дах жилдээ зохион байгуулсан “Хүрэл тогоот-2017” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн “Хорих ялыг дүйцүүлэн хасаж тооцоход математик статистикийн аргачлал ашигласан нь” сэдэвт илтгэл.

МОНГОЛ УЛСЫН ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИКИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, УЛАМЖЛАЛ

Б.Мягмарсүрэн

*ЦЕГ-ын Төв архивын тусгай сангийн архивч, цагдаагийн ахлагч,
ХСИС-ийн магистрант*

Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийн түүхэн уламжлалын талаар авч үзэхээс өмнө статистикийн шинжлэх ухаан, түүний үүсэл хөгжлийн талаар товч авч үзэх нь зүйтэй болов уу.

Шинжлэх ухаанд статистик гэдэг нэр томъёог анх Немцийн эрдэмтэн Готфрид Ахенваль 1746 онд оруулжээ. Статистикийн хэл нь “тоо” юм. Статистикийн онцлог нь нийгмийн олон талт үзэгдлийг тоогоор илэрхийлдэгт оршино. Статистик хэмээх нэр томъёо Латины status (статус) гэдэг үгнээс гаралтай бөгөөд юмс үзэгдлийн төлөв байдал гэсэн утгатай. Энэ үгний үндэснээс Итали хэлний stato (Стато) буюу улс гэдэг үг үүсч гарсан байна. Төр улсын бүтэц, үйл ажиллагааны тухай өргөн дэлгэр мэдлэгтэй хүмүүс буюу төрийн зүтгэлтнийг statista (статиста) гэж нэрлэдэг байжээ. Үүнээс statistica (статистика) хэмээх нэр үг үүсжээ. Статистик гэдгийг амьдрал практикт хүн ам, эдийн засаг, боловсрол, соёл болон нийгмийн олон талт үзэгдлийн тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хий, олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа гэж ойлгож хэрэгслээр ирсэн байна.

Олон улс орнуудад бүртгэл статистикийн хөгжлийн түүх нь гол төлөв хүн амын статистикийн түүхээс эхтэй байдаг байна. Үүнээс үзэхэд статистик нь амьдралын зайлшгүй шаардлагаас урган гарсан бололтой. Эртний улс орнууд улс төр, аж ахуй, цэрэг дайны зориулалттайгаар тооллого явуулдаг байжээ. Эртний Египет, Вавилон, Грек, Ромд хүн амын бүртгэлийн хамрах хүрээ хязгаарлагдмал, хүн амын зөвхөн тодорхой хэсгийг тооцдог байжээ. Эртний Египетэд гэхэд эмэгтэйчүүд, хүүхэд, боолчуудыг бүртгэдэггүй байв. Харин ХҮIII зууны дунд үеэс хүн амыг бүртгэх сонирхол нэмэгдэж, Европын орнууд, Ази, Америк хүн амаа бүртгэж эхэлжээ. Америкийн Нэгдсэн Улс (АНУ), 1790 оноос, Швед, Финланд 1800 оноос, Дани, Норвег, Франц 1801 оноос хүн амын тооллогыг тогтмол явуулж иржээ.

Олон зуун жилийн туршид статистик бие даасан шинжлэх ухаан болтлоо хөгжиж, нийгмийн олон үзэгдлийг судлах болжээ. Философчид, математикчид, эдийн засагчид, нийгэм судлаачид, улс төрийн зүтгэлтнүүд, түүний дотор статистикчид шинжлэх ухааны тодорхойлолтыг буй болгон хэрэглэсээр иржээ. Орчин үед статистикийн мянга орчим тодорхойлолт байдаг аж. ХҮII зууны дунд үеэс статистик нь шинжлэх ухаан болж хөгжсөн гэж үздэг Статистикийн шинжлэх ухаан нь эхлээд хоёр үндсэн сургалт (арга барил)-аар хөгжиж ирсэн түүхтэй.¹⁷

Английн улс төрийн арифметикийн сургалт (арга барил)

Германы тодорхойлон бичих сургалт (арга барил)

Английн улс төрийн арифметикийн шинжлэх ухааны сургалт нь нийгмийн үзэгдэл юмсыг тооны шинж чанарын тусламжтайгаар судалдаг. Судалгааны гол арга нь статистикийн аргууд, онолын статистик байв.

Германы тодорхойлон бичих сургалт нь гол төлөв тоогүйгээр үгээр илэрхийлдэг, динамик байхгүй үзэгдэл юмсын хоорондын холбоо хамаарлыг онцлон үздэггүй байсан аж. Харин XIX зууны дунд үеэс статистикийн шинжлэх ухааны гурав дахь чиглэл, **математик-статистик** буй болжээ. Энэ аргыг Бельгийн статистикч Адольф Кетле үндэслэсэн. Энэ хүн дундаж хэмжигдэхүүний тухай ойлголтыг анх тодорхойлжээ. XIX зуунд статистикийн арга зүй улам боловсронгуй болж Английн эрдэмтэн Ф.Гальтон, О.Пирсон, М.Митчел нар үзэгдэл юмсын харилцан хамаарал-корреляцийн аргыг боловсруулжээ. XX зуун гарсаар нийгэм, эдийн засгийн судалгаанд бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ, чанарын харилцан хамаарлыг судлах магадлалын онол, хэрэглээний математикийн салбар буй болсон ажээ.

¹⁷ Ц.Бадрах, Х.Бажийхүү. Монгол Улсын бүртгэл статистикийн үүсэл хөгжил.2014 он.

Аливаа улс оронд статистик үүсэх үндсэн нөхцөл нь цэрэг дайны зориулалтаар хүн ам, газар тариалангын ургац, эд хөрөнгийн бүртгэл тооллого явуулж байсан талаар дээр өгүүлсэнтэй адил бидний өвөг Хүннү нар ч гэсэн хүн ам, мал тооллого явуулж байсан байна. “МТӨ 174-163 он Хүн гүрэн Лаошань шаньюин үед улсын албан татварыг цэгцтэй болгож хүн амын тооллого хийв”, “Хүн улс хүн ам, малаа нас дээшлүүлэх тооллогоо Есдүгээр сарын нохой өдөр Дайлан (Тайлга тархилга хийх)-д хуралдахаа цэгцэлдэг байжээ. “Хүн (Хүннү) гүрний үед хүн ам 1.5-2.0 сая”, МТӨ 72 онд Хүн гүрний мал нь нэг хүнд 19 толгой ногдоно гэсэн тооцоо байдгаар 1,2-1.5 сая хүнтэй гэж үзвэл 22.8-28.5 сая малтай байжээ¹⁸ гэж тэмдэглэжээ.

Хүннү гүрний үед хүн ам, цэрэг эрс, малын тоотой холбоотой олон баримт түүхэнд тэмдэглэгдэн үлдсэнээс үзэхэд Монголчууд МТӨ бүртгэл статистикийн талаар анхны мэдэгдэхүүнтэй төдийгүй хүн ам, малаа жил бүр тодорхой хугацаанд тоолдог, бүртгэл статистикийг амьдрал ахуйдаа хэрэглэж байсан аж.

Үүний сацуу гэмт хэргийн тоо бүртгэл, статистиктай холбоотой баримт зарим түүхийн эх сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ. Үүнд:

Хүннү гүрний иргэдийн авир нь догшин боловч улсын хэрэгтэн нь хэдэн арваас үл хэтэрнэ гэж Хятад түүхийн эх сурвалжид тэмдэглэн үлдээжээ.¹⁹

Эртний хятадын “Зүүн Хань улсын түүх” зохиолд Таньшихуай “хууль цааз хэрэглэн зөв бурууг шийдэж байсан бөгөөд зүрхлэн зөрчигчид байсангүй” гэсэн байдаг байна.²⁰

Монголын эзэнт гүрэн болон түүний дараачийн бага хаадын үеийн бүртгэл статистик нь хүн ам, мал тооллого төдийгөөр хязгаарлагдаж байсан гэвэл нэлээд өрөөсгөл болно. Түүхийн эх сурвалж бичгүүдэд тэмдэглэн үлдээснээс үзвэл гэмт хэрэг, газар тариалан түүгээрч барахгүй улсын сан хөмрөгийн нэгдсэн бүртгэлтэй байсан талаар тэмдэглэгдэн үлджээ.

1320-иод оны үеэр албан тариалан эрхлэх яамыг Монголд байгуулжээ. Тэр үед Монголд тариа тарих өрх 1618, тариалангийн хэмжээ 6400 илүү хуваарь газар байжээ.²¹

Чингисийн эзэнт гүрний үед хулгай, дээрмийн гэмт хэрэг бага байсан бололтой. Учир нь тэр үеийн түүхэн эх сурвалж, бичиг тэмдэглэлд эзэнт гүрэнд шорон гяндан, гэмт хэрэгтэн байсан тухай гэмт хэрэгтнийг шүүсэн тухай ямар нэгэн тэмдэглэл байхгүй хэдийч Монголын нууц товчоонд хулгайн шинжтэй гурван тохиолдлыг тэмдэглэсэн байна.²²

Энэ мэт төв Азийн нүүдэлчид үүний дотор одоогийн Монгол улсын нутагт хамаарах хэсэгт амьдарч байсан овог аймгууд хүн ам, мал, газар тариалан, худалдаа болон гэмт хэргийн статистикийн хөгжил нь нэн эртний уламжлалтай байсныг харуулж байна.

Мөн 1820-1913 он хүртэл буюу 93 жилийн турш шийдсэн хэргүүдийн түүвэр болох “Улаан хацарт” хэмээх бүтээл шүүхийн түүхэнд онцгой байр эзэлдэг.²³ Улаан хацарт нь Их шавийн яамнаас таслан шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны гэж ангилж болохуйц эрх зүйн зөрчил гэж үзсэн үйлдлийг эрх бүхий албан тушаалтнаас шийтгэсэн эрх зүйн зөрчлийг нэгтгэсэн бүртгэл данс, дүрэм юм. Улаан хацартад манжийн Төр гэрэлт, Түгээмэл элбэгт, Бүрэн засагч, Бадаргуулт төр, Хэвт ёс хааны он тооллоос гадна, Хаант Монголын “Олноо өргөгдсөн” он тооллыг тус тус тэмдэглэсэн нь уг хэрэг шийтгэсэн дансыг нэг бол 1913 оноос хойш эмхтгэсэн эсвэл 1821 оноос эхэлж 1913 онд сүүлийн хэргийг данслан бүртгэсэн байна. Улаан хацартад тэмдэглэсэн эрх зүйн зөрчлүүдийг “Шавь яам”-д хэлэлцсэн болохыг дансны агуулгаас нь тодорхой мэдэж болох бөгөөд уг эх сурвалжид бурхны шашны зэрэг дэв, сүм хийдийн албан тушаалтан, сахил санваартангуудтай холбоо бүхий, цөөн хэдэн тохиолдолд хошуу тамгын газрын ажилтан, шавийн харьяат энгийн иргэдтэй холбоотой эрх зүйн зөрчлүүдийг тэмдэглэсэн байна.

1912 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Богд хаант засгийн үеийн Шүүн таслах яамнаас битүү хулгайн зэрэг шийтгэн дууссан хэрэг ба хөнгөн ял оноосон, золио авч шийтгэсэн хэрэг буй, үгүйг жил бүрийн эцэст аль газарт мэдэгдэхийг заан тушаасан бичигт

¹⁸ (Энэ үеийн тоолол нь одоогийн билгийн тооллоос өөр, тухайлбал аргын тооллын 3 дугаар сарын 21-ний өдөр, шөнийн тэнцлээс хаврын улирал эхэлдэг хэмээн тооцвол есөн сар нь 11 сарын 20-оос 12 дугаар сарын 20-ны хоорондох нохой өдөр таарах ёстой). Б.Балжинням. Дэлхийн Монголчуудын түүх (дэд дэвтэр). УБ. 2012 он, 73, 100 дугаар тал

¹⁹ Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи. 2010 он

²⁰ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 19-р тал.

²¹ Монгол Улсын ШУА-ын түүхийн хүрээлэн. Монгол Улсын түүх. II боть., УБ, 2003 он. 245-р хуудас

²² Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи. 2010 он

²³ <http://supremecourt.mn/c/print/1>

“Эдүгэ нийслэл хүрээний эрдэнэ шанзудба нарын газраас Чин улсын тогтоосон хууль дүрмийг дагаж жил бүр харьяат шавийн дотор дөнгө золио авч шийтгэсэн хэрэг, буй үгүйг тодорхойлон байцааж жилийн эцэст хүрээний сайдуудын газар мэдүүлэх бөлгөө” гэсэн нь тухайн жил гарсан гэмт хэргийн тоо бүртгэлийн хөтлөн явуулж, дээд байгууллагадаа илгээдэг байсныг илтгэнэ.²⁴

Мөн 1913 оны намраас Бүгд ерөнхийлөн захирах яаманд төрийн бүх яамд улирал тутамд шийтгэж дууссан ба дуусаагүй хэргүүдийг ялган салгаж товчлон мэдүүлэх журам тогтоожээ.²⁵ Шүүн таслах яамнаас шийтгэж дууссан, дуусаагүй хэргүүдийг тодорхойлж бүгд ерөнхийлөн шийтгэх яамнаа өргөн илгээсэн бичигт “... Үүнд хянан байцааваас манай Шүүн таслах яамны энэ жил намар цагаас эхлэн аливаа хүнд хөнгөн хэрэг зүйлийг шийтгэн дууссан ба шийтгэн дуусаагүй нь бүрнээ ялган салгаж хураангуйлан сүүлд жагсаан бичиж, үүнийг олвоос бүгд ерөнхийлөн захирах яамнаа өргөн явуулаад байцаан үзүүлсүгэй. Үүний тулд өргөн илгээв. Олноо өргөгдсөний гуравдугаар он арван нэгэн сарын арван таван” гэжээ.²⁶

1921 онд ардын хувьсгалт цэрэг нийслэл хүрээг эзлэх үед улсын төв шорон, аймгийн шоронд арав хүрэхгүй тооны хорих ялтан байсан гэдэг.²⁷ Энэ нь шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын статистикийн талаарх чухал баримт, эх сурвалж болж байгаа юм.

Мөн 1928 оноос тухайн үеийн засан хүмүүжүүлэх байгууллагад, хоригдлын судалгаа, бүртгэлийн журмыг шинээр боловсруулан тогтоож, хэргийн үйлдлээр нь ангилан бүртгэх, түүний үндсэн дээр засан хүмүүжүүлэх ажлын арга барилыг нарийвчлан зохион байгуулж явахаар болсон байна.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны сайдын 1946 оны 08 дугаар сарын 05-ны өдөр “Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд хорих ангиудад хорих хоригдлын тоо бүртгэлийн ажлыг хэрхэн явуулах тухай дүрэм” баталжээ. Энэ үед тоо бүртгэлийн ажлыг гүйцэтгэх “тавдугаар” тасгаас удирдаж байсан бөгөөд хоригдлын тоо бүртгэл судлалын ажлыг үнэн зөв хөтлөх, зөв биелүүлэх нь хоригдлын тоо бүртгэл хөтлөлтөд чухал ач холбогдол болсон.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны сайдын 1951 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Хоригдлын тоо бүртгэлийн ажлыг сайжруулах тухай” 453 дугаар тушаалаар хоригдлын мэдээ бүртгэлийг тусгайлан бэлтгэсэн 7 төрлийн төрлийн маягтаар сар бүр мэдээ гаргаж “тавдугаар” тасагт ирүүлж байхаар тогтоож байжээ.

НАХЯ-ны сайдын 1969 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 50 дугаар тушаалаар “хоригдлын тоо бүртгэлийн ажлын зааврыг 28 төрлийн хавсралт, баталсан мөн НАХЯ-ны сайдын 1983 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 524 дүгээр тушаалаар “Хоригдлын тоо бүртгэлийн ажилд өөрчлөлт” мөн сайдын 1984 оны “Хоригдлын тоо бүртгэлийн заавар”-т оруулсан тушаал зэрэг эрхийн акт гарсан.

Дээрх баримтуудаас үзэхэд цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд тус тусдаа тоо бүртгэл хөтөлж байсан бөгөөд Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэл, судалгаа хийдэггүй байжээ.

Гэмт хэргийн тоо бүртгэлийн нэгж нь цагдаагийн байгууллага үүссэн үеэс анх бий болж 1967 оныг хүртэл бие даасан алба болон зохион байгуулагдахгүй бусад албаны харьяанд гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөн, түүний шалтгаан нөхцөлийг судлах, удирдлагыг мэдээллээр хангах үүрэгтэйгээр ажиллаж байсан байна.²⁸

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1965 оны 305 дугаар тогтоолд гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг улам сайжруулах, гэмт хэргийн гаралт, түүнд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүн гүнзгий судалж, эрүүгийн гэмт хэргийн болон урьдчилан сэргийлэх тоо бүртгэл хөтлөн, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах аппаратыг Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дэргэд байгуулахыг заасан нь энэ албыг бие даан хөгжих үндсийг тавьжээ.

²⁴ “Монголын шүүх” хууль тогтоомжийн эмхэтгэл I Боть. УБ хот., 2016 он 23 дахь тал

²⁵ Монголын шүүх” хууль тогтоомжийн эмхэтгэл I Боть. УБ хот., 2016 он 37 дахь тал

²⁶ Монгол Улсын шүүн таслах хэргийг Бүгд захиран шийтгэгч яам /Баримт бичгийн эмхэтгэл/1911-1921он. УБ хот.,2011 39-43 дахь тал

²⁷ Ж.Болдбаатар, О.Нямдаваа. Криминологи. 2010 он

²⁸ ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. “Түүхэн замнал” танилцуулга. УБ. 2007, 4 дэх тал

Сайд нарын зөвлөлийн 1966 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 422 дугаар тогтоолоор Улсын цагдан сэргийлэх ерөнхий газарт гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэл, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг хариуцах тоо бүртгэлийн тасгийг 1967 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн байгуулахыг НАХЯ-нд зөвшөөрснөөр энэ ажил эрхэлсэн тусгай тасгийг НАХЯ-ны Сайдын 1967 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Нэгдсэн тоо бүртгэлийн тасаг байгуулах тухай” 19 тоот тушаалаар бүгд 9 хүний орон тоотойгоор Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дэргэд байгуулснаар гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцлийн талаарх мэдээ тайланг Цагдан сэргийлэх ерөнхий газраас гаргаж, статистикийн байгууллага мэдээ тайланг нь авч эхэлсэн байна.

Гэмт хэргийн мэдээлэл эхэндээ анхан шатны бүртгэлийн хэлбэртэй байсан бөгөөд гэмт хэрэгт холбогдогчдын тоо, эрүүгийн хуулийн зүйл ангиар, нас, хүйсээр, боловсрол, нийгмийн байдлаар гаргаж, түүнд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг судалж, дээд байгууллагадаа илтгэл маягаар танилцуулж байжээ.

Гэмт хэргийн тоо бүртгэлийн зааврыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайд, Улсын прокурор, Улсын дээд шүүхийн даргын 1967 оны хамтарсан 720, 216, 119, БНМАУ-ын Прокурор, Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайд, Улсын дээд шүүхийн даргын 1975 оны хамтарсан 11, 30, 6 дугаар тушаал, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн дарга, Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайдын 1981 оны 28, 87, 13 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 189, 1999 оны 163, 2002 оны 256, 2007 оны 04 дүгээр тушаалаар тус тус батлан мөрдөж байжээ.

Удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд дүн шинжилгээ, мэдээллийн систем чухал ач холбогдолтойг харгалзан Нийгмийг аюулаас хамгаалах яамны Сайдын 1979 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 718 дугаар тушаалаар Дүн шинжилгээ мэдээллийн албыг штабын бүрэлдэхүүнд оруулж Гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэлийн тасаг, Дүн шинжилгээ мэдээллийн тусгай тасаг болгон ажиллуулсан.

Гэмт хэргийн статистик мэдээллийн систем 1980 оноос эхлэн нэлээд өргөжиж, дундаж болон чанарын үзүүлэлтийг тооцож, гаргах болсон байна. Тухайн үед Нийгмийг аюулаас хамгаалах яаманд гэмт хэргийн мэдээлэл, шалтгаан нөхцөлийг судлах, мэдээлэх тусгай тасаг ажиллаж, цагдан сэргийлэх, шүүх, прокурорын байгууллагаас гэмт хэрэг нэг бүрийн талаарх товч мэдээллийг авч, Статистикийн төв газрын тооцоолох төвд тооцоолох электрон машинаар боловсруулж байсан нь энэ салбарын мэдээллийн үзүүлэлтийг ихээхэн өргөжүүлж, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж байсан билээ.

Гэмт хэргийн тоо бүртгэлд гэмт хэргийн “А”, сэжигтэн холбогдогчийн “Б”, шилжилт хөдөлгөөний “В”, шүүхийн шийдвэрийн “Г” гэсэн 4 төрлийн маягт хөтөлдөг байсан. Үүнээс А маягт 42, Б маягт 39 үзүүлэлттэй байсан бөгөөд тэдгээрийг шифрлэн, Улсын статистикийн газрын тооцоолон бодох төвд өгч тусгай программаар боловсруулалт хийж жилд 2 удаа тайлан гаргаж, сар бүрийн сүүлчийн өдөр ВЧ холбоогоор аймгуудаас мэдээ авч нэгтгэн, дараа сарын 5-ны өдрийн дотор тэр үеийн нам, төр, яамны удирдлагуудад тарааж танилцуулдаг байжээ.²⁹

Эрүүгийн гэмт хэргийн тоо бүртгэл, түүний шалтгаан нөхцөлийг судлах тусгай тасаг нь Улсын хэмжээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж шүүхээр шийтгүүлсэн бүх хэргийг нэгтгэн бүртгэж, тэдгээрийн шалтгаан нөхцөлийг судалдаг байснаа 1980-аад оноос үйл ажиллагаа нь улам боловсронгуй болж, Улсын статистикийн газарт мэдээллээ нэгтгэж компьютерээр ангилан ялгаж, мэдээлэл бүрдүүлэх болсон байна.

1986 оноос Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын штабыг татан буулгаж Дүн шинжилгээ, мэдээллийн хэлтэс болгон өөрчлөн зохион байгуулж, 1990 оны 6 дугаар сараас Захиргаа, боловсон хүчний хэлтэс болгон өөрчилж уг хэлтэс гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, шалтгаан нөхцөл судлах ажлыг давхар эрхлэх болсон байна.

1993 онд батлагдсан “Цагдаагийн байгууллагын тухай” хуульд Цагдаагийн төв байгууллагын харьяанд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно, мөн Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд туслах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан байгуулж, ашиглана гэж заасан нь өнөөгийн Мэдээлэл, судалгааны төвийн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн түүхтэй. Цаашлаад Засгийн газрын 2000 оны 180 дугаар тогтоолоор **Цагдаагийн ерөнхий газрын**

²⁹ ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. “Түүхэн замнал” танилцуулга. УБ. 2007, 25 дахь тал

бүтцэд “Гэмт хэргийн шалтгаан нөхцөл дүн шинжилгээ, мэдээллийн төв”-ийг байгуулав.

Мөн 1993 онд батлагдсан Шүүхийн тухай хууль“-д Улсын Дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистикийн тоон мэдээлэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” гэж заасны дагуу Шүүхийн судалгааны төв байгуулагдан ажилласнаар Монгол улсад шүүхийн статистикийн үндэс суурь тавигдсан түүхтэй.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 1999 оны 163 дугаар тушаалаар батлагдсан гэмт хэргийн анхан шатны тоо бүртгэлийн хөтлөх, мэдээ тайлан гаргах зааврыг удирдлага болгон ажиллаж, эрүүгийн болон эрүүгийн байцаах шийтгэх хууль шинэчлэгдсэн болон олон улсын нийтлэг стандарт үзүүлэлт, аргачлалтай нийцүүлэн, мэдээллийн үзүүлэлт, аргачлалыг шинэчлэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 256 дугаар тушаалаар баталж, мөрдөж байна.

Одоогоор гэмт хэргийн улсын статистикийн мэдээллийг сар бүрийн бюллетень, жилийн эмхтгэлд оруулж нийтэд тархааж байна. Сүүлийн жилүүдэд улс орны хөгжлийг зөвхөн ДНБ-ий өсөлтөөр бус хүний амьдралын чанарын үзүүлэлтээр³⁰ хэмжих болсноор гэмт хэрэг, шүүхийн мэдээллийг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Шүүхийн статистик мэдээллийн 12 маягт, гэмт хэргийн статистикийн мэдээллийн 8 маягтыг 2008 онд, гэмт хэргийн статистик мэдээллийн 29 маягтыг 2009 онд шинэчлэн зөвшөөрч, баталж, мөрдүүлжээ. Гэмт хэрэг, шүүхийн статистик мэдээлэл нь НҮБ-аас гаргасан “Гэмт хэрэг, шүүхийн статистикийн гарын авлага”-д заасан аргачлалын дагуу гаргаж, НҮБ-ын ГХМБТГ-аас Гэмт хэргийн чиг хандлага, эрүүгийн эрх зүйн тогтолцоо, түүний үйл ажиллагааны асуулгаар авдаг тоо мэдээллийг 2008 оноос хойш жил бүр тогтмол гарган өгч байна. Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох, цогцоор нь сайжруулах үүднээс авлига хээл хахуулийн талаарх мэдээний маягтыг 2007 онд, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мэдээний маягтыг 2009 онд тус тус батлан мөрдөж байна.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн талаарх мэдээллийг тогтмол гаргах, авилга, хүний наймаа, хар тамхи мансууруулах бодисын үйлдвэрлэл, хэрэглээ зэрэг бүртгэж мэдээлэхэд төвөгтэй шинээр гарч буй гэмт хэргийн талаар мэдээлдэг болох асуудал чухлаар тавигдаж байна. Энэ шаардлагатай нийцүүлэн хохирогчийн судалгаа явуулах, гэмт хэрэг, шүүхийн статистик мэдээллийн нэгдсэн сан байгуулах шаардлага зүй ёсоор тавигдсан юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2002 оны 474 дүгээр тушаалаар “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээг танилцуулах байгууллага, албан тушаалтны жагсаалтыг баталж, мөн газрын даргын 2006 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 71 дүгээр тушаал, 2006 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 360 дугаар тушаал, 2007 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 420 дугаар тушаалаар тус, тус заавар, маягт, статистик мэдээнд нэмэлт өөрчлөлт оруулж байжээ.

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллага харьяа нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ /маягт ГХТБ-10/, сэжигтэн яллагдагчийн мэдээ /маягт ГХТБ-11/, хохирогч иргэн, байгууллагын мэдээ /маягт ГХТБ-12/, түдгэлзүүлсэн хэрэг, хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ /маягт ГХТБ-13/-г сарын сүүлчийн өдрөөр тасалбар болгон гаргаж дараа сарын 3-ны дотор ирүүлснийг Мэдээлэл судалгааны төв тухайн сарын 5-ны дотор багтаан Улсын хэмжээнд нэгтгэн боловсруулж Цагдаагийн ерөнхий газрын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж Үндэсний статистикийн хороонд тогтмол шилжүүлэн хүргүүлж байв.³¹

Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах алба нь өөрсдийн журамлан тогтоосон заавраар сар бүрийн сүүлийн хоногоор тасалбар болгон хэрэг

³⁰ Амьдралын чанар нь хүн амын эрүүл мэндийн чанар, боловсролын түвшин, эдийн засгийн болон байгалын хүчин зүйлсийн нөлөө зэрэг олон асуудлыг хамарсан нилээд нийлмэл бүтэцтэй бөгөөд материаллаг баялгын тодорхой түвшингээс гадна хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны төлөв шинж, аюулгүй байдал, сэтгэлд болон организмд нийцсэн ажил, чөлөөт цаг, итгэл үнэмшил бүхий амьдралыг амьдралын чанарын хүрээний асуудал болгон судалдаг. Н.Даваажав. Амьдралын чанарын зарим үзүүлэлт. УБ.2001.

³¹ Ж.Болдбаатар.О.Нямдаваа. “Криминологи” I дэвтэр. УБ. 2013 он, 44 дэх тал

бүртгэх, мөрдөн байцаах ажлын тайлан мэдээг тус тусын албандаа нэгтгэн гаргаж Цагдаагийн ерөнхий газрын болон Прокурорын байгууллагад танилцуулдаг байсан.³²

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 112 дугаар тушаалаар гэмт хэргийн тоо бүртгэлийн мэдээллийн санг боловсронгуй болгох, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах албаны хэмжээнд гарч буй тайлантай уялдуулах ажлыг судалж, хангуулах ЦЕГ-ын тэргүүн дэд даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан.

Уг ажлын хэсэг гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг бүртгэх маягт, тоо бүртгэлийн заавар, программ хангамжийг шинээр боловсруулах, гэмт хэргийн мэдээллийн сангийн багтаамжийг нэмэгдүүлж, судалгаа, дүн шинжилгээний ажлын цар хүрээг өргөжүүлэх, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шатууд дахь хэргийн хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, Цагдаагийн байгууллагын Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах албадын ажлын мэдээний харилцан уялдаа, нэгдмэл байдлыг хангах, Цагдаагийн байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа бүртгэлийн болон статистикийн мэдээний маягтуудыг бүртгэж, бүлэглэн коджуулах шаардлагыг харгалзан заавар, маягтын төслийг боловсруулсан байна.³³

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 12 дугаар сарын 24-ний 636 дугаар тушаалаар “Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар”, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/174 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 1 дүгээр тушаалаар “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт”, “Гэмт хэргийн статистикийн мэдээний маягт”, “Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягт нөхөх заавар”-ыг тус тус шинэчлэн баталж мөрдөж байгаа бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэлийн заавар” болон бусад холбогдох тушаал, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага хэрэгцээ гарсан байна.

Мөн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагуудын бүртгэсэн гэмт хэргийг тоо бүртгэлд бүрэн хамруулж, **Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн сан** бий болгож, судалгаа, дүн шинжилгээ хийх зорилгоор Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албаны даргын хамтарсан 2013 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 43/182/223/21 дүгээр тушаалаар “**Гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтыг нөхөх, мэдээллийн санд төвлөрүүлэх журам**”-ыг батлан, энэ оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаад хуулиудын өөрчлөлттэй холбоотойгоор 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар дарга нарын хамтарсан А/136:А/190:А/82 дугаар тушаалаар журмыг шинэчлэн батлан мөрдөж байгаа болно.

Журамд зааснаар Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар эрүүгийн хэрэг үүсгэж, аймаг, нийслэл, дүүрэг, тээврийн прокурорын газраас эрүүгийн хэргийн дугаар авсан, Улсын Ерөнхий прокурорын газрын болон аймаг, нийслэл, дүүрэг, тээврийн прокурорын газрын прокурорууд эрүүгийн хэрэг үүсгэж, дугаар олгон, харьяаллын дагуу шилжүүлсэн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хүлээн авсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар тухайн хэргийн гэмт хэргийн тоо бүртгэлийн маягтуудыг нөхөж бичиж өөрийн харьяалагдах байгууллагын эрүүгийн тоо бүртгэл хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч, мэдээллийн санд бүртгүүлэх буюу нэгдсэн сүлжээнд холбогдсон нөхцөлд төвлөрсөн санд тухай бүр шивж оруулах зарчмаар ажиллаж байна.

Одоогоор Мэдээлэл нэгтгэн боловсруулах газар нь “Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ”-г сар бүрийн 25-ны, 12 дугаар сүүлийн өдрөөр тасалбар болгон нэгтгэн боловсруулж Цагдаагийн ерөнхий газрын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж Үндэсний статистикийн хороонд тогтмол хүргүүлж байна.

³² УМБГ. “Мөрдөн байцаагч-V” аргачлал, зөвлөмж. УБ.2001, 13дахь тал

³³ “Гэмт хэргийн тоо бүртгэлийн зааврыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн тайлан”. 2009

Цагдаа, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба зэрэг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагуудын бүртгэсэн гэмт хэргийг тоо бүртгэлд бүрэн хамруулж, Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн сан бий болгосноор судалгаа, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлснээр гэмт хэргийн статистикийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэх томоохон алхмуудын нэг болсон.

Дүгнэлт, санал

Монгол Улсад бүртгэл статистикийн болоод гэмт хэргийн статистикийн хөгжил Хүннү гүрний үеэс үүсэн хөгжиж, өргөжсөөр ирсэн түүхэн уламжлалтай.

Нүүдэлчин монголчуудын дотор овог аймгийн нэгдлээс төрийн зохион байгуулалт хүртэл улс төржих үйл явц явагдан, тархай бутархай олон овог, аймаг, жижиг улсуудыг нэгэн зорилгод нэгтгэн, нэгдсэн төр улс байгуулах түүхэн зорилтыг Эзэн Чингис тэргүүлэн хэрэгжүүлж, нүүдэлчдийн ахуйн амьдрал, аж байдалд тохирсон хэм хэмжээг хуулийн хэм хэмжээ болгон тогтоож дээдлэн сахих явдлыг чандлан мөрдүүлж байснаар төр, хууль цааз нь дэлхий дахинд хүчирхэгжин мандсан түүхэн үе бий. Дээрх баримтуудаас үзэхэд амьдрал ахуйдаа тоо хэрэглэж, юуны түрүүнд хүн ам, малын тоо, газар нутгийн хэмжээ, эд хөрөнгө, гэмт хэргийн талаар бүртгэх шаардлага бий болсноор бүртгэл статистикийг амьдрал ахуйдаа нэвтрүүлэх зайлшгүй шаардлага бий болж, үүсч хөгжиж ирсэн гэдгийг харуулж байна. Иймд гэмт хэргийн статистикийн үүсэл хөгжлийн талаар лавшруулан судлах шаардлагатай байгааг харуулж байна.

Цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Прокурорын байгууллага нь тус тусдаа гэмт хэргийн статистикийн тоо бүртгэлийг хөтөлж, харилцан уялдаа холбоо, гэмт хэргийн статистикийг хөтлөх нэгдсэн арга зүй, аргачлалгүйгээр салбар байгууллагын хэмжээний хэрэгцээ шаардлагыг хангах төдийгөөр явж иржээ.

Манай улс цаашид гэмт хэргийн статистикийг түүхэн уламжлалд тулгуурлан олон улсын статистикийн шалгуур үзүүлэлт, нийтлэг стандартад нийцүүлэх хэрэгцээ шаардлага бидний өмнө тулгарч байна.

Түүнчлэн гэмт хэргийн статистикийн зөв тогтолцоог бүрдүүлж, хууль сахиулах шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистикийн харилцан уялдаа холбоог сайжруулан, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулах, гэмт хэргийн статистикийн мэдээллийн урсгалд дүн шинжилгээ судалгаа хийж, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг оновчтой зохион байгуулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төвлөрсөн бааз суурийг бий болгох саналыг дэвшүүлж байна. Ингэснээр Хууль сахиулах шүүх эрх мэдлийн байгууллагын гэмт хэргийн статистик төвлөрсөн бөгөөд нэгдсэн арга зүй удирдлагаар хангагдаж, гэмт хэрэгтэй шинжлэх ухаантай үндэслэлтэй бодитой аргаар тэмцэх нөхцөл бүрэлдэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар үр дүн дээшилж, гэмт хэргийн гаралт буурна.

Ашигласан ном зүй

1. Б.Балжинням, Б. Дэлхийн Монголчуудын түүх (дэд дэвтэр), УБ.2012
2. Монгол Улсын ШУА-ын түүхийн хүрээлэн. Монгол Улсын түүх. II боть., УБ, 2003
3. “Монголын шүүх” хууль тогтоомжийн эмхэтгэл I Боть. УБ хот., 2016 он
4. Монгол Улсын шүүн таслах хэргийг Бүгд захиран шийтгэгч яам /Баримт бичгийн эмхэтгэл/1911-1921он. УБ хот.,2011
5. Болдбаатар,Ж. Нямдаваа, О. Криминологи. УБ. 2010
6. Нямсүрэн,Ч. Гэмт хэргийн виктимологи. УБ.2005.
7. Ихзаяа,П. Жанцан,С. Мөнхдорж,Б. Гэмт хэргийн статистик. УБ. 2007
8. ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төв. “Түүхэн замнал” танилцуулга. УБ. 2007, 4 дэх тал
9. Ж.Болдбаатар.О.Нямдаваа. “Криминологи” I дэвтэр. УБ. 2013 он, 44 дэх тал
10. УМБГ.“Мөрдөн байцаагч-V” аргачлал, зөвлөмж. УБ.2001, 13дахь тал
11. “ Гэмт хэргийн тоо бүртгэлийн зааврыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн тайлан”. 2009

ТООН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ УХААН БА ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ МЕНЕЖМЕНТ

Л.Цогтбаяр

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн хэрэг
хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн багш, докторант

“Аливааг хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй бол удирдаж чадахгүй, удирдаж чадахгүй бол амар амгалан үгүй”.

Статистикийн ухааны мэдлэг, арга зүй, техник хэрэгслийг ашиглан боловсруулсан тоон мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлыг баталгаажуулах удирдлагын үндсэн баримт болдог.

Тооны үүсэл ба статистик

Хүн төрөлхтөн “тоо” гэгч ертөнцийн нэгэн чухал хэмжүүр, ер бусын нөлөөтэй хүчин зүйлийг нэн эртнээс хэрэглэж ирсэн нь соёл иргэншлийн эхлэл, хөгжлийнх нь үндэс болсон билээ.

Хүн төрөлхтөн хэдийнээс аливааг тоолж эхэлсэн нь тодорхойгүй боловч лавтай эртний Вавилон, Ассир, Шүмэр³⁴, Египтчүүд цаг хугацааг өөр өөрийнхөөрөө тоолох явцад, дүрсээ байнга өөрчилж байдгийн хувьд сар илүү баримжаатай байсан учраас сарны тоолол өргөн дэлгэрсэн. Өрний иргэншлийн хувьд эртний Еврей нарын “Каббала” гэх нууц номд “Бүх үзэгдлийг тооны тусламжтайгаар шинжлэн судалж, түүний нууцад нэвтрэн сэтгэн эргэцүүлж, тооны нууцыг мэдсэнээр өөрөө цэцэн ухаантай болно” гэж дурдсан байдаг.

Дорнын иргэншлийнхэн “тоонууд ертөнцийн эхлэлийн бэлгэ тэмдэг, харин тооны шинжлэх ухаан нь бүх нууц мэдлэгийн суурь” гэж үзэж байжээ. Түүнчлэн хүн, тооны ид шидийг хичнээн их мэдвэл өөрийн хувь тавилангаа, ирээдүйгээ төдий чинээ захирч чадна гэж үздэг байлаа.

Тооны далд утгын судлаач нар маш эртний хүмүүс байсан тул чухам хаана нээгдсэнийг тодорхойлох аргагүй бөгөөд агуйн үеийн хүн 2 хүртэлх, чулуун зэвсгийн үеийн хүн 103, Миссир, Грекүүд 104, Энэтхэгүүд 107, Вавилончууд 108 хүртэлх тоог мэддэг байсан гэжээ³⁵.

Тоо нь аливаа үзэгдэл, үйл явц, тодорхой зүйлийн тоон хэмжээ, хязгаарыг илэрхийлэхэд ашигладаг хийсвэр ойлголт төдийгүй энэ нь хүн төрөлхтний түүхийн турш хөгжиж ирсэн, тоолоход ашигладаг хамгийн энгийн тоо болох натурал тооноос эхлэлтэй.

Хүн төрөлхтөн тоон илэрхийллийг амьдрал, зан үйлдээ төдийгүй ирээдүйн хувь тавилангаа бодитой, үнэн зөв тодорхойлох, ялан дийлэх, хүчирхэгжин цэцэглэх зорилгоо хэрэгжүүлэхэд ашигладаг статистикийн ухаан болгон хөгжүүлж ирсэн.

Иймд статистик нь хүн төрөлхтний өнө эртний үеэс үндэслэн, олон мянган жилийн түүхтэй хөгжиж байгаа мэдлэгийн салбар гэж үздэг.

Тухайлбал, Хүн төрөлхтний түүхэнд төрт улсууд бий болсон цагаас эхлэн газар, нутаг, хүн ам, мал, хөрөнгийнхөө талаар тоо мэдээлэл цуглуулах, нэгтгэн дүгнэх шаардлага, хэрэгцээтэй холбоотой үүссэн³⁶.

³⁴ Одоогоос 6-7 мянган жилийн тэртээгээс Инд мөрний сав газарт үхрээ тууж нүүн очоод Дарвид-бүргэд овогтон нар улмаар Инд, Ганга мөрний сав газарт тархан суурьшсан нь грекийн соёлоос даруй 2000 гаруй жилийн өмнөх явдал болой. Сүмбэрчүүд өнөөгийн Ирак, Иран, Египет орчмын Ур, Киш хот-улсууд бүрэлдэн тогтсон байна. Эдгээр нь бичиг үсэг зохиож харилцаж байсан дурсгалууд олдож байгаагийн дээр 29, 30 хоногтой 12 сар мөн Жарны тооллыг ч хэрэглэж байсан гэх баримт олдож байна.

Ингээд Сүмэрийг Аккад, Ассир, Вавилон, Персүүд эзлсэний улмаас тэд ондоошсон гэж үзнэ.

Сүмэрчүүд МЭӨ 5000-6000 жилийн тэртээ төв Азийн гүнээс Персийн булангаар хөвж очсон байх магадлалтай тухай археологийн олдворууд олдсон ба эндгээр улс нь монгол гарлтай байх үндэслэлтэй гэж Чех Б.Грозный, И.Клим, немец Ханс Крамер, Казах О.Сулейманов, М.Белицкий зэрэг судлаач нар дүгнэсэн байна.

³⁵ Очирын Намнандорж “Монголын түүхийн сурвалж” ., УБ, 1964 он

³⁶ Манай эртний өмнөх 6000-5000 жилийн тэртээгээс эртний Шумер, Хятадад хүн амаа тоолж байсан тухай, МЭӨ 2200 оноос Эртний Вавилон, Египет, Римд мөн цэрэг дайны зориулалтаар хүн ам, эд хөрөнгийн бүртгэл хийдэг байсан тухай, Хүннү нар мал сүргээ тоолж, мод хэрчин тэмдэглэж байсан тухай, хожим Монголчууд XIII зуунд хүчирхэг төр, улсыг байгуулан хүн амаа тоолж, эсгий туургатныг 95 мянгат болгож хуваан түүндээ үндэслэн албан татвар ногдуулж байсан тухай түүхийн баримт бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Аливаа улс гүрэн, ард иргэдийн аюулгүй байдал, тусгаар тогтнолоо бататгахдаа улс хоорондын харилцаа, үйлдвэрлэл, өмчийн харилцаа, худалдааны тогтолцоонд нөлөөлж байгаа тоон мэдээллийн бүртгэлийг бий болгох, улам боловсронгуй болж хөгжихөд статистикийн ухаан түлхэц болсон төдийгүй олон тооны нээлтүүд практик үйл ажиллагааны бие даасан салбар шинжлэх ухааны шинжийг олоход чухал хүчин зүйл болсон.

Германы эрдэмтэн Г.Ахенваль “статус” гэх латин үгнээс гаралтай “статистик”-ийг 1746 онд анх удаа “Хүн ам, эдийн засгийн хүчин зүйлс судлал” гэсэн үгний утгаар илтгэл, өгүүлэл бичиж, хичээл сургаж³⁷ шинжлэх ухааны эргэлтэд оруулсан.

Статистикийн салбар нь өнөөг хүртэл хэд хэдэн чиглэлээр хөгжсөн. Тухайлбал, хүний нийгмийн үзэгдлийг судлах зорилгоор тодорхой тоо, баримтыг ашиглан дүрслэн бичих чиглэл³⁸, үүний дараа янз бүрийн тооцооны тусламжтайгаар эдийн засгийн үзэгдлүүдийн хоорондын холбоо, хамаарал, зүй тогтолцоог илэрхийлэх зорилготой урсгал³⁹. Энэ урсгал нь статистикийн шинжлэх ухааны хөгжилд цоо шинэ үеийг авчирсан бөгөөд цаашид үзэгдэл, үйл явцыг дүрслэн бичихээс халиад үзэгдлийг хэмжиж, судалж, түүний цаашдын чиг хандлагыг тодорхойлох чиглэл рүү илүү хөгжсөн нь ач холбогдолтой.

Статистикийн шинжлэх ухааны гурав дахь чиглэл болох математик статистик XIX зууны эхний хагаст үүсэн хөгжиж эхэлсэн⁴⁰. А.Кетле үзэгдэл, эд зүйлсийн мөн чанарыг танин мэдэхдээ олон мянган тохиолдол үзэгдлийг судлан, түүний статистик зүй тогтлыг илрүүлэх боломжтой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн. Улмаар математик статистикийн чиглэл нь Английн эрдэмтэн Ф.Гальтон (1822-1911), К.Пирсон (1857-1936) нарын оролцоотойгоор улам бүр хөгжин цэцэглэн хөгжсөн бөгөөд эдгээр эрдэмтэд нь ялангуяа корреляцийн онолын хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсан.

Орчин үед “статистик” гэсэн нэр томъёог дэлхий нийтээрээ гурван утгаар ойлгож, хэрэглэж байна.

1-рт: Хүн ам зүй, эдийн засгийн хөгжлийн талаарх тоон мэдээг цуглуулан, боловсруулж, шинжилгээ хийхэд чиглэгдсэн хүмүүсийн үйл ажиллагааны салбар,

2-рт: Статистикийн практикт ашиглагдах онол, арга зүй, техникүүдийг боловсруулдаг шинжлэх ухааны салбар,

3-рт: Аливаа тоо мэдээ, үүний дотор статистикийн эмхтгэл, лавлах, тогтмол хэвлэлүүдэд гардаг тоо мэдээллийг “статистик” гэж нэрлэж хэвшсэн байна.

Монгол Улсад дахь статистикийн шинжлэх ухааны үйл ажиллагаа

Монгол Улсын статистикийн алба өнө эртний уламжлалтай бөгөөд төр улсаа төвхнүүлж ирсэн МЭӨ 220 онд Хүннү нар хүн, мал тоолж, мод хэрчин тэмдэглэж байсан тухай түүхийн судар бичигт тэмдэглэгдэн үлдсэн байна. Эртний Хүннү нараас үүдэлтэй цэргийн мянгат, зуут, аравтын зохион байгуулалтыг засаг захиргаа болон цэргийн зохион байгуулалт талаас нь манай эрдэмтэд, судлаачид судалж, цэргийн энэхүү зохион байгуулалт нь юуны өмнө их цэргийг тоолох ажлыг хялбархан болгож, богинохон хугацаанд цэрэг дайчлан хөдөлгөх боломжийг олгодог байжээ.

Мөн монгол цэргийн энэхүү зохион байгуулалт нь овог аймаг бүрийг захирч байсан ноёд бүрээс хэдий хэмжээний цэрэг, мал уналга, ачлага дайчлан гаргах нөөц боломжтойг байнга мэдэж байх боломжийг олгож байжээ. Ерөнхийдөө энэхүү зохион байгуулалт нь Монголчуудын хүчирхэг, цэргийн нэн уян хатан хөдөлгөөнтэй байх нөхцөлийг бүрдүүлж, чадварыг хангасан нэг гол хүчин зүйл болсон түүхтэй.

Алтан улс, Сүн улсын довтолгоонд Хятад улс өртөж зовж байсан 1122 оны Монгол Улс 50 мянган цэрэг илгээж байсныг Хятад улс түүхэнд бичсэн байна. Энэ нь Чингис хаанаас өмнө Монголчууд цэргийн энэхүү зохион байгуулалтын хэлбэрийг чадварлаг эзэмшиж байсныг харуулдаг. Чингис хаан 1189 онд хамаг монголын хаанаар

Монголчуудын Алтан ордын улсын Бат хаан 1257 онд байлдан дагуулсан Орос орны хүн амыг тоолж, түүндээ үндэслэн албан татвар ноогдуулж байсан тухай Оросын түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байдаг.

³⁷ Gottfried Achenwall (20 October 1719 – 1 May 1772) was a German philosopher, ARA historian, economist, jurist and statistician. He is counted among the inventors of statistics. “Statistic, status” гэсэн нэршлийг шинжлэх ухаанд оруулсан түүхтэй.

³⁸ Германы эрдэмтэн Г.Конринг (1606-1681), Г.Ахенвальд (1719-1772) нар,

³⁹ У.Петти (1623-1687) “Статистикийг зохион бүтээгч” гэгч

⁴⁰ Бельгийн статистикч А.Кетле (1796-1874) онцгой хувь нэмэр оруулж, дундаж хэмжигдэхүүний тухай сургаалаараа статистикийн шинжлэх ухааныг үлэмж хөгжүүлсэн

өргөмжлөгдөн харьяат ардаа эртний уламжлалаар мянгатад хуваасан, улмаар 1206 онд Их Монгол Улсын хаанд өргөмжлөгдсөнөөр иргэдээ 95 мянгат болгож хуваасан нь зөвхөн цэргийн зориулалтаар төдийгүй албан татвар авах зорилгод өргөн ашиглаж байсан учир Монголчууд эртнээс хүн амаа тоолдог уламжлалтай байсан тухай түүхэнд тэмдэглэгджээ⁴¹.

Монгол Улс 19-20 дугаар зуунд уламжлалт статистикийн аргыг ашиглан 1918 онд хүн ам, сүм хийд, малын тооллогын ажлыг хэрэгжүүлсэн бол Богд хаант Монгол Улсын үе болох 1922 онд хүн ам, сүм хийд, малын тооллогод бүх аймгийн тарианы газрыг бүртгэж, тариа тарих, өвс хадах газрыг гадаадын хүмүүст ямар журмаар түрээсэлж байсныг судалж байв.

Манай улс 1924 оны анхдугаар Үндсэн хуульдаа “Улсын аливаа тоо бүртгэх явдлыг тогтоохыг хуульчилж өгсөн” түүхэн уг сурвалжтай бөгөөд 1924 онд хуралдсан Улсын Анхдугаар Их Хурлын тогтоолд тус улсын бүх тоог бүртгэх явдал маш нарийн чухал болох бөгөөд одоо мөнхүү яамнаас тоо бүртгэх хэлтэс байгуулж уг хэргийг эрхлүүлэн явуулбаас зохимуй хэмээн зааж, 1924 оны 11-р сарын 11-ий өдөр тэр үеийн Дотоод яамны бүтцийн хамт анх удаа тоо бүртгэлийн хэлтсийг 6 орон тоотойгоор байгуулснаар орчин цагийн статистикийн албаны эрх зүйн үндэс суурь бүрэлдсэн.

Хуучин социалист системийн улс орнуудад хэрэглэгддэг статистикийн арга зүйн гол цөм болсон улс ардын аж ахуйн балансын систем нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн нөхцөлд тохирсон⁴², зах зээл хөгжсөн орнуудад хэрэглэгддэг үндэсний тооцооны системээс зарчмын ялгаатай байсан.

Манай орон 1990 оноос чөлөөт өрсөлдөөнт эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэнээр өмч хувьчлал, үнэт цаасны арилжаа, чөлөөт өрсөлдөөнт өмчийн олон хэлбэрийн аж ахуй нэгж олноор бий болсноор статистикийн мэдээллийг цуглуулж байсан өмнөх аргийг хэрэглэх боломжгүй болж, ихэвчлэн, түүвэр судалгаа, нэг удаагийн тооллого, төлөөлөх чадвартай нэгжийг сонгож мэдээлэлд хамруулах, түгээмэл тархалтыг тооцох зэрэг статистикийн шинжлэх ухааны бусад олон аргуудыг хэрэглэх шаардлагатай болсон.

Монгол Улс 1993 онд НҮБ-ын Ази, номхон далай орнуудын статистикийн институтын гишүүнээр элссэн нь манай орны статистикийн хөгжилд чухал түлхэц болсон ба энэ байдлыг харгалзан Монгол Улсын Статистикийн тухай хуулийг 1994 онд баталснаар, олон улсын статистикийн стандартад шилжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж улмаар 1999 оноос салбар хоорондын тэнцлийг шинэ нөхцөлд анх удаа боловсруулсан нь улс орны хөгжилд үнэтэй хувь нэмэр болсон.

Статистикийн ач холбогдол

Статистик нь нийгмийн амьдралын түгээмэл үзэгдэл, үйл явцын талаарх тоон утгын зүй тогтол, харилцан хамаарлыг үндэслэн өнөө ба ирээдүйн тухай судалдаг шинжлэх ухааны салбарын хувьд улс орны хөгжил, цаашдын нөхцөл байдалд нөлөөлөх нөлөө асар их болж байна.

Статистик нь өөрийн зорилтоо хэрэгжүүлэх үүднээс олон тооны арга, арга зүйд тулгуурлана. Тухайлбал, аливаа үзэгдэл, үйл явцыг бүхэлд нь хамарч тодорхойлсон дундаж хэмжигдэхүүнийг ерөнхий дундаж, бүлэг тус бүрээр нь тооцсон дундаж хэмжигдэхүүнийг бүлгүүдийн дундаж гэж нэрлэдэг.

Жишээ нь. Улсын хэмжээгээр тооцсон (гэмт хэрэг, зөрчил, хохирол, хохирогч, хүн гэх мэт) дундаж нь ерөнхий дундаж байхад, аймаг болон эдийн засгийн мужлалаар тооцсон нь бүлгийн дундаж болгон авч ашигладаг хоёр төрлийн дундаж хэмжигдэхүүн байдаг.

⁴¹ Ромын лам Г.Рубрук, П.Карпин, худалдаачин Марко Поло зэрэг судлаач, аялагч нарын тэмдэглэлд: Монголчуудыг морь, гүү, тэмээ, шар, үнээ, зэрэг малтай язгууртан, ноёд ба бусад хүмүүс цөм хувьдаа им, тамга хэрэглэдэг байсан, мөн Чингис хааны удам Гүег хаан 1247оны өвөл монголд хүн амын тооллогын ажил хэрэгжүүлсэн, 1326 онд адуун сүргийг тоолж дансыг шинэчилсэн гэж бичиж үлдээсэн байна.

⁴² Эдийн засгийн ашигтай байх үндсэн зарчмаас хэт хазайн, үзэл сурталд тулгуурласан энэхүү эдийн засгийн онол болон хөгжсөн эдийн засгийн сэтгэлгээ нь хувь хүний эрх ашиг, идэвхи санаачлагыг огтоор үгүйсгэн бараг дан ганц энтузиазмд тулгуурласанаар амьдралд огт амжилт үзүүлэхгүй явсаар эцэст нь 1990-ээд оны үед бүрэн сүйрсэн

Статистикийн аргуудыг ерөнхийд нь боловсруулалтын аргууд ба шинжилгээний аргууд гэж хоёр ангилдаг. Үүнээс улбаалан статистикийн арга техникүүдийг дүрслэн тодорхойлох статистик (**Descriptive statistics**) ба шинжилгээний статистик (**Inferential statistics**) гэж хоёр бүлэгт хуваадаг.

Дүрслэн тодорхойлох статистик аргуудад статистик боловсруулалтын энгийн аргууд, тухайлбал, тоо мэдээ цуглуулах, цуглуулсан мэдээллээ цэгцлэн бүртгэх, тархалтын цуваа байгуулах, нэгтгэх, хүснэгт, график, гистограм, хистограм хэлбэрээр илэрхийлэх, дундаж үзүүлэлтийг тооцох зэрэг аргууд байдаг.

Харин, шинжилгээний статистик аргуудад дүрслэн тодорхойлох статистик аргуудаар гарган авсан тоон мэдээлэлд тулгуурлан судлагдаж байгаа олонлогийн гол шинж чанарыг тодорхойлогч үзэгдлүүдийг тооцож, илүү өндөр түвшний статистик аргуудыг хэрэглэн зохих дүн шинжилгээнд үндэслэн логик оюун дүгнэлтийг гарган авдаг. Энэ шатанд математик статистикийн аргууд болох варианцын цувааны шинжилгээ, корреляци, регрессийн шинжилгээ, индексийн шинжилгээний гэх мэт аргуудыг өргөн ашигладаг.

Орчин үед электрон тооцоолон бодох техник, компьютерийг өргөн хэрэглэх болсонтой холбогдож статистикийн хөгжил дэх математикийн үүрэг улам нэмэгдэж байна. Статистик математик аргуудыг хэрэглэснээр, тооцоолох техникээр гүйцэтгэдэг маш их хэмжээний тооцоог нэгтгэх, дүгнэхэд зориулж, тоо мэдээллийг програмчлалын хэлэнд “хөрвүүлэх” стандарт програмуудыг бий болгох боломж бүрдсэн. Гэсэн хэдий ч, математикийн нэн төвөгтэй, нарийн аппаратуудыг хэрэглэснээр статистик нь математик болж хувирахгүй бөгөөд, математик нь судалгаа, шинжилгээний арга хэрэгсэл болж хувирдгийг мартаж болохгүй.

Статистикийн шинжлэх ухаан нь бүтцийн хувьд статистикийн ерөнхий онол, эдийн засгийн статистик, шүүхийн статистик, цагдаагийн статистик, бизнесийн статистик, нийгмийн статистик болон салбарын статистик (аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр, холбоо, худалдаа, хүн ам, боловсрол, эрүүл мэнд гэх мэт) гэх мэтчилэн хуваагддаг боллоо.

Статистикийн ерөнхий онол нь эдийн засагч, менежер болон аж ахуй нэгж, байгууллагын удирдах ажилтан мэргэжлийн хувьд зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг бүрдүүлэхийн тулд судалбал зохих шинжлэх ухааны салбар болон хөгжиж, ач холбогдол улам бүр өссөөр байна.

Бий болсон энэхүү бодит байдал нь статистикийн ухаанд суурилан боловсруулагдсан тоон мэдээлэл улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хөгжлийн үндсэн нөхцөл, иргэдийн аюулгүй байдлыг тодорхойлох нэн чухал хүчин зүйл боллоо.

Гэмт хэрэг, зөрчлийн статистик ба менежмент, хандлага

Статистик ДАТА⁴³ нь аливаа үзэгдэл, үйл явцыг үнэн зөв хэмжиж чаддаг, бодитой хянаж чаддаг, ухаалаг удирдаж чаддаг, иргэдийн аюулгүй байдлыг хангаж чаддаг үр нөлөөтэй хэрэгсэл байх учиртай.

Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллийг нэгтгэн боловсруулж ирсэн уламжлалтай хэдий боловч энэ нь өнөөгийн бодит байдлаар гэмт хэрэг, зөрчилтэй үр дүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдал, хүний хөгжлийг бодитой тодорхойлох, үйл ажиллагааны удирдлагад хангалттай нөлөөлж чадахгүй байна.

Учир нь тоон мэдээллийг хүлээн авах, нэгтгэх, боловсруулах, удирдлагын баримт бичиг болгох үүрэгтэй нэгжүүд, түүний ажилтан нарыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлэх шаардлага зүй ёсоор бий болсныг гэрчилнэ.

Гэмт хэрэг, зөрчлийн статистик нь гэмт хэрэг, зөрчил, аюулгүй байдлыг илэрхийлсэн тооны хэлээр гардаг түүхэн баримт байх төдийгүй эрсдэл, аюулгүй байдлыг удирдах удирдлагын баримт бичиг байх нь цаг үеийн шаардлага гэж тодорхойлж болно.

Статистик нь олон улсын нэгдсэн хэл болохын хувьд аль нэг улсын дотоод асуудал биш хүн төрөлхтний аюулгүй байдал, хүний хөгжил, олон улсын эдийн засаг, улс төрийн, соёлын хамтын ажиллагааны, худалдаа хөрөнгө оруулалтын бодит илэрхийлэл учир НҮБ-ын статистикийн арга, арга зүй, үзүүлэлттэй нийцүүлэх шаардлагатай.

⁴³ Гэмт хэрэг, зөрчлийн статистик.

Гэмт хэрэг, зөрчлийн статистик нь дан ганц тоо биш чанарын нөхцөл байдлыг тухайн орон зай, цаг хугацааны хувьд тодорхойлдог тул олон улсын шаардлагад нийцүүлэх нь ашиглалт, хэрэглээний эргэлтэд оруулахад чухал нөхцөл болно.

Ашиглалтын шалгуурын хувьд:

1. Удирдлагын шийдвэр гаргахад бодитой байх,
2. Удирдлагын шийдвэр үнэн зөв, хандлага тодорхой байх,
3. Нийгмийн бодит үйл явц, үзэгдлийн давтамжийг тодорхой илэрхийлсэн байх,
4. Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд харьцуулах боломжтой байх,
5. Төр захиргааны байгууллагаас гадна судалгаа шинжилгээний болон бизнесийн байгууллагууд өргөн ашиглах боломжтой байх,
6. Хэрэглээний соёл хангагдсан байх,
7. Дата, үзүүлэлт ойлгомжтой, тодорхой байх,
8. Статистикийн боловсрол нийтлэг байх /бүх шатанд хэрэглэгдэхээр/,
9. Бодлого тодорхойлогчийн шийдвэр статистик ДАТА-д суурилсан байх,
10. Шийдвэрийн хэрэгжилт нь чиг хандлагад тулгуурлаж байх,
11. Үйл ажиллагааны үр дүн нь бодитой, үр ашигтай, үнэн байх
12. Эдийн засгийн хувьд үр ашигтай, хэмнэлттэй байх.

Гэмт хэрэг, зөрчлийн статистикийг бүх түвшинд /хөрөнгө оруулалт, оршин суух газраа сонгох, суралцах, ажиллах, бизнес эрхлэх, амарч зугаалах гэх мэт/ ашиглах нь чухал учраас үнэн зөв, хандлага нь бодитой, зөв түвшинд, үр дүн сайтай, эдийн засгийн үр ашигтай, агуулга сайтай, ач холбогдол дүүрэн байх ёстой.

Статистик нь хэсэг тоо цуглуулах үйл ажиллагаа бус бодитой, агуулгатай, үр нөлөөтэй байх үүднээс маш их бүтээлч хөдөлмөрийн үр дүнд статистик дата боловсрогдох учиртай.

Иймд шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, технологид тулгуурлаж нэг хэлээр боловсрогдсон статистик ДАТА⁴⁴ гаргах хэрэгтэй бөгөөд эхний шатанд байгууллагуудад байгаа мэдээллийг нэгтгэн боловсруулах, дараагийн шатанд хэрэглээг өргөн болгоход зорих нь чухал болсон. Статистик ДАТА нь нээлттэй, шуурхай, хүртээмжтэй, бодитой, үнэн /худал, эргэлзээтэй биш/, үр дүнтэй байх нь үндсэн шалгуур байдаг.

Гэмт хэрэг, зөрчлийн статистикийн өнөөгийн байдал

Улсын хэмжээнд хууль сахиулах байгууллага (Цагдаагийн байгууллага) судалгаанд хамрагдсан 2011-2016 он буюу 6 жилийн хугацаанд нийт 1851977 гомдол, мэдээлэл хүлээн авч үүнээс гэмт хэргийн шинжтэй нийт 486699 гомдол, мэдээллийг буюу 26,2 хувийг шалган 230361 тохиолдолд буюу 47,3 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр 310592 тохиолдолд буюу 63,8 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн хугацааны хувьд 0-5 хоногт 226674 буюу 42,4 хувь, 6-19 хоногт 260054 буюу 57,6 хувийг шалгасан.

Гэмт хэрэг: Тайлбар, Судалгаанд хамрагдсан хугацааны эхлэл/төгсгөл байдлаар гэмт хэргийн нөхцөл байдал, илрээгүй гэмт хэргийн төрлийн хувьд ихэнх хувийг эзэлж байгаа хулгайлах, танхайрах гэмт хэргийг сонгон тоймлон дүгнэсэн болно.

Улсын хэмжээнд 2011 онд нийт гэмт хэргийн шинжтэй 59376 гомдол, мэдээллийг шалгаад 23405 /34,4 хувь/ тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 2016 онд нийт гэмт хэргийн шинжтэй 94324 гомдол, мэдээллийг шалгаад 28320 /30 хувь/ тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан нь судалгааны хамрагдсан 2016 онд хүлээн авсан нийт гомдол, мэдээлэл судалгааны эхний 2011 оны дүнгээс 359412 (2.8 дахин), гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 34948 нэгж буюу 58,8 хувиар, эрүүгийн хэрэг үүсгэсэн 1915 нэгж буюу 8,1 хувиар жил бүр тус тус тогтмол өссөн байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийн нөхцөл байдал

Улсын хэмжээнд 2011-2016 онд нийт 148890 /өсөлт 33,9 хувь/ гэмт хэрэг бүртгэснээс хөнгөн гэмт хэрэг 69325 /илрүүлэлт 61,2 хувь/, хүндэвтэр гэмт хэрэг 66289 /илрүүлэлт 57,2 хувь/, хүнд 10305 /илрүүлэлт 70,1 хувь/, онц хүнд 2971 /илрүүлэлт 86,6

⁴⁴ Үүнийг "BIG DATA" гэж нэрлэдэг

хувь/, нийт илрээгүй 26412 гэмт хэргээс 19422 хулгайлах гэмт хэрэг, 1786 танхайрах гэмт хэрэг ихэнх хувийг эзэлж байна⁴⁵.

Дүгнэлт

Гэмт хэрэг, зөрчлийн статистик нь хэсэг тоо цуглуулах үйл ажиллагаа бус бодитой, агуулгатай, үр нөлөөтэй байх үүднээс маш их бүтээлч хөдөлмөрийн үр дүнд статистик дата боловсрогдох байтал дээрх гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ нь жил бүрийн улсын хэмжээний тоон мэдээллийг идэвхгүйгээр хүлээн авч нэгтгэсэн, дан тоон цуглуулга хэвлэж байгаа байдал ажиглагдаж байгааг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

Уг нь энэхүү тоон мэдээллийг цуглуулж, нэгтгэн сайтар шалгасны эцэст бодитой боловсруулалт хийж өнөөгийн байдал, цаашдын зорилгоо бодитой тодорхойлох, эрсдэлийг удирдах, зохион байгуулах баримт бичиг байх ёстой ч үндсэн шалгуурыг хангахгүй “сул баримт” болон хувирсан байна.

Тухайлбал, Нийт бүртгэсэн гэмт хэргийн 135614 буюу 91.1 хувь нь хөнгөн, хүндэвтэр ангиллын, ил цагаан үйлдэлтэй хэрэг шалгасан нь цагдаагийн байгууллагын удирдлагын болон гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны бодлогыг шинээр тодорхойлох, албад болон алба хаагчдыг мэргэшүүлэх шаардлага байгааг илэрхийлж байна.

Хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийн мөрдөн шалгасан дүн мэдээлэл нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа үр дүн багатай, цаг хугацаа, хөрөнгө мөнгө үрсэн, бүтээлч биш ажилд ихэнх нөөц боломжоо алдаж байгаа маш тааруу статистикийн дүрслэл зурагдаж, улмаар цагдаад итгэх иргэдийн итгэлийн индекс муу, иргэдийн аюулгүй байдлын баталгаа алдагдсан гэж тодорхойлж болохоор байна.

Санал

Гэмт хэрэг, зөрчлийн статистикийг шинжлэх ухааны мэдлэг, арга зүй, технологид тулгуурлаж чанартай, үр ашигтай, бүтээлч байдлаар нэг хэлээр гаргаж ашиглах шаардлага тулгарсан байна.

Статистик дата нь дараах шаардлагыг хангасан байх:

1. Удирдлагын шийдвэр гаргахад бодитой нөлөөлж байх;
2. Удирдлагын шийдвэр үнэн зөв, хандлага тодорхой байх;
3. Нийгмийн бодит үйл явц, үзэгдлийн давтамжийг тодорхой илэрхийлсэн байх;
4. Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд харьцуулах боломжтой байх;
5. Төр захиргааны байгууллагаас гадна судалгаа, шинжилгээний болон бизнесийн байгууллагууд өргөн ашиглах боломжтой байх;
6. Хэрэглээний соёл хангагдсан байх;
7. Дата, үзүүлэлт ойлгомжтой, тодорхой байх;
8. Үйл ажиллагааны үр дүн нь бодитой, үр ашигтай, үнэн байх зорилгоо хангах, зорилтоо хэрэгжүүлэхэд бүрэн чиглэсэн байх шаардлагатайгаар боловсруулан хэрэглээнд нэвтрүүлэхээр зохион байгуулалтыг арга хэмжээг авах хэрэгтэй.

⁴⁵ Цагдаагийн ерөнхий газраас гаргадаг мэдээлэл 2016 оны эцэс

УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛДЭГДСЭН ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

*Б.Соронзонбаатар
ХСИС-ийн магистрант*


Зорилго: Монгол Улсын хэмжээнд 2017 онд дээрэмдэх 1126 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 1081 буюу нийт дээрэмдэх гэмт хэргийн 96 хувь нь үйлдэгдсэн байна. Энэ тоон үзүүлэлт 2016, 2017 онд үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон дээрх төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийн хувийг өсгөхөд оршино.

Судалааны арга: Энэхүү судалгааг Нийслэлийн цагдаагийн Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн алба хаагч нартай хамтран 2016, 2017 онуудад үйлдэгдсэн дээрмийн гэмт хэргийн гарсан цаг хугацаа, яллагдагч нарын нас, хүйс, дээрмийн гэмт хэрэг үйлдэгдсэн хороо, алдагдсан эд зүйл, үйлдлийн арга, хохирогчийн нас хүйс, үйлдсэн багаж хэрэгсэл, бүлэглэн үйлдсэн эсэх зэргийн асудалгааг гаргаж SPSS-21 программ дээр шивж дүгнэлтүүдийг гаргаж бичсэн.


Нэг. Улаанбаатар хотод үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал, тоон үзүүлэлт /2016, 2017/

1.1 Улаанбаатар хотод 2016 онд үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн талаар:


Монгол улсын хэмжээнд 2016 онд дээрэмдэх 474 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 404 буюу нийт дээрэмдэх гэмт хэргийн 85,2 хувь нь үйлдэгдэж 69,8 хувь нь илэрсэн байна. Үйлдэгдсэн гэмт хэргийн 226 буюу 56,4 гудамж талбайд, орон сууцанд 73 буюу 17,9, гэр хороололд 40 буюу 9,8 авто машинд 21 буюу 5,1, аж ахуй нэгжид 27 буюу 8,2 хувь нь үйлдэгдсэнээс шатахуун түгээх станцад 4, банкинд 2, барьцаалан зээлдүүлэх газруудад 1 дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн.



Дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа цаг хугацаа нь өглөө 06 цагаас 14 цагт 51, өдөр 14 цагаас 19 цагт 78, орой 19 цагаас 22 цагт 70, шөнө 22 цагаас 06 цагт 205 буюу нийт гэмт хэргийн 50,7 хувь нь шөнийн цагаар үйлдэгдсэн байна.



Дээрэмдэх гэмт ихээр үйлдэгдэж байгаа газар зүйн байршлаар Баянгол дүүргийн 6 дугаар хороонд 12, 18 хороонд 9, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд 9, 3 дугаар хороонд 10, 15 дугаар хороонд 9, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд хамгийн их буюу 17 хэрэг тус тус үйлдэгдсэн.




Дээрэмдэх гэмт хэрэгт хохирч байгаа иргэдийн 117 буюу 28,9 хувь нь эмэгтэй, 297 буюу 73,5 хувь эрэгтэй, үүнээс 104 буюу 25,7 хувь нь насанд хүрээгүй иргэд мөн Бүгд найрамдах хятад ард улсын 7, Бүгд найрамдах солонгос улсын 3, Оросын холбооны улсын иргэн 2, бусад улсын 8 нийт 20 гадаад улсын иргэд дээрэмдэх гэмт хэргийн хохирогч болсон байна.




Дээрэмдэх гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлсийн 68 буюу 16,7 хувь нь бэлэн мөнгө, 238 буюу 58,3 хувь нь гар утас, 23 буюу 5,6 хувь нь үнэт эдлэл, 5 буюу 1,2 хувь нь автомашин, 71 буюу 17 хувь нь бусад эд зүйлсээ дээрэмдүүлсэн байна.

Алдагдсан эд зүйлсийг графикаар үзүүлэл:




Дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчийн 9 буюу 2,1 хувь нь эмэгтэй, 402 буюу 97,9 хувь нь эрэгтэй, үүнээс 95 буюу 23,1 хувь нь насанд хүрээгүй этгээдүүд үйлдсэн байна. Нийт үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн 100 буюу 24,7 хувийг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ, 11 буюу 2,7 хувь нь Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “АСАП” сангаар эрэн сурвалжлагдаж байхдаа, 10 буюу 2,4 хувь нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байхдаа, 2 буюу 0,4 хувь нь захиргааны хяналтад байхдаа дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн байна. Дээрэмдэх гэмт хэргийн 266 буюу 65,8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.



ШШГЕГ-ын цагдан хорих 461 дүгээр ангид 2016 дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн 275 сэжигтэн, яллагдагчийг тодорхой хугацаагаар цагдан хорьсон байна.


1.2 Улаанбаатар хотод 2017 онд үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн талаар:

Монгол улсын хэмжээнд 2017 онд дээрэмдэх 1126 гэмт хэрэг бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 1081 буюу нийт дээрэмдэх гэмт хэргийн 96 хувь нь үйлдэгдэж 17 хувь нь илэрсэн байна. Нийт үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн 196 буюу 18,1 хувь нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 885 буюу 81,8 хувь нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш үйлдэгдсэн байна.




Үйлдэгдсэн гэмт хэргийн 654 буюу 58,2 гудамж талбайд, орон сууцанд 196 буюу 17,9, гэр хороололд 97 буюу 8,6, авто машинд 50 буюу 4,5, аж ахуй нэгжид 88 буюу 7,9 хувь нь үйлдэгдсэнээс шатахуун түгээх станцад 4, банкинд 2, барьцаалан зээлдүүлэх газруудад 3 дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн.


Дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэж байгаа цаг хугацаа нь өглөө 06 цагаас 14 цагт 176, өдөр 14 цагаас 19 цагт 216, орой 19 цагаас 22 цагт 201, шөнө 22 цагаас 06 цагт 488 буюу нийт гэмт хэргийн 45,1 хувь нь шөнийн цагаар үйлдэгдсэн байна.




Дээрэмдэх гэмт ихээр үйлдэгдэж байгаа газар зүйн байршлаар Баянгол дүүргийн 6 дугаар хороонд 25, 18 хороонд 18, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд 33, 3 дугаар хороонд 23, 4 дүгээр хороонд 24, 5 дугаар хороонд 25, 6 дугаар хороонд 25, 7 дугаар хороонд 30, 14 дүгээр хороонд 25, 15 дугаар хороонд 13, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд хамгийн их буюу 34 хэрэг тус тус үйлдэгдсэн.




Дээрэмдэх гэмт хэрэгт хохирч байгаа иргэдийн 287 буюу 31,6 хувь нь эмэгтэй, 794 буюу 68,4 хувь эрэгтэй, үүнээс 258 буюу 28,4 хувь нь насанд хүрээгүй иргэд мөн Бүгд найрамдах хятад ард улсын 9, Бүгд найрамдах солонгос улсын 1, бусад улсын 4 нийт 14 гадаад улсын иргэд дээрэмдэх гэмт хэргийн хохирогч болсон байна.



Дээрэмдэх гэмт хэргийн улмаас алдагдсан эд зүйлсийн 172 буюу 15,3 хувь нь бэлэн мөнгө, 727 буюу 64,8 хувь нь гар утас, 49 буюу 4,4 хувь нь үнэт эдлэл, 5 буюу 0,4 хувь нь автомашин, 148 буюу 13,3 хувь нь бусад эд зүйлсээ дээрэмдүүлсэн байна.




Дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагчийн 10 буюу 2,9 хувь нь эмэгтэй, 329 буюу 97,1 хувь нь эрэгтэй, үүнээс 96 буюу 28,3 хувь нь насанд хүрээгүй этгээдүүд үйлдсэн байна. Нийт үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн 36 буюу 10,6 хувийг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ, 12 буюу 3,5 хувь нь Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “АСАП” сангаар эрэн сурвалжлагдаж байхдаа, 11 буюу 3,2 хувь нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байхдаа, 2 буюу хувь 0,5 нь захиргааны хяналтад байхдаа дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн байна. Дээрэмдэх гэмт хэргийн 188 буюу 17,3 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.



ШШГЕГ-ын цагдан хорих 461 дүгээр ангид 2017дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн 247 сэжигтэн, яллагдагчийг тодорхой хугацаагаар цагдан хорьсон байна. Үүнээс 189 буюу 76,5 хувь нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө нь цагдан хорьсон, 58 буюу 23,4 хувь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш цагдан хоригдсон байна.

Алдагдсан эд зүйлсийг графикаар үзүүлвэл:



Дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2017 онд 1081 дээрэмдэх гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2016 онтой харьцуулахад дээрэмдэх гэмт хэргийн гаралт 667 нэгжээр буюу 62,6 хувь өссөн, хэргийн илрүүлэлт 52,8 хувиар буурсан нь дараах нөхцөл байдлаас шалтгаалсан гэж үзэж байна. Үүнд:

- 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж байгаа Монгол улсын Эрүүгийн хуулиар бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийг дээрэмдэх гэмт хэргээр зүйлчилж байгаа нь хэргийн гаралтын тоон үзүүлэлтэд нөлөөлсөн. Жишээ нь 2017 онд үйлдэгдсэн нийт 1081 дээрэмдэх гэмт хэргийн 885 буюу 81,8 хувь нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш үйлдэгдсэн байна.
- Дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч нарт шүүх, прокуророос цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй байгаа нь дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг олгож байна. Жишээ нь ШШГЕГ-ын цагдан хорих 461 дүгээр ангид 2017 онд дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн 247 сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьсноос 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 58 буюу 23,4 хувийг 2-14 хоногийн хугацаанд цагдан хорьсон байна.
- Дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн мөрдөгч нар дунджаар 70 орчим хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа нь ажлын ачаалал нэмэгдэж эзэн холбогдогч тогтоогдоогүй хэрэгт илрүүлэх чиглэлээр тодорхой ажиллагаа зохион байгуулахгүй байгаа нь хэргийн илрүүлэлтийн хувьд сөргөөр нөлөөлсөн.

2. Улаанбаатар хотод 2016, 2017 онд нийт 1485 дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэж хэргийн улмаас алдагдсан эд зүйлсийн 965 буюу 64,9 хувийг гар утас эзэлж байна. Иймд гар утас худалдан борлуулах газар, барьцаалан зээлдүүлэх төв, цахим орчим болох фейсбүүк, зарын сайтууд зэргээр дээрх гар утаснууд зарагдаж байгаад онцгой анхаарч гэмт хэргийн замаар алдагдсан эд зүйлсийг борлуулан зарж байгаа зах зээлд нь хяналт тавих ажлыг шат дараатайгаар зохион байгуулах.

3. Дээрэмдэх гэмт хэргийн 693 буюу 46,6 хувь нь шөнө 22 цагаас 06 цагт үйлдэгдэж байгаа нь шөнийн цагаар ажиллаж байгаа баар, цэнгээний газруудад үйлчлүүлсэн иргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэж биеэ хянах чадваргүй болсны улмаас дээрэмдэх гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдэд боломж нөхцөлийг олгож байна.

4. Улаанбаатар хотод 2016, 2017 онд дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байршлийн тоон үзүүлэлтэд хамгийн ихээр үйлдэгдэж байгаа дараах хороодууд байна. Үүнд: Баянгол дүүргийн 6 дугаар хороонд 37, 18 хороонд 27, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд 42, 3 дугаар хороонд 33, 4 дүгээр хороонд 24, 5 дугаар хороонд 25, 6 дугаар хороонд 25, 7 дугаар хороонд 30, 14 дүгээр хороонд 25, 15 дугаар хороонд 22, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд хамгийн их буюу 41 хэрэг тус тус үйлдэгдсэн. Иймд 2018 онд дээрх хороодод дээрэмдэх гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зөв оновчтой зохион байгуулах.

5. Улаанбаатар хотод 2017 онд дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч нарын 96 буюу 28,3 хувь нь насанд хүрээгүй этгээдүүд үйлдэж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй хийгдэж байна.

Гурав. Дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх зарим арга хэмжээ

3.1 Дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Нийслэлийн цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор богино хэмжээний суртчилгаа/штрок/ бэлтгэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргах.

- Банк, банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газар, шатахуун түгээх станц, валют арилжааны 8 шарга гэх зэрэг бэлэн мөнгө ихээр төвлөрдөг аж нэгж, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу теле-хяналтын камерыг цагдаагийн байгууллагын сүлжээнд холбох ажлыг зохион байгуулах.

- Иргэд хувиараа такси үйлчилгээнд явж байгаа машинд сууж дээрэмдэх гэмт хэргийн хохирогч болж байгаа тохиолдол 2017 онд 62 удаа бүртгэгдсэн. Иймд дуудлагын такси үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллагатай уулзалт зохион байгуулж хамтран ажиллах талаар санал тавих. Жишээ нь шөнийн цагаар ажиллаж байгаа баар, цэнгээний газруудад дуудлагын такси дуудах мэдээллийг байршуулах мөн үйлчилгээний газруудаар аюулгүй зорчих зөвлөмж бүхий хуудас тараах. /Зөвлөмж болон мэдээллийг байршуулахад шаардагдах зардлыг тухайн аж ахуйн нэгжүүдээр гаргуулах/

- Улаанбаатар хотод 2016, 2017 онд үйлдэгдсэн дээрэмдэх гэмт хэргийн 693 буюу 46,6 хувь нь шөнийн цагаар үйлдэгдсэн. Нийслэлийн цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах газар, Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран шөнийн цагаар согтууруулах ундааны зүйл зарж, борлуулж байгаа баар, цэнгээний газар, хүнсний дэлгүүрүүдийг олж тогтоон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх. Цаашид баар, цэнгээний газруудыг 00 цагт үйл ажиллагааг зогсоох талаар судалгаа хийж Нийслэлийн засаг даргын тамгын газарт уламжлах.

- Улаанбаатар хотод үйлд ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад дүүргүүдийн цагдаагийн хэлтсээс дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт оруулах.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

“БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ЗОРИЛГООР ХАЛДАХ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЦАГДАА, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ХЭРЭГЛЭЭ” СУДАЛГААНЫ ТОЙМ

Л.Бат-Очир

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

Дэлхийн ихэнх улсууд эдийн засгийн хямралтай тулгарч даван туулсны дараа нийгмийн харилцаанд гарсан өөрчлөлтийг зохицуулах, нийцүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хандлага явагдаж байна. Манай улсад ч мөн адил энэ үйл явц нөлөөлж, нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаа хувьсан өөрчлөгдөж байгаа бөгөөд гэмт хэргийн түвшин, гаралтаас харж болно. Нийгмийн харилцааны эдгээр өөрчлөлтүүд нь хууль сахиулах байгууллагуудын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд эерэг, сөрөг байдлаар нөлөөлж байгаагаас гадна хууль сахиулах байгууллагуудын хүрээнд эрх зүйн шинэтгэлийн үр дүн ихээхэн нөлөөлж байна.

Улсын Их Хурлаас баталсан Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт⁴⁶ “Иргэн, байгууллагад хохирол учруулж, хорих ял эдэлж байгаа хүмүүсээр тэдгээрийн учруулсан хохирлыг бүрэн төлүүлж байх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, байгаль орчны холбогдолтой гэмт хэргийн эрүүгийн хариуцлагыг чангатгах чиглэлээр Эрүүгийн болон холбогдох хуульд өөрчлөлт оруулна” гэж заасны дагуу 2002 оны эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын нэг төрөл болох “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах” үйлдлийг анх удаа бие даасан институт болгон хуульчилсан нь цагдаагийн алба хаагчын хууль ёсны үйл ажиллагааны эрүүгийн эрх зүйн баталгаа болсон төдийгүй иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, идэвхжүүлэх, олон улсын чиг хандлагад нийцүүлэх, хүний эрхийг хангах зэрэг томоохон дэвшил болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын гэрээ, конвенцийн агуулга, зарчимд нийцүүлэх, нөгөө талаас нийгмийн хаилцаанд гарсан өөрчлөлтүүдээс улбаалан 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн баталсан боловч баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах явдлын эрх зүйн зохицуулалтын хувьд өмнөх хуулийн үзэл баримтлал хадгалагдан үлдсэн гэж үзэх үндэстэй.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн байгууллагыг улс төржүүлэх, алба хаагчын хууль ёсны үйл ажиллагааг буруутгах, хэлмэгдэх, үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, хүлээлгэх, нэр хүндийг гутаах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэдийн дунд сөрөг хандлага давамгайлах, нийгмийн дэг журам алдагдах, тэдний албандаа хандах хандлага өөрчлөгдөх, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болох, амь нас эрсдэх, эрүүл мэндээр хохирох⁴⁷, эрүүгийн хуулийн дээрх хэм хэмжээг олон нийтийн таалалд нийцүүлж хууль буруу хэрэглэх, хууль ёсны эрх ашгийг зөнд нь орхих, улмаар эрүүгийн хуулийн хууль ёсны зарчмын хэрэгжилт алдагдаж төсөөтэй хэрэглэх явдал гарах боллоо.

Улсын Их Хурлаас 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр баталсан Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 4.2 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэж оргосон хүнийг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор энэ хуульд заасан үйлдлийг аргагүй байдалд хийж тухайн хүнд халдсан нь баривчлах, таслан зогсоох хэр хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй” гэж баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах институтийг өргөн хүрээнд хуульчилсан юм.

⁴⁶ Монгол Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. 31 дүгээр зүйл.

⁴⁷ Цагдаагийн байгууллагын судалгааны дүнгээс үзэхэд албан үүргээ гүйцэтгэж явах үедээ нас барсан 82, хөдөлмөрийн чадвараа алдсан 316 алба хаагч байна.


гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үйлдэл нь аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлаас агуулга, мөн чанар, хууль ёсны шинжийн хувьд эрс өөр гэдгийг хууль тогтоогч хүлээн зөвшөөрсөн явдал болсон юм. Эрүүгийн хуульд орсон дээрх нэмэлт өөрчлөлт нь зөвхөн хууль сахиулагчын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэх эрүүгийн эрх зүйн чухал баталгаа болсон төдийгүй гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд иргэдийг өргөнөөр татан оролцуулах боломж олгосон чухал зохицуулалт болсон юм.

Эрүүгийн хуулийн дөрөвдүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын институт нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд чухал байр суурь эзэлдэг тулгуур асуудлын нэг учраас эрүүгийн хууль дахь энэ хэм хэмжээг шүүхийн практикт хэрхэн хэрэглэж байгаа, онолын суурь судалгаа ямар түвшинд хийгдсэн, хууль сахиулагчдын үйл ажиллагааны практикийг судлах, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох шаардлага тулгарч байгаа нь эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны судлаачдын хувьд чухал зорилт болж байна. Хууль зүйн доктор Х.Сэлэнгэ: "баривчлах ажиллагааны явцад хүний эрхийг зөрчсөн гэх шинжлэх ухааны сүүлийн үеийн дорвитой судалгаа байхгүй"⁴⁸ гэж энэ хэм хэмжээний талаарх судалгаа дутмаг байгааг хүлээн зөвшөөрчээ.

Ийм учраас хууль сахиулах үйл ажиллагааны явцад өдөр тутам тохиолддог гэмт хэрэг, зөрчил үйлдэж буй этгээдийг баривчлах, үйлдлийг таслан зогсоох явцад гэмт этгээд болон иргэн аж ахуйн нэгж байгууллагад амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол учруулах явдал цөөнгүй гардаг бөгөөд чухам энэхүү нөхцөл байдлын үед хууль сахиулагч болон гэмт хэрэг үйлдэж буй этгээдийг таслан зогсоох үйл ажиллагаанд оролцож байгаа иргэний үйлдэл нь хууль ёсны байсан эсэхийг тогтоох нь онол практикийн ач холбогдолтой юм.



Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлд заасан баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах институт нь нэгдүгээрт иргэдийн зүгээс гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг идэвхжүүлэх, урамшуулах, хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалж буй хууль сахиулах байгууллагын алба хаагчдын хууль ёсны үйлдлийг хамгаалах эрүүгийн эрх зүйн гол баталгаа болгон эрх зүйн үндэсийг тодорхойлсон гэж болно. Практикт Цагдаагийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох ажиллагаанд ихэвчлэн оролцож байна. Тийм учраас энэ институтийн талаарх мэдлэг, ур чадвар, практикийн хэрэглээ, хууль сахиулагчдын хандлага зэргийг судлах, дүн шинжилгээ хийх зорилгоор Цагдаагийн 1550, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 80, нийт 1630 алба хаагчаас анкетын судалгаа авч нэгтгэн дүгнэсэн.

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл



⁴⁸ Х.Сэлэнгэ. Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ. Эрх зүй сэтгүүл. УБ. 2017. №1 215 дахь тал.

Судалгаанд 21 аймгийн Цагдаагийн газар, 7 дүүргийн 15 Цагдаагийн хэлтсийн алба хаагчдаас судалгаа авсан. Нийт оролцогчдын дийлэнх хувь нь буюу 18-35 насны алба хаагч оролцсон бөгөөд ЦЕГ-ын Нийгмийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын алба хаагчид болон хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, эргүүлийн цагдаа зэрэг өдөр тутам баривчлах, таслан зогсоох ажиллагаанд оролцдог алба хаагчдаас судалгаа авсан.



Нийт алба хаагчдын 542 буюу 33.6% нь бакалавр, 355 буюу 22% нь бүрэн дунд боловсролтой алба хаагчид байна.



Ажилласан жилийн хувьд дийлэнх оролцогчид 5-10 жилийн хугацаанд ажилласан, баривчлах, таслан зогсоох ажиллагааны талаар зохих туршлагатай алба хаагчид байгаа нь энэ хэм хэмжээний талаарх онолын анхан шатны зохих мэдлэгтэй, практикт баривчлах, таслан зогсоох ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцож байсан алба хаагчид хамрагдсан байна.



2. Судалгааны үр дүн




Оролцогчдын 1025 буюу 3/2 нь гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах, таслан зогсоох ажиллагаанд оролцож байсан байна.

Баривчлах, таслан зогсоох явцад бусдад хохирол учруулж байсан уу?




Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах явцад хохирол учруулаагүй тохиолдол дийлэнх нь байгаа боловч амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах явцал цөөнгүй байгаа бөгөөд доорх судалгаанаас үзэхэд галт, зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх явдал харьцангуй их байна. Энэ нь гэмт этгээд цагдаагийн алба хаагчын тавьсан хууль ёсны шаардлагыг ямар нэгэн байдлаар эсэргүүцэх, зайлсхийх, зугатаах явдал харьцангуй их байна гэж үзэж болно.

Гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах, таслан зогсоох үед галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэж байсан уу?



Хэрэв хэрэглэж байсан бол алиныг нь хэрэглэж байсан бэ?



Судалгаанд оролцогчдын 57% нь тусгай хэрэгсэл хэрэглэсэн байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлд хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болох талаар заасан ба хэрэглэсэнээс үүсэх үр дагаварын төлөө хариуцлага хүлээхгүй гэж заасан. Цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үед өөрөө бие даан тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэж болно.

Баримт

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт 50 настай эмэгтэйг траншейны нүхэнд хүчиндэж алсан гэмт хэрэг үйлдсэн “С” гэгчийг илрүүлэн баривчлах үед эсэргүүцэн учир зүггүй чанга орилон хашгирч, зугтаахад цагдаагийн албан хаагч сэтгэл зүйн хувьд хэвийн бус этгээд гэдгийг урьдчилан таамаглаж гудамжинд явж байгаа хүмүүст анхааруулан холдуулан биеийн хүч хэрэглэн баривчилсан байна. Баривчлах үедээ түүнд ямар нэгэн гэмтэл учруулаагүй байна.⁴⁹ Энэ нь баривчлах ажиллагааны нөхцөл байдлыг зөв үнэлж дүгнэсэний тод жишээ юм.

Шүүхийн практикт хоорондоо адил нөхцөл байдалд өчих мэх хэрэглэж хүндэвтэр гэмтэл учруулсан төсөөтэй хэргүүдийг өөр байдлаар шийдвэрлэсэн нь энэ хэм хэмжээг хэрэглэсэн практик бага, шүүгчид нэгдсэн ойлголт байхгүй байгааг үгүйсгэх аргагүй юм. Эрх зүйт төрд шүүхийн шийдвэр иргэдэд нээлттэй ил тод байх нь иргэдээс шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх төдийгүй, судлаачдад судалгаа шинжилгээ хийх, шүүмж судлал өрнүүлэх, судалгааны талбар болсон эрх зүйн шинэчлэлд гарч буй шинэлэг дэвшилтэт зүйл болсон. Шүүхийн шийдвэрийг зөв буруу гэж дүгнэхээс илүү шийдвэрт дүн шинжилгээ хийх нь онолын болон практикийн хувьд хууль хэрэглээний нэгдмэл ойлголтыг тогтооход чухал ач холбогдолтой юм. Шүүхийн шийдвэр нь агуулга болоод хэлбэрийн ангиллын талаар хууль зүйн шинжлэх ухаан болон практикийн хооронд нэгдмэл нэг ойлголтод хүрэх нь шүүгчийн ажлыг хөнгөвчлөх бөгөөд алдаа гаргахгүй байхад тус дөхөм болдог⁵⁰.

Баримт

2016 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр таксины мөнгөө төлөхгүй жолоочтой нь маргалдаж танхайрсан шалтгаанаар саатуулагдсан Т нь цагдаагийн алба хаагч А-ын тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэн, доромжилж дайрсан тул зүүн гарыг нь өчиж хугалан хүндэвтэр гэмтэл учруулжээ⁵¹. Хохирогч Т-нь гомдол гаргасаны дагуу эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж дүүргийн прокурорын газраас эрүүгийн хуулийн тусгай ангийн 98 дугаар зүйлийн 98.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэн шүүхэд ирүүлснийг хэлэлцэж цагаатгах тогтоол гаргажээ.

Цагдаагийн алба хаагч А-ын үйлдэл нь хууль ёсны ажиллагаа байсныг шүүх хүлээн зөвшөөрч цагаатгах тогтоол гаргажээ. А-нь Хууль зүйн сайдын 2014 оны долдугаар сарын 10-ны өдрийн А/126 дугаар тушаалын хоёдугаар хавсралтаар батлагдсан Цагдаагийн

⁴⁹ Д.Тогмид.Цагдаагийн дууль.Хоёрдугаар дэвтэр.УБ.,2007 он.,49 дүгээр тал.

⁵⁰ И.Кают."Шүүхийн шийдвэр, тогтоол бичих арга техник.Гарын авлага.УБ.,2015.,5 дахь тал.

⁵¹ Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн цагаатгах тогтоол.УБ.,2017 оны 05 дугаар сарын 12-ны өдөр. 175.,201625032259 дугаартай эрүүгийн хэрэг.

байгууллага, албан хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 1.3.3, 5.1, 5.4 дэх хэсгүүдэд тус тус заасны дагуу үйл ажиллагаа явуулсан, хохирогч Т-ын гаргаж буй зохисгүй зан харьцаа, хоорондын биеийн хэмжээний байдал зэргийг харгалзан, өөрийн дотоод итгэлээр нөхцөл байдлыг үнэлж дүгнэн, Т-ын үйлдлийг таслан зогсоох зорилгоор, хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлсэн нь нөхцөл байдлыг зөв үнэлж, биеийн хүч хэрэглэсэн хууль ёсны үйлдэл байжээ.

Гэтэл Баянзүрх дүүргийн шүүхээр дээрх нөхцөл байдалтай ижил хэргийг шийдвэрлэхдээ ял оногдуулсан нь шүүхийн практикт дээрх хэм хэмжээний талаар нэг мөр ойлголт байхгүй, хуулийг өөр өөр байдлаар ойлгож хэрэглэж байгаа тохиолдол байсаар байна.


Баримт

2017 оны 08 дугаар сарын 07-ны өдөр саатуулах байрны цагдаа Д нь албан үүргээ гүйцэтгэж байх үед хэл амаар доромжлон, цагдаагийн алба хаагчын тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн Б-д хүч хэрэглэх талаар сануулсны дараа, саатуулах үед өчих мэх хэрэглэн гарыг хугалж хүндэвтэр гэмтэл учруулжээ⁵².

Шүүхээс Д-г гэм буруутайд тооцож 350 цагийн албадан ажил хийлгэх ялаар шийтгэсэн нь хэргийн бодит үнэнд нийцээгүй, үндэслэлгүй шийдвэрлэсэн гэж үзэж болохоор байна. Хууль зүйн доктор Т.Золбоо:”Эрүүгийн эрх зүйн залхаан цээрлүүлэх шинжээс хүмүүнлэгийн шинж байдалд шилжин эрх зүйт төрийн зарчмын үндсэн дээр эрүүгийн хуулийг боловсронгуй болгож байна. Гэхдээ.....хуулийг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлан практикт зөв хэрэглэж сая нэгэн цогч болох учиртай”⁵³ гэснийг хүлээн зөвшөөрөх үндэстэй юм

Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын 36% нь баривчлах, таслан зорилгоор халдах явцад биеийн хүч хэрэглэж байгаа нь нэгдүгээрт, хүч хэрэглэх ур чадвар дутмаг, нэг бүрийн тусгай хэрэгсэл хангалтгүй, хоёрдугаарт дийлэнх тохиолдолд баривчлагдаж, саатуулагдаж байгаа хүн ямар нэгэн байдлаар эсэргүүцэл үзүүлж байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын 82% нь хүч хэрэглэж байснаас 60% нь тусгай хэрэгсэл хэрэглэсэн байна. Ялтан оргосон үед Тусгай ажиллагаа, аюулгүй байдлын газар дайчлан баривчлах ажиллагааг зохион байгуулах бөгөөд алба хаагчид нь байнгын бэлтгэлтэй, нөхцөл байдлыг урьдчилан нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг учраас баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлэх асуудал гардаггүй гэж үзэж болно. Нөгөө талаар оргосон ялтны зан төлөв, тухайн үеийн нөхцөл байдал, аюулгүй байдлыг хангах үүднээс тусгай хэрэгсэл хэрэглэх явдал их байна.



⁵² Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр. 183.,201625011132 дугаартай эрүүгийн хэрэг.

⁵³ Т.Золбоо.Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.Эрх зүй сэтгүүл.УБ.2017.№1 223 дахь тал

Баривчлах, таслан зогсоох ажиллагааны явцад хохирол учруулах үед албаны шалгалт хийж байсан уу?



Судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 80% нь албаны шалгалт хийгдсэн талаар дурдсан байна. Практикт баривчлах, таслан зогсоох зорилгоор халдсан алба хаагчын үйл ажиллагааг хууль ёсны байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхөөс илүү тэднийг буруутгах, олон нийтийн таалалд нийцүүлэх, хариуцлага хүлээлгэх хандлага давамгайлах хандлага байна. Энэ нь алба хаагч өөрийн ажил үүрэг, амьдралд итгэл үнэмшилгүй болох, алба хаагчдыг олон удаагийн давтамжтай сургалтанд хамруулах, мэдлэг олгох, хяналт шалгалтыг сайжруулах, мэдээлэлээр хангах, чадваржуулах, үнэлэх, удирдлагын алба хаагчдадаа хандаж буй хандлагыг өөрчлөх, хууль ёсны үйлдэл хийсэн алба хаагчыг бүх шатанд хамгаалах, өөрийн албандаа итгэл үнэмшилтэй болох, тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангах, олон нийтэд цагдаагийн албаны үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн дунд байгаа сөрөг хандлагыг өөрчлөх, цагдаагийн болон бусад тусгай албадын нэр хүнд имижийг өсгөх ажлыг бодлогын түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Практикт цагдаагийн алба хаагчид гэмт этгээдийг баривчлах, үйлдлийг таслан зогсоох үед хэтэрхий их хичээдэг учраас туршлага багатай, алба хаагчдын хувьд гэмт этгээдтэй адил шууд сэтгэл хөөрлийн байдалд шилждэг. Ингээд тухайн нөхцөл байдлыг зөв үнэлэх хяналтаа алддаг тул цаг хугацаа болон орон зайгаа мэдрэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл богино хугацаанд нөхцөл байдлаа үнэлнэ гэсэн үг юм.

Тийм учраас хяналтгүй байдал хүчирхийллийг бий болгон гэдгийг анхаарах хэрэгтэй.

Баримт

2009 оны 09 сарын 15-нд Парис хотод дэлхийн дулаарлын эсрэг жагсаалд 100000 хүн оролцсон бөгөөд 4000 орчим цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн. Энэ цуглааны үед 2000 орчим хүнийг баривчилсан боловч тусгай байранд хүргэх ёстой автобус нь замын түгжрэлд орсоны улмаас 3 цаг гаруй хүйтэн зам дээр удаан суулгасан бөгөөд шүүхээс дээрх ажиллагааг, гарах сөрөг үр дагаварыг буруу тооцоолж хүний эрх зөрчсөн үйлдэл гэж үзэн Францын засгийн газраас хүн тус бүрт 1000 ам доллар гаргуулах шүүхийн шийдвэр гаргасан байна.⁵⁴

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тагнуулын байгууллагын алба хаагчдын хувьд баривчлах, таслан зогсоох ажиллагааны явцад хохирол учруулах байдал харьцангуй бага байна. Учир нь гэмт этгээдийн хувийн байдал, цаг агаар, нутаг дэвсгэрийн онцлог, хүн хүч, учрах эрсдлийг тооцоолох зэрэг тухайн үеийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэн, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлдэг учраас хохирол учрах явдал гардаггүй байна.

Харин Хил хамгаалах байгууллагын хувьд 2016 оноос өмнө хил зөрчигчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах явдал цөөнгүй гарч байсан боловч сүүлийн жилүүдэд ийм тохиолдол гараагүй байна. Учир нь 2016 оноос өмнө галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл журам боловсронгуй бус, Хил хамгаалалтын дүрмээр⁵⁵ зохицуулж байсан бол 2016 онд Хил хамгаалах тухай хуульд галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл журмыг шинэчлэн хуульчилсан юм.

⁵⁴ Цагдаагийн байгууллагаас хүч хэрэглэх талаарх олон улсын стандарт. Сургалтын гарын авлага.УБ.,2015.,16 дахь тал.

⁵⁵ Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг.УБ.,1994., Дугаар 81.



Алба хаагчдын дийлэнх нь баривчлах, таслан зогсоох зорилгоор халдахдаа зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэн гэдэгтэй санал нийлж байгаа боловч баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах институтийн талаарх онолын мэдлэг дунд түвшинд байгааг дараахь судалгааны дүн харуулж байна.

Баримт.


Цагдаагийн алба хаагч М нь саатуулах байранд хүргэгдэж ирсэн хохирогч Т-г хүзүүний гинжээ тайл гэж шаардлага тавихад үгүй гээд тонгойх үед түүний хэвлий орчимд нэг удаа өвдөглөсөнөөс түүний биед хэвлийн битүү гэмтэл, 12 хуруу гэдэсний урагдал, язрал гэмтэл учирч нас баржээ⁵⁶. Шүүхээс М-ийг хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 10 жилийн хорих ял оногдуулсан байна.

М нь хүч хэрэглэх шаардлага байгаагүй, гинжийг тайлж авах үүрэгтэй, тонгойж байх үед өвдөглөх шаардлага байхгүй үед тухайн нөхцөл байдалд илт тохироогүй хүч хэрэглэсэн нь алдаанд хүргэсэн. Аливаа мэдлэг, ур чадваргүй, хүч хэрэглэсэн үйлдэл нь ердийн үед мэдэх боломжтой байсан хэргийн бүх нөхцөл байдлыг үнэлэх боломжгүй болгодог.



⁵⁶ Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол. 2016 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр. 51.,2014250008487 дугаартай эрүүгийн хэрэг.

Цагдаагийн алба хаагч баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх гол шалгуур нь хувийн үнэлэмж байх ёстой юу?



Алба хаагч баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх нь гол шалгуур нь хувийн үнэлэмж байх ёстой гэжээ. Канад, Итали улсад баривчлах, таслан зогсоох ажиллагааг нарийвчлан журамладаггүй бөгөөд цагдаагийн алба хаагчын баривчлах, таслан зогсоох ажиллагаанд хэр хэмжээ хэтрүүлэх тухай асуудал байдаггүй, харин алба хаагчыг олон удаагийн сургалтанд хамруулж нөхцөл байдлыг бодитой үнэлэх, чадвар хандлагыг төлөвшүүлдэг байна. Зарим судлаачид гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудад хэр хэмжээ хэтрүүлэх шалгуур тавьж болохгүй.

Учир нь тухайн ойлголтын мөн чанарыг үгүйсгэдэг гэж үздэг байна. Ихэнх улсуудад гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, таслан зогсоох ажиллагаанаас үүсэх эрсдлийг тооцоолох талаар урьдчилан тодорхойлох аргачлал байдаггүй бөгөөд тухайн нөхцөл байдлыг алба хаагч хувийн үнэлэмжээр үнэлэх ёстой. АНУ-д цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх, аюулыг байдлыг хангах талаар урьдчилан сануулах ба хэрэв шаардлагыг үл биелүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно. Энэ нь галт зэвсгийг тухайн улсын иргэд эзэмших, ашиглах, өмчлөх, худалдах, хэрэглэх эрх нь харьцангуй нээлттэй байдагтай холбоотой юм.

Баримт

АНУ-д цагдаагийн хоёр ажилтан зочид буудлын хонгилд зэвсэггүй хүнийг буудан хөнөөсөн хэрэг гарсан байна. Саатуулагдсан эр санамсаргүйгээр өмдний халаас руугаа гараа хөдөлгөснөөс уг золгүй явдал болжээ⁵⁷. Буудалд үйлчлүүлэгсдийн нэг нь өрөөнийхөө цонхоор гар буутай шагайн, хажуугаар өнгөрөгсдийг заналхийлээд байна гэх дуудлагын дагуу цагдаа нар зочид буудалд ирсэн бөгөөд тэд 26 настай Дэниэл Шейверийг сэжиглэн саатуулжээ. Шүүхээс хэрэгт холбогдсон цагдаагийн үйлдлийг хууль ёсны үйлдэл хийсэн гэж шийдвэр гаргажээ.

АНУ-ын Калифорнийн Их сургуулийн профессор Блаугийн тодорхойлсноор шинэ үеийн цагдаагийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжтой, үйл ажиллагаа нь олон нийтэд чиглэсэн, мэргэшсэн, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг байх гэж тодорхойлоод хамгийн гол шинж нь мэргэжлийн болон мэргэшсэн байх явдал гэж тус тус дүгнэжээ.⁵⁸ Тийм учраас алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг онол практиктай хослуулан заах, гэмт этгээдийг баривчлах, таслан зогсоох үйл ажиллагааны талаарх хандлагыг өөрчлөх, төлөвшүүлэх шаардлагатай байна. Манай улсад хэв журмын цагдаагийн алба хаагчыг 3 сарын хугацаатай бэлтгэж байгаа бөгөөд баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээний талаар ердөө гурван цагийн багтаамжтай хичээл зааж байна. Ийм богино хугацаанд баг цагаар цогц мэдлэг, ур чадвар эзэмших ямарч боломжгүй юм.

Баримт

⁵⁷ www.The Washington Post.com

⁵⁸ Blau P. M. "A Formal Theory of Differentiation in Organisations", American Sociological Review 35: 1999. 201-218 pg.

Цагдаагийн алба хаагч Ө нь, согтууруулах ундаа хэрэглэсэн, хутгайтай хүн танхайраад байна гэсэн дуудлагын очиход хохирогч Д нь хутга барин ойртсон хэнийг ч ална шүү гэж байв. Ө хутгаа хаях шаардлага тавихад биелүүлээгүй тул газраас чулуу авч шидэн, Д-ын толгойд хөнгөн гэмтэл учруулан барьж авсан байна. Шүүхээс Ө-ийн үйлдлийг хууль бус гэж үзэн 2010 оны 08 дүгээр сарын 16-ны өдөр нэг сар баривчлах ял оногдуулсан байна⁵⁹.

Ө нь баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үедээ хууль ёсны шаардлага тавьсаны дараа тайвшруулах, ямар хүч хэрэглэх, ямар үр дагавар гарах талаар урьдчилан сануулах, зан төлөвийг судлах, зөрчил гаргаж буй хүн, иргэдийн, өөрийн аюулгүй байдлыг хангах зэрэг об'ектив хүчин зүйлсийг үнэлэсэний дараа тусгай мэх хэрэглэн, хутгыг авч үйлдлийг таслан зогсоох ёстой. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын⁶⁰ 223.5.2 дахь хэсэгт “Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж баривчлах, төрийн байгууллагад албадан хүргэх ажиллагааны явцад хохирол, эрсдэл учруулахгүй байхыг эрмэлзэж ажиллана” гэж заасан нь зөвхөн баривчлах ажиллагааны явцад л анхаарах асуудлыг зохицуулсан хэм хэмжээ юм. Тэгвэл зөрчил үйлдэж буй хүний үйлдлийг таслан зогсоох явцад яг ямар арга тактик хэрэглэж ажиллах талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй байна.

Цагдаагийн албаны тухай хуульд⁶¹ зөвхөн биеийн хүч хэрэглэх үндэслэлийг, Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд⁶² **Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ биеийн хүч хэрэглэж болох бөгөөд хүч хэрэглэхгүйгээр үүргээ гүйцэтгэх боломжтой тохиолдолд биеийн хүч хэрэглэхгүй байх талаар, Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх зааварт**⁶³ олон хүнд нөлөөлөхөөс бусад бүх төрлийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх шийдвэрийг цагдаагийн алба хаагч өөрөө гаргаж, үр дагаврыг хариуцах талаар тус тус заасан байна. Дээрх тохиолдолд Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар⁶⁴ цагдаагийн байгууллага нь алба хаагчыг албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж тусгай хэрэгсэл тавьж олгох үүрэгтэй.

Баримт

1990 оны 05 сард Хүнсний нэгдүгээр дэлгүүрийн урд цэрэг хувцастай хүн таксинд буу тулган суух үед таксины жолооч цааш нь зугатаасан байна. Энэ байдлыг харсан эргүүлийн цагдаа П үйлдлийг нь таслан зогсоохоор ойртож буугаа газарт тавихыг шаардахад “Чамайг буудна шүү, цаашаа бай” гэж хэлээд буудах мөчид, тусгай мэх хэрэглэн, үйлдлийг таслан зогсоосон байна.⁶⁵

Дээрх тохиолдолд Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар⁶⁶ цагдаагийн байгууллага нь алба хаагчыг албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж тусгай хэрэгсэл тавьж олгох үүрэгтэй. Цагдаагийн алба хаагчийн тусгай мэх хэрэглэх ур чадвараас өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хууль ёсны эрх ашиг ихээхэн хамааралтай байдаг ба судалгаанаас үзэхэд 31% нь алба хаагчын эсрэг, 67% нь иргэдийг хамгаалах үед, 12% нь бусад довтолгоон хийж байна. Мөн нийт довтолгооны 60% нь зэвсэггүй, 25% нь хүйтэн зэвсэг, 10% нь галт зэвсэг, 5% нь бусад зүйлс хэрэглэн довтолдог байна.⁶⁷ Хүч хэрэглэх эхний шат нь биеийн хүч хэрэглэх явдал бөгөөд гэмт хэрэг зөрчил үйлдсэн хүн цагдаагийн алба хаагчын хууль ёсны шаардлагыг эсэргүүцэл үзүүлэх үед биеийн хүчээр айлгаж сэтгэл зүйн дарамтанд оруулах, баривчлах, өөрийн хяналтанд оруулах зорилгоор хэрэглэдэг. АНУ-д цагдаагийн тусламж авахыг хүссэн

⁵⁹ Сонгино хайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол.УБ.,2010 оны 08 дугаар сарын 16-ны өдөр. 178.,21007135 дугаартай эрүүгийн хэрэг.

⁶⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам.УБ.,2016 он.№223.3 дэх хэсэг

⁶¹ Цагдаагийн албаны тухай хууль.УБ.,2017.,49 дүгээр зүйл

⁶² Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль.УБ.,2017.,18 дугаар зүйл

⁶³ Цагдаагийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх заавар.Монгол Улсын Ерөнхий Прокурор, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаал.УБ.,1994.,8 дугаар зүйл

⁶⁴ Цагдаагийн албаны тухай хууль.УБ.,2017.,50 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

⁶⁵ ЦЕГ.Сургамж өгсөн хэсэг бусад.УБ.,1993.,Л.Гаравсүрэн нарын эмхэтгэл.72 дахь тал

⁶⁶ Цагдаагийн албаны тухай хууль.УБ.,2017.,50 дугаар зүйлийн 5 дахь хэсэг


⁶⁷ Б.Батжав.Цагдаагийн алба хаагчын биеийн хүч хэрэглэх тусгай бэлтгэлийн сургалтын онолын үндэс.УБ.,2014.,64 дахь тал

10.000 дуудлага тутмын 3.61% нь хүч хэрэглэсэн ба⁶⁸ үүнээс 39% нь баривчлах ажиллагааны үед биеийн хүч хэрэглэсэн байна.

Баримт

2015 оны 04 сарын 02-ны өдрийн 19:30 цагийн үед ОХУ-аас Турк улсад суух элчин сайд Карлов Анкарагийн Орчин үеийн Урлагийн Төвд ирж, гэрэл зургийн үзэсгэлэнг нээсэн байна. Түүний нээлтийн үг минут ч хүрэхгүй хугацаанд үргэлжилсний дараа элчин сайдын ард зогсож байсан алуурчин халааснаасаа гар буу гаргаж, “Аллах Акбар” хэмээн орилж сайдыг араас нь нийтдээ 11 удаа буудсан байна. Үүний дараа алуурчин Сиритэй холбоотой үг хашгичиж тааз руу болон үймсэн хүмүүсийн зүгт хэд хэдэн удаа бууджээ⁶⁹. Түүнийг 25 минутын дараа Туркийн тусгай хүчнийхэн буудаж, амийг нь хөнөөсөн юм. Алуурчин нь 22 настай Мэвлют Мэрт Алтинтас гэгч цагдаагийн албан хаагч болохыг сүүлд тодруулжээ.


Энэ тохиолдолд Алтинтас нь бусад хүмүүсийн амь насанд халдаагүй, заналхийлээгүй, хэн нэгнийг барьцаалах гэж оролдоогүй, хүмүүсийг байшингаас гарахад саад болоогүйгээс үзэхэд түүний баруун мөр эсвэл аль нэг тулгуур эрхтэн, гарыг буудаж эсэргүүцэл үзүүлэх боломжгүй болгосны дараа амьдаар нь баривчлах ажиллагааг зохион байгуулах замаар баривчлах ажиллагааны механизм бэлэн байх учиртай. Түүний үйлдлийг хэн захиалсан, элчин сайдыг ямар зорилгоор алсан зэргийг тогтоох боломжыг алдсан үйлдэл болжээ. Энэ нь Туркийн тусгай хүчний алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дутмаг, магадгүй хэргийн ул мөрийг баллах, улс төрийн ашиг сонирхол, зохион байгуулалттай ажиллагаа байсныг ч үгүйсгэхгүй. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шууд баривчлах талаар ОХУ-ын Холбооны Аюулгүй байдлын Албаны Альфа тусгай бүлэгт ажиллаж байсан, бэлтгэл хурандаа Андрей Попов “Ямар нэг ажиллагааг бодит орчноос нь тусдаа алсаас дүгнэх нь үргэлж хэцүү байдаг”⁷⁰ гэснийг хүлээн зөвшөөрөх үндэстэй юм.



⁶⁸ Joel.H.Garner, Christopher D.Maxwell.Use of Force by Police.USA,NY.2005.,48 pg.

⁶⁹ www.mass.mn. 2015 оны 04 сарын 01-ны өдөр.

⁷⁰ Кадников Н.Г. Обстоятельства, исключющие преступность деяния.М., 1998.стр 65.



Судалгааны явцад цагдаагийн алба хаагчдаас дараахь санал өгсөн байна.

Тухайлбал иргэний эрх мэдэл нь хэт их байгаа болохоор ажил хийхэд хэцүү, алба хаагчийн аюулгүй байдал хангагдаагүй, хөнгөн гэмтэл учруулсан бол хариуцлага хүлээлгэхгүй байх, эрүүгийн хуульд биеийн хүч хэрэглэх талаар тодорхой заалт оруулах, амьдралд алба хаагч байнга бурууддаг, хариуцлага хүлээлгэдэг, эрх зүйн туслалцаа үзүүлэх газар байдаггүй, хамгаалах эрх зүйн орчин сул, зөвшөөрөл шаардаж цаг их алддаг, амь нас эрүүл мэндээрээ хохирч байна, тусгай хэрэгсэл хангалтгүй /104 алба хаагч/, хууль сахиулах байгууллагуудын хоорондын харилцаа муу, тавьсан шаардлагыг эсэргүүцэж өөртөө гэмтэл учруулдаг /232 алба хаагч/ гэж хариулсан байна. Дээрх судалгааны үр дүнг цагдаагийн 300 гаруй алба хаагчтай хийсэн ярилцлага, Тусгай ажиллагааны газрын 60 алба хаагчдад заасан сургалтын үр дүн ч дээрх нөхцөл байдлыг батлан харуулж байна.

Дүгнэлт

Хүмүүнлэгийн эрх зүйн салбарт “хамгаалагч бол шүүгч биш” гэж үзэх хандлага⁷¹ давамгайлах болсон бөгөөд энэ нь аливаа хууль бус үйлдлийн эсрэг өөрийгөө болон бусдыг хамгаалж буй тухайн нөхцөл байдалд хууль ёсны эсэх гэдгийг үнэлэх, дүгнэх боломжгүй гэж үздэгтэй холбоотой юм. Энэ үзэл хандлагын гол мөн чанар нь эрх бүхий этгээд хуулиар олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэх явцад гэмт этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг таслан зогсоож буй явдал нь бүх талаар хууль ёсны байх явдал юм.

Орчин үед хүний эрхийг дээдэлсэн үзэл хүчтэй хөгжиж байгаа өнөөгийн нийгэмд хууль сахиулагчын аливаа үйлдэл нь хууль ёсны байх, хүний жам ёсны эрхийг хөндөхгүй байх, хүний эрхийн талаар болон ёс зүйн хэм хэмжээг чанд сахидаг, ухамсар, соёл, хуулийн өндөр мэдрэмжтэй, ур чадвартай байхыг олон нийтийн зүгээс шаардаж байна.

Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үед галт зэвсэг, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ дараах үндсэн зарчмуудыг заавал баримтлана. Үүнд:

1. Хүний эрхийг хүндэтгэн хамгаалах.

Хүний эрхийн билл⁷², олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжид заасан хүний бүх эрхийг ялгаварлахгүйгээр хүндэтгэж хөндөхгүй байж, аливаа асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй оролцоно.

⁷¹ С.Л.Николаевна. Теория и практика задержания лица, совершившего преступление, с причинением ему вреда. Томск., 2003., 159 стр

⁷² НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1946 онд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, 1976 онд “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт”, 1966 онд “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, 1966 онд “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1 дүгээр протокол”, 1986 онд тус тус баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар протокол”-ыг Олон улсын хүний эрхийн билл гэж нэрлэдэг байна.

2.Цагдаагийн алба хаагчын эрх хэмжээ нь хүний эрхийн хэм хэмжээтэй тэнцвэртэй байх. Энэ нь баривчлах, таслан зогсоох үед нөхцөл байдлыг зөв үнэлж, дүгнэсэний үндсэн дээр шат дараалан хэрэгжүүлэх, хууль ёс, шудрага ёсны дагуу бүх талын аюулгүй байдлыг хангах эрх зүйн болон ёс суртахууны хамгаалалтаар хамгаалагдсан байна.

Орчин үед нийгэмд дэг журам тогтоох, олон нийтийн аюулгүй байдалд чиглэсэн бодлого их үгүйлэгдэж байна. Энэ нь олон улсын түвшинд шинэ “загвар” бий болгохыг шаардаж байна гэсэн үг юм. Ялангуяа цахим орчин дахь цагдаагийн алба хаагчын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, иргэд, олон нийтийн хандлагаас дүгнэж үзэхэд Цагдаагийн байгууллагаас мэргэжлийн өндөр ур чадвар, хууль ёсны ажиллагаа, хүний эрхийг дээдлэхийг шаардаж байна. Энэ нь нэг талаар нийгмийн хөгжил, олон улсын чиг хандлага, шинжлэх ухаан технологийн хөгжил дэвшил, иргэдийн эрх зүйн мэдлэг, өөрийгөө хамгаалах, илэрхийлэх чадвар өсч байгаатай холбоотой юм. Цагдаагийн байгууллагын хөгжил хүсэлтэд чиглэсэн бодлогоос ухаалгаар зохицуулах бодлого руу чиглэж, үүссэн нөхцөл байдлыг хамгаалахаас илүү урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад анхаарал хандуулж эхэлж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж “Төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, стратеги хөтөлбөр боловсруулагдаж, үүний хүрээнд томоохон ажлууд хийгдэнэ. Цагдаа, дотоод цэргийн албан хаагчид даргаасаа үлгэр дууриалал авдаг, ёс зүйг сахидаг, хуулиа чанд биелүүлдэг байх ёстой. Энэ бол өнөөдөр бидэнд тулгарч буй том асуудал шүү..... бид сахилга хариуцлага, ёс зүйг чандлан сахиж, шудрага ёсыг эрхэмлэн, оногдсон үүрэг, даалгаварыг сэтгэл, зүтгэл гарган биелүүлэх хэрэгтэй”⁷³ гэжээ.

Тийм учраас Цагдаагийн байгууллага дахь хариуцлагын тогтолцоо, бодлого, сэтгэлгээг өөрчлөх, алба хаагчдаа сургаж мэргэшүүлэх, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, гүйцэтгэлийн үр дүн, үнэлгээ, өндөр бүтээмжтэй байх, бүх шатанд сахилга хариуцлагыг чангатгах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах хэм хэмжээг хэрхэн хэрэглэж байгаа талаар шүүх, прокурорын байгууллагаас анкетын судалгаа авч нгэтгэн дүгнэлээ. Шүүхийн байгууллагаас авсан судалгаанд нийт 170 шүүгч оролцсон бөгөөд судалгааны дүнгээс үзэхэд 72% нь зайлшгүй өөрчлөх шаардлагтай, нарийвчлан зохицуулах нь зүйтэй гэсэн ба баривчлах, таслан зогсоох зорилгоор халдсан хэм хэмжээтэй холбоотой шийдвэрлэсэн хэргийн 82%-д нь ял шийтгэсэн гэжээ.

Шүүхийн практикт баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах ажиллагаатай холбоотой хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн эрх зүйн гол эх сурвалж болох эрүүгийн хуулийг тэр бүр хэрэглэдэггүй болох нь доорх баримаас харж болох юм. Өрөөр хэлбэл тухайн хэрэгт хамаарах хэм хэмжээний зохицуулалтыг шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүүтэй байдлаар шийдвэрлэж байна гэсэн үг юм. Хуульчид зөвхөн хэм хэмжээний эрх зүй буюу онолыг судлах бус харин тухайн хэргийг шийдвэрлэхэд хэм хэмжээг зөв тайлбарлаж хэрэглэхэд мөн суралцах ёстой ба ингэснээр онол практикийн уялдаа, хууль хэрэглээний нэгдмэл практик тогтооход чухал ач холбогдолтой юм.

Баримт

Баянзүрх дүүргийн Цагдаагийн ..дугаар хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа О нь үүрэг гүйцэтгэж байхдаа 2016 оны 08 дугаар сарын 23-24-нд шилжих шөнө Маахуур толгойд дуудлагаар очихдоо согтууруулах ундаа хэрэглэсэн Т-г цагдаагийн алба хаагчын таавсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн гэх шалтгаанаар биеийн хүч хэрэглэж хохирогчын биед хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэрэгт холбогджээ⁷⁴.

Шүүх О-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгохдоо эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлийг баримтлан хэрэгсэхгүй болгожээ.

Баримт

Б нь 2015 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл дотор хохирогч Ю өөрийг нь хутгалж

⁷³ Цагдаа дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны сургалт зөвлөгөөн.2017 оны 12 сарын 26

⁷⁴ Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн цагаатгах тогтоол.УБ.,2017.05 сарын 01.,№93.,201625013327 дугаартай, 105/2017/0035/Э индекстэй эрүүгийн хэрэг.

довтолсны улмаас санаа сэтгэл нь цочрон давчидсан үедээ Ю-г хутгалж алсан гэх гэмт хэрэгт холбогджээ⁷⁵.

Баянгол дүүргийн шүүхээс Б-д холбогдох эрүүгийн хэргийг эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан аргагүй хамгаалалтын нөхцөл байдал гэж үзэн хэрэгсэхгүй болгохдоо эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 40 дүгээр зүйл, эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн /тухайн үеийн нэрээр/ 24.1.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ. Дээрх хоёр тохиолдолд эрүүгийн процессын хуулийн, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, шинжгүй гэх үндэслэлийг баримталсан нь хууль хэрэглээний хувьд буруу болжээ.

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын үед хийсэн үйлдлийг хэрэгсэхгүй болгохдоо эрүүгийн процессын хуулийн дээрх хэм хэмжээг баримтлан хэрэгсэхгүй болгодог практик нэгэнт тогтсон байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэсэн ойлголтууд нь хууль зүйн үр дагаварын хувьд ижил төсөөтэй боловч онолын хувьд өөр ойлголтууд юм. Дээрх ойлголтуудын талаар Хууль зүйн доктор /Ph.D/ Г.Гантөмөр:⁷⁶ “Академич С.Нарангэрэл:”Гэмт хэргийн бүрэлдэхүүн бол тодорхой гэмт хэргийн эрүүгийн хуулиар тогтоосон объектив, субъектив шинжийн нийлбэр мөн”⁷⁶, “тодорхой этгээдэд гэм хор учруулсан боловч нийгэмд аюултай гэмт хэрэг хэмээн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй онцлог нөхцөл байдлыг ойлгоно”⁷⁷ гэж тус тус тодорхойлсоноос дүгнэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэдэг нь гэмт хэргийн шинжээс ямар нэг шинж нь байхгүй буюу эрүүгийн хуульд заагаагүй, гэм буруугүй, нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүй юм. Тэгвэл гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэдэг нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй боловч нийгэмд ашигтай зорилгоор хийгдсэн учир нийгэмд аюултай шинжийг үгүйсгэж байгаа явдал юм.

Тэгэхээр шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тогтоол гаргахдаа гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй, огт гэмт хэргийн шинжгүй үйлдэл, эс үйлдэхүйг хооронд ялгаж зааглахгүйгээр хуулийг хэрэглэж байгаа нь онолын мэдлэг, хууль хэрэглээний хувьд учир дутагдалтай байна гэж дүгнэж болохоор байна.

Баримт

Цагдаагийн алба хаагч П нь 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдөр албан үүргээ гүйцэтгэж явах үедээ Соната-2 маркийн тээврийн хэрэгслээр, хохирогч А-ын жолоодож явсан улсын дугааргүй мотоциклийг хөөж явах үедээ хохирогчид хүнд гэмтэл учруулсан гэх үндэслэлээр шүүх гэм буруутайд тооцон түүнд эрүүгийн хуулийн тусгай ангийн 215 дугаар зүйлийн 215.2 дэх хэсэгт зааснаар жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасч, гурван сар 10 хоногийн хугацаагаар баривчлах ялаар шийтгэжээ⁷⁸.

А нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхгүй, улсын дугааргүй, хамгаалах малгайгүй, Замын хөдөлгөөний дүрмийн заалтыг⁷⁹ зөрчиж тогтоосон тооноос илүү хүн тээвэрлэсэн, хурд хэтрүүлж явсан байна. Мөн замын хөдөлгөөний дүрмийн 2.3-ын “и”, 2.1 дэх хэсэг, 21.8-ын “а”-д тус тус зааснаар цагдаагийн алба хаагчын дохиогоор зогсох, баримт бичгээ шалгуулах, тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтоор тогтоосон тооноос олон хүн тээвэрлэхийг, замын хөдөлгөөнд оролцохдоо бусдад аюул хохирол учруулахгүй, хөдөлгөөнд саад бэрхшээл, осолтой байдал бий болгохгүйгээр зорчих заалтуудыг зөрчсөн байна.

А-ын үйлдэл нь бүх талаараа хууль бус үйлдэл үйлдэл бөгөөд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, таслан зогсоох үүрэгтэй цагдаагийн алба хаагчын тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэн зугатаасан А-ын үйлдлийг таслан зогсоож байгаа үйлдэл нь хууль ёсны ажиллагаа юм. Гэтэл цагдаагийн алба хаагчыг хууль, тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу албаны үүргээ гүйцэтгэж, хууль бус үйлдлийг таслан зогсоосны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа явдал нь үндэслэлгүй юм. П нь тухайн өдөр үүрэг гүйцэтгэж байх явцад зөрчилтэй тээврийн хэрэгсэл унаж явсан А-г тээврийн хэрэгсэл албадан зогсоох зааварт заасны дагуудохиур модоор дохио өгсөн, зугатаах үед тээврийн

⁷⁵ Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн цагаатгах тогтоол.УБ.2017.,11 дүгээр с арын 28-ны өдөр №46.,201526022112 дугаартай эрүүгийн хэрэг.

⁷⁶ С.Нарангэрэл.Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий анги.УБ.,1996.,94 дахь тал.

⁷⁷ Дурдсан бүтээл.174 дахь тал.

⁷⁸ Хөвсгөл аймгийн сум дундын эрүүгийн хэргийн шүүхийн шийтгэх тогтоол.УБ., 2012 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр.Дугаар 141.201222000337 дугаартай эрүүгийн хэрэг.

⁷⁹ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм.УБ.,2016.,2.2 а, 2.3 в хэсэг.

хэрэгслээр хөөж, чанга яригчаар шаардлага тавьсан боловч биелүүлээгүй тул уг тээврийн хэрэгслийг гүйцэн зэрэгцэж замын зах руу шахан урдуур нь хөндлөн зогссон нь Тээврийн хэрэгсэл албадан зогсоох зааврын⁸⁰ 2."б"-д заасан хууль ёсны үйлдэл байжээ.

Баримт

2015 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Завхан аймгийн Тосон цэнгэл сумын нутаг дэвсгэрт мотоциклтэй явж байсан В-г, замын хөдөлгөөнийг зохицуулах үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн алба хаагч С нь зогсох дохио өгсөн боловч В-нь зугатаасан тул С түүний үйлдлийг таслан зогсоохоор албаны машинаар хөөх үед мотоциклтэй унаж хүндэвтэр гэмтэл учирсан байна⁸¹. Хохирогч В нь Цагдаагийн байгууллага болон иргэний хэргийн анхан шатны шүүхэд эрүүл мэндэд учирсан хохиролд 3.000.000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан байна.

Шүүхээс Цагдаагийн алба хаагч С нь тухайн өдөр албаны үүрэгт ажлаа⁸² гүйцэтгэж явсан, В-ын үйлдлийг таслан зогсоосон үйлдэл нь хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу хэрэгжүүлсэн, хууль ёсны үйлдэл байсан тул Иргэний хуульд⁸³ зааснаар төрийн албан хаагчийн бусдад учруулсан гэм хорыг төр хариуцаж арилгахаар шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагыг учирсан гэм хорыг арилгуулахаар шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй шийдвэр болжээ. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт зааснаар хохирогч өөрөө санаатай гэм буруутай үйлдлийн улмаас, үүсч болох хохиролоос урьдчилан сэргийлэх оролдлого хийгээгүйгээс өөрт нь гэм хор учирсан бол холбогдох байгууллагыг хариуцлагаас чөлөөлж болох талаар заасан учраас Цагдаагийн байгууллага учирсан гэм хорыг арилгах үүрэг хүлээхгүй.

4.Санал

Судалгааныхаа үр дүнд түшиглэн баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах институтийн талаарх цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчын мэдлэг, практик хэрэглээнд дүгнэлт хийж цаашид алба хаагч, иргэдийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх, хүний эрхийг хангах баталгааг дээшлүүлэх үүднээс тодорхой саналуудыг боловсруулсан юм.

1.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах явцад хохирол учруулах явдлаас ямагт урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан тооцоолоогүй шинэ нөхцөл байдал, эрсдлийг тооцоолох;

2.Баривчлах, таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хууль сахиулагч нь тухайн үеийн нөхцөл байдлыг үнэн зөв, бодитой үнэлэх, үйл ажиллагаагаа баримтжуулах, тайлагнах, гарцаагүй нөхцөл байдалд тулгуурлах, тэнцвэрт байдлыг хангаж ажиллах;

3.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах явцад биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэхдээ шат дараалан хэрэгжүүлэх. Тухайлбал хүч хэрэглэх талаар анхааруулах, гарах үр дагаварыг тайлбарлан таниулах, бодох хугацааг тооцоолох, сануулах, хүч хэрэглэхгүйгээр халдах, биеийн хүч, тусгай хэрэгсэл, шаардлагтай тохиолдолд амь насанд аюулгүй галт зэвсэг хэрэглэх гэх мэт.

4.Хамгийн бага хохирол учруулахуйц арга хэлбэрийг сонгох, энгийн иргэд хохирохоос урьдчилан сэргийлэх, тухайн нөхцөл байдлын эхлэл, өрнөл, төсгөл үеийн тактикийг зөв хувиарлах, нутаг дэвсгэрийн онцлог, байршил, улирал цаг агаар, өдөр, шөнө, хүрээлэн буй орчин, хүн хүч нөөц бололцоо, зохион байгуулалт, ур чадвар зэргийг харгалзан баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах явцадаа урьдчилан тооцоолж сэтгэл санаа, эрүүл мэнд, нас хүйс, зан төлөв, зэвсэг хэрэгсэл байгаа эсэх, өөр сонголт хийх боломж байгаа эсэх, тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, бие бялдарын хувьд бэлэн, өөрийн үйл ажиллагаанд итгэл, үнэмшилтэй байх;

⁸⁰ Тээврийн хэрэгсэл албадан зогсоох заавар. Хууль зүйн сайдын тушаал.УБ.1999.73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

⁸¹ Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын тогтоол.Завхан.,2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр. 5/172.

⁸² Цагдаагийн хэлтсийн жижүүр, эргүүл, саатуулах, баривчлах байранд ажиллах алба хаагчдын томилгоо.Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Цагдаагийн хэлтсийн даргын тушаал.Завхан.2015.,08 дугаар сарын 01-ний өдөр.№ 172

⁸³ Иргэний хууль.УБ.,2002. 498 дугаар зүйл.

5. 1972 онд Нью-Йорк хотын цагдаагийн мөрдөгч [Harvey Schlossberg](#) орчин үеийн цагдаагийн байгууллагын хэлэлцээрийн үндэсийг анх үндэслэсэн⁸⁴ бөгөөд баривчлах, саатуулах ажиллагааны үед цагдаагийн алба хаагч нар сэтгэл зүйн бэлтгэлтэй байх ёстой гэдгийг сэтгэл зүйчид хүлээн зөвшөөрсөн юм. Орчин үед олон нийтийн аюулгүй байдалд заналхийлсэн гэмт хэрэгтэнийг баривчлах, саатуулах ажиллагаанд хэлэлцээрийн баг оролцуулах хандлага давамгайлах боллоо. Баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэхдээ гэмт этгээдтэй удаан хугацаанд ярилцах нь хамгийн үр дүнтэй арга ба гэмт этгээдийн сэтгэл хөөрөл, шийдэмгий байдлыг өөрчлөх, тайвшруулах, сэтгэл санаа, зорилгыг эргэлзүүлэх, гэмших, бодох, айх зэрэг байдалд хүргэдэг ба 95%-ийн ач холбогдолтой учраас аль болох гэмт этгээдийн нэг адил сэтгэл хөөрөлд автахгүй байх;

6. Албан хаагчдыг олон удаагийн давтамжтай сургалтанд хамруулах, мэдлэг олгох, хяналт шалгалтыг сайжруулах, мэдлэг мэдээлэлээр хангах, чадваржуулах, үнэлэх, удирдлагын алба хаагчдадаа хандаж буй хандлагыг өөрчлөх, хууль ёсны үйлдэл хийсэн алба хаагчыг бүх шатанд хамгаалах, өөрийн албандаа итгэл үнэмшилтэй болох, тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангах, иргэдийн дунд байгаа сөрөг хандлагыг өөрчлөх, цагдаагийн болон бусад тусгай албадын нэр хүндийг өсгөх ажлыг бодлогын түвшинд хэрэгжүүлэх;

7. Хууль сахиулагчын эрх ашгийг хамгаалах бүтэц нэгжийг бий болгох, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хамтран ажиллах, гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг нэмэгдүүлэх, урамшуулах, хууль тогтоомж, ёс зүйг чанд сахих;

8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлд "Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон" гэж нэмэлт өөрчлөлт оруулах;

9. Удирдлагын албан хаагчдад хандах хандлагыг өөрчлөх, үргэлжилсэн, мэргэшүүлэх сургалтын чанарыг дээшлүүлэх, чадваржуулах сургалтыг онол, практиктай хослуулан үе шаттай зохион байгуулах шаардлагтай байна.

⁸⁴. Strentz, Thomas (2006). Psychological aspects of crisis negotiation. CRC Press, [ISBN 978-0-8493-3997-4](#) pg

МОНГОЛ УЛСАД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ОНОГДУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

*Б.Одонгэрэл
ШЕЗ-ийн Шүүгчийн хараат бус байдлыг
хамгаалах хэлтсийн дарга*

Удиртгал

Монгол Улсад 1990 оноос өрнөсөн улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт нь эдийн засгийн боловсронгуй болгох, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх явдал чухлаар тавигдаж, Монгол Улсын Үндсэн хууль болон эдийн засаг, өмчийн харилцаа, банк санхүү болон аж ахуйн үйл ажиллагааг зохицуулсан олон хуулиудыг шинээр баталсан. Ингэснээр эдийн засгийн харилцаа үндсээрээ өөрчлөгдөн өмчийн олон хэлбэр, түүнд суурилсан аж ахуйн нэгжүүд бий болж жижиг, дунд үйлдвэрлэл хөгжихийн хэрээр дотоодын хөрөнгө оруулалт, үндэсний үйлдвэрлэл нэмэгдэн, үндэсний томоохон компаниуд, групп, корпорациуд бий болж эдийн засагт голлох үүрэг гүйцэтгэх болсон. Мөн эдийн засаг нээлттэй болж эдийн засгийн гадаад харилцаа хөгжихийн хирээр гадаадын хөрөнгө оруулалт өсч, хамтарсан болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд болон үндэстэн дамжсан олон улсын корпорациуд эдийн засагт оролцох оролцоо нэмэгдэж байна. Хэдий аж ахуйн нэгжүүд эдийн засгийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн банк, санхүү, даатгал, үнэт цаас болон үйлдвэрлэл үйлчилгээ зэрэг аж ахуйн нэгж, компаниудын хууль тогтоомж зөрчих тухайлбал татвараас зайлсхийх, мөнгө угаах, зах зээлд шударга бусаар өрсөлдөх, хэрэглэгчдийг хуурах, үгсэн хуйвалдаж үнэ хөөрөгдөж хэрэглэгчдийг хохироох, чанар муутай, стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, чанар муутай барилга барих, ашиглалтанд оруулах, байгалийн баялагийн хууль бусаар ашиглах, байгаль орчныг бохирдуулах гэх мэт хууль бус үйлдлүүд хийж нийгэмд, иргэдэд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргүүд олноор үйлдэгдэж байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд төдийгүй энгийн иргэдийн дунд яригдах болсоор даруй 10 гаруй жилийн нүүрийг үзэж байна. Монгол Улсад 2015 онд батлагдаж 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж буй Эрүүгийн хуульд анх удаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах заалт батлагдсан нь эрх зүй, эдийн засаг, нийгмийн томоохон ач холбогдол бүхий өөрчлөлтийг авчирч байна. Өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуулиар яригдаж байсан ч дэмжлэг авч чадаагүй энэ асуудал 2008 оноос эхлэн Монгол Улсад судлаачдын дунд хүчтэйгээр яригдах болж улмаар 2010 оны 9 сард Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгуулж байсан түүхтэй.

Үнэндээ хуулийн этгээдэд захиргааны болон иргэний хариуцлага бус заавал эрүүгийн хариуцлага оногдуулах зорилго нь чухам яг юу юм бэ гэсэн асуулт судлаачдын дунд байнга гарч ирдэг. Гэтэл үнэндээ бол энэ яг эцсийн зорилго юм гэсэн нэгдсэн, иж бүрэн онолын тодорхойлолт бол байдаггүй. Харин ял шийтгэлийн үндсэн 4 төрлийн онолд түшиглэсээр ирсэн нь нэгдүгээрт урьдчилан сэргийлэх, хоёрдугаарт хохирол нөхөн төлүүлэх, гуравдугаарт залхаан цээрлүүлэх, дөрөвдүгээрт сургах, хүмүүжүүлэх. 1 буюу урьдчилан сэргийлэх бол компанийн гэмт хэрэгт эрүүгийн ял шийтгэл хэрэглэх нэн тэргүүний үндэслэл болдог. Судлаачид, шүүгчид болон хууль сахиулагчид, түүнчлэн хууль тогтоогчид эрүүгийн ял шийтгэл бол айлган сүрдүүлэх байдлаар ирээдүйд хийгдэх гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн зорилготой хууль тогтоох арга хэрэгсэл гэсэн үзэл бодолд нэгддэг.

Хуулийн этгээдэд ял шийтгэл оногдуулж буй бас нэг шалтгаан бол олон нийтэд зарлаж, тэднийг “ичээх” явдал юм. Энэ нь компаниуд өөрсдийн ивээн тэтгэгчид түүнчлэн хэрэглэгчдэдээ өөрсдийн ичгүүрт үйлдлийг мэдэгдэхийг хүсдэггүйтэй холбоотой. Аливаа бизнесийн байгууллага өөрсдийн нэр хүндийг өндөр авч явахад их ач холбогдол өгдөг, энэ нь тэдний ашиг орлогод нөлөөлнө хэмээн үздэг тул ял шийтгэл ноогдуулах арга үр нөлөөтэй. Компанийн гэмт хэрэгт шийтгэл оноох нь тухай компанийн ёс суртахууныг дээшлүүлэх төдийгүй, тэдгээрийн удирдлагуудын ёс суртахуунд асар ихээр нөлөөлдөг.

Хуулийн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлага

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага ноогдуулах асуудалд эрх зүйн систем харгалзахгүйгээр улс орнуудад өөрийн гэсэн байр сууринаас хандсаар ирсэн юм. Одоогоор АНУ, Англи, Австрали, Канад, Ирланд, Энэтхэг, Франц, Швейцари, Япон, Хятад, Өмнөд Солонгос, Бельги, Голланд, Дани, Финланд, Индонез, ӨАБНУ, Шинэ Зейланд, Недерланд, Норвеги, Молдав, Эстони, Латви ... зэрэг дэлхийн 50 гаруй улсууд өөр өөрийн арга хандлагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагыг хүлээлгэж байна. Эх газрын эрх зүйн системтэй орнуудын хувьд хувь хүний гэм бурууг үндэслэсэн эрүүгийн зарчмыг баримталдаг учраас эдгээр улсуудад энэ асуудал урт хугацааны туршид шүүмжлэлтэй тулгарсаар ирсэн. Гэсэн хэдий боловч эх газрын эрх зүйн системтэй орнуудын хувьд Франц, Голланд, Швейцари, Дани, Бельги, Япон, БНХАУ зэрэг олон улс орон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байна.

Энэхүү улсууд эрүүгийн хариуцлагыг ноогдуулахдаа өөр өөрийн эрх зүйн онцлог, арга хандлагаар ханддаг бөгөөд тухайлбал Англи улс тусгайлсан хуультай бол АНУ, Франц, Австрали зэрэг ихэнх улс орнууд тус улсын эрүүгийн хуульд тусгайлан заажээ. Харин Япон Сингапур зэрэг зарим улсад бусад хууль тогтоомжоороо зохицуулсан байна. Япон улсын Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар хуульчилж өгөөгүй хэдий ч бусад хуулиндаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах талаар заасан байдаг. Тухайлбал, Шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах хууль, Компанийн татварын хууль зэрэг 500 орчим хууль тогтоомжиндоо хувь хүн болон хуулийн этгээдэд аль алинд нь эрүүгийн хариуцлагын торгох ялыг ноогдуулна гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагын торгох ялыг харин хувь хүнд мөн торгох, хорих зэрэг эрүүгийн бусад ялыг ноогдуулж давхар шийтгэдгээрээ онцлогтой юм. Мөн Японы Дээд Шүүх компанийн удирдлага нь өөрийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх бодлого, тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж байх ёстой гэсэн шийдвэр гаргасан бөгөөд хэрвээ тийм бодлого баримтлаагүй болон түүнийгээ шинэчлэн сайжруулаагүйгээс болоод гэмт хэрэг үйлдэгдсэн байвал тэр нь хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл мөн гэж үздэг байна.

Олон улсын түвшинд буюу олон улсын болон бүсийн гэрээ конвенцид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх дотоодын хууль тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэх талаар авч үзэх түүнчлэн энэ талаар улс орнуудад үүрэг хүлээлгэсэн заалтыг олноор агуулах болжээ. Тухайлбал, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (10 дугаар зүйл), Авилгын эсрэг НҮБ-ын конвенц (26 дугаар зүйл), гадаадын төрийн албан тушаалтны хээл хахуультай тэмцэх эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын конвенц (2 дугаар зүйл), авилгын талаархи Европын консулын эрүүгийн хуулийн конвенц (18 дугаар зүйл), Гэмт хэргээс үүдсэн мөнгө угаах, нэгжлэг хийх, эд хөрөнгө хураах, улсын орлого болгох болон терроризмыг санхүүжүүлэх Европын консулын конвенц (10 дугаар зүйл) зэрэг конвенцид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэвэл зохих заалтыг агуулсан байна. Тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 26 дугаар зүйлд оролцогч улс бүр эрх зүйн зарчимдаа нийцүүлэн энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хуулийн этгээдэд хариуцлага тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна гээд оролцогч улсын эрх зүйн зарчмуудаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага эрүүгийн, иргэний буюу захиргааны байж болно гэжээ. Түүнчлэн ийм хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүний эрүүгийн хариуцлагыг хөндөхгүй бөгөөд оролцогч улс бүр ялангуяа энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд үр дүнтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг хийхгүй байлгах эрүүгийн буюу эрүүгийн бус шийтгэл, түүний дотор мөнгөн торгуулийн шийтгэл ногдуулна гэсэн байдаг.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэлийг хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө Эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа эсвэл хамтран шийдвэр гаргаж үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байхыг ойлгоно⁸⁵ гэжээ. Эрүүгийн хуулийн энэ заалтаас үзэхэд

⁸⁵ Онолын хувьд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэдэг нь хуулийн этгээд тухайн хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө түүний өмнөөс хийсэн хувь хүний гэмт үйлдлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээх субъект болох явдлыг хэлдэг бөгөөд үүсмэл хариуцлага болон байгууллагын хариуцлага гэсэн 2 төрөлд ангилдаг. Үүсмэл хариуцлагыг төлөөлөн хүлээлгэх (АНУ), адилтгалын хариуцлага (Англи улс) гэж ангилна.

манай улс Англи улсын жишгээр буюу адилтгалын загвараар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.⁸⁶

Тус хуулийн ерөнхий ангийн шударга ёсны зарчимд “хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна”⁸⁷ гэж давхар ял шийтгэлийн зарчмыг баримтлахгүй хуулийн этгээдэд ял оногдуулсан бол тухайн хувь хүнийг ялаас чөлөөлөхөөр тусгасан байсан. Харин 2017 оны 5 дугаар сард УИХ-аар баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлалд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх олон улсын байгууллагын шинэчилсэн 40 зөвлөмжийн гуравдугаарт “хувь хүнд хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар хуульд тусгах шаардлагатай”⁸⁸ гэснийг дурдаж манай улс давхар хариуцлагын тогтолцоог Япон улс, БНХАУ зэрэг улсуудтай нэгэн адилаар хуульчиллаа. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон Авилгын эсрэг НҮБ-ын Конвенцийн 26 дугаар зүйлд оролцогч улс бүр эрх зүйн зарчимдаа нийцүүлэн энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэрэгт оролцсон хуулийн этгээдэд хариуцлага тогтооход шаардлагатай байж болох арга хэмжээг авна гээд оролцогч улсын эрх зүйн зарчмуудаас хамааран хуулийн этгээдийн хариуцлага эрүүгийн, иргэний буюу захиргааны байж болно гэжээ. Түүнчлэн ийм хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүний эрүүгийн хариуцлагыг хөндөхгүй бөгөөд оролцогч улс бүр ялангуяа энэ зүйлийн дагуу хариуцлага хүлээх хуулийн этгээдэд үр дүнтэй, тухайн үйлдэлд тохирох, тухайн үйлдлийг хийхгүй байлгах эрүүгийн буюу эрүүгийн бус шийтгэл, түүний дотор мөнгөн торгуулийн шийтгэл ногдуулна гэсэн байдаг.⁸⁹

Эрүүгийн хариуцлагын төрөл

Дэлхийн улс орнуудад хуулийн этгээдэд нилээд олон төрлийн ял оногдуулж буй жишиг байна. Тухайлбал, торгох, үйл ажиллагааг нь хугацаатай болон хугацаагүйгээр хязгаарлах, эрхийг нь хасах, татан буулгах, зэрэг. Одоогийн байдлаар АНУ корпорацид харьцангуй олон төрлийн ял шийтгэлийг оногдуулж байгаагаараа, мөн ямар ч төрлийн ажилтныхаа өмнөөс хариуцлага хүлээнэ гэсэн чиг хандлагыг баримталдгаараа ихээхэн үр нөлөөтэй гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, АНУ-ын Эрүүгийн хуульд торгох, үйл ажиллагааг нь хориглох, татан буулгах, нөхөн төлбөр төлүүлэх, эрхийг нь хураах, эрхийг нь хүчингүй болгох гэсэн зургаан төрлийн шийтгэлийг оногдуулдаг байна. Харин Хятад, Япон зэрэг улсад хуулийн этгээдэд зөвхөн торгох ялыг оногдуулдаг бол Франц улсын хувьд торгох, татан буулгаж үйл ажиллагааг нь зогсоох, хугацаатай ба хугацаагүйгээр үйл ажиллагааг нь зогсоох, шүүхийн хяналт тогтоох, тодорхой санхүүгийн үйл ажиллагаа явуулахыг хориглох, нийтэд тухайн хуулийн этгээдэд ял оноосон тогтоолыг мэдээлэх, эд хөрөнгө хураах зэрэг олон төрлийн уян хатан шинжтэй ялыг оногдуулдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хуулийн этгээдэд торгох ял оногдуулахаар хуульчилсан ба шүүх хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн. Эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

1. эрх хасах албадлагын арга хэмжээ;
2. татан буулгах арга хэмжээ;
3. хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Ингэхдээ эдийн засгийн 28 төрлийн гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, хуулийн этгээдэд оногдуулах торгох ялыг үндсэн, эрх хасах болон бусад албадлагын арга хэмжээг нэмэгдлээр хэрэглэхээр хуульчилсан. Үүнд:

⁸⁶ Адилтгалын хариуцлага нь зөвхөн удирдах түвшний ажилтны хийсэн үйлдэлд компани хариуцлага хүлээдэг. Жишээ нь: Англи, Австрали, Канад гэх зэрэг зарим улс зөвхөн гүйцэтгэх захирал болон ахлах менежер зэрэг удирдах түвшний ажилтны гэмт үйлдлийн төлөө корпораци эрүүгийн хариуцлага хүлээдгээрээ харьцангуй хязгаарлагдмал шинжтэй гэж үзэж болох юм.

⁸⁷ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг.

⁸⁸ Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, 2017 он <http://mojha.gov.mn/uixd-huuli-tusul.html>

⁸⁹ Монгол Улсын нэгдэн орсон хэд хэдэн гэрээ конвенцид ийм заалт байгааг анхаарах нь зүйтэй.

8 төрлийн гэмт хэрэгт 10.000 нэгжээс -80.000 нэгжээр (Энэ хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.) торгох,
6 гэмт хэрэгт 20.000 нэгжээс-120.000 нэгжээр торгох,
4 төрлийн гэмт хэрэгт 40.000 нэгжээс-200.000 нэгжээр торгох
6 төрлийн гэмт хэрэгт 120.000 нэгжээс -400.000 нэгжээр торгох
3 төрлийн гэмт хэрэгт 200.000 нэгжээс-400.000 нэгжээр торгох оногдуулахаар Эрүүгийн хуульд хуульчилсан байна.

Харин үйл ажиллагаа явуулах эрх хасах нэмэгдэл ялыг 23 төрлийн гэмт хэрэгт заавал оногдуулахаар хуульд тусгаж, 7 төрлийн гэмт хэрэгт эрх хасах нэмэгдэл ялыг тусгайлан заагаагүй, 2 төрлийн гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийн татан буулгахаар зохицуулжээ.

1. Торгох ял

Торгох ял нь хуулийн этгээдэд хамгийн тохирсон ялын нэг юм. Гэхдээ торгох ялын үр нөлөө нь торгуулийн хэмжээ нь тэдэнд “хүнд цохилт” болохоор буюу гэмт хэрэг үйлдээд олсон орлогоос хэд дахин илүү байж ач холбогдолтой байх юм. Торгох ялын хэмжээ нь манай улсын Эрүүгийн хуулиар “энэ хуульд заасан тохиолдолд арван мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”⁹⁰ гэж тогтоогджээ. Нэг нэгж нь 1000 төгрөгтэй тэнцэнэ гэж үзвэл энэ нь 10 сая-400 сая хүртэл төгрөг байх юм. Харин хувь хүнд нэг зуун нэгжээс дөчин мянган нэгжээр торгох ял оногдуулж байна. Тухайлбал, нэг компани хууль зөрчөөд олсон ашиг нь жилд 500 сая гэж үзье. Гэтэл шүүхээс 50 сая төгрөгийн торгох ял оногдуулбал, энэ нь ашгийн 10 хувийг л торгуульд өгөх тооцоо гарч байна. Ийм үр дүнтэй байхад компани хууль бус үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх сонирхолтой байх нь тодорхой. Тэгвэл энэ төрлийн гэмт хэргийг тогтоон барихын тулд торгуулийн хэмжээг хууль зөрчиж олсон ашгаас нь 1-10 дахин их байхаар хуульчилж байж ял шийтгэл зорилгоо биелүүлэх юм. Манай жишээгээр бол дор хаяж 1 тэрбумын торгууль оногдуулах шаардлагатай. Гэхдээ энд анхаарах нэг зүйл нь тухайн компани нь торгуулиа даахгүй дампуурч болох эрсдэлтэй гэдгийг мартаж болохгүй. Энэ талаар Жон Коффее 1981 онд “гэмт хэрэг бууруулах арга” хэмээх бүтээлдээ дурдсан байдаг. Тэрээр гэмт хэрэг, зөрчил үйлдсэн үйлдвэрүүдэд өндөр хэмжээний торгууль оногдуулах нь тэдний өрсөлдөх чадвар ихээхэн нөлөөлдөг буюу сул талыг бий болгодог гэсэн байдаг. Иймд торгох ял гэмт хэргийг бууруулахад үр нөлөөтэй боловч “Just deserts” буюу гэмт хэрэг, ял 2 тохирсон байх зарчимтай зөрчилдөж болохгүй юм.

Үүнтэй холбоотой нэгэн жишээг авч үзье. Англи болон Уэльсд 1999 онд “Хове болон Сон” инженерийн компанийн хэргийг шүүхээр шийдүүлэх хүртэл торгуулийн хэмжээ бага байсан. Уг хэрэг нь тус компанийн ажилтан цэвэрлэгээ хийж байгаад цахилгаанд цохиулан нас барсан ба компани 48000 фунтээр торгуулжээ. Тухайн үед тус компани торгуулийн хэмжээ их байна хэмээн бууруулахыг шүүхээс хүсч байжээ. Энэ торгуулийг оноохдоо шүүх маш олон хүчин зүйлийг авч үзсэн байдаг. Энэ хэрэг явдлаас хойш Английн шүүх торгууль оногдуулахдаа дараах хэдэн хүчин зүйлийг харгалзан үзэж байхаар шийдвэрлэсэн байдаг.

- Гэмт хэргийн хэр хэмжээ;
- Мөрдөх ёстой стандартаас хэдий хэмжээгээр зөрсөн;
- Эрсдэлийн зэрэг аюулын хэмжээ;
- Санаатай үйлдсэн эсэх;
- Гэмт хэргийн давтамж;
- Гэмт хэрэгтэний хөрөнгө нөөцийн хэмжээ;
- Гэмт хэрэгтэний бизнест үзүүлэх торгуулийн нөлөө зэрэг.

Тэгвэл Австралид нэг ижил гэмт хэрэгт хувь хүнд ноогдох торгуулийг 5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр компанийг торгодог жишиг байдаг.

Үүнээс үзвэл шүүх торгох ял оногдуулахдаа ялын үр нөлөөтэй байх явдлыг нэгдүгээрт анхаарах боловч тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэргийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, давтан үйлдсэн эсэх, тухайн гэмт хэрэгтэн хуулийн этгээдийн хөрөнгийн байдал, түүний бизнес цаашид үргэлжлэхэд үзүүлэх үр нөлөө зэргийг харгалзан үзэж байх нь зүйтэй.

⁹⁰ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 9.3 дугаар зүйл.

2. Эрх хасах албадлагын арга хэмжээ

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д “энэ хуульд заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах албадлагын арга хэмжээ оногдуулна”⁹¹ гэжээ.

Нийгэмд аюул занал учруулсан учраас аливаа этгээдэд ял шийтгэл оноодог. Орчин үед хорих хэлбэр илүү хэрэгжиж буй бөгөөд нийгэмд учруулах аюулын хэр хэмжээнээс хоригдох хугацаа хамаарна. Тэгвэл компанийн гэмт хэрэгт ямар шийтгэл тохиромжтой вэ? Мэдээж компани физилогийн биет биш учраас хоригдож чадахгүй нь тодорхой. Харин хорих ялтай дүйх ял нь гэмт үйлдлийг нь нийгмээс тусгаарлах буюу үйл ажиллагаа явуулах эрхийг нь хасах явдал юм. Өөрөөр хэлбэл, компанийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь хассанаар тодорхой гэмт үйлдлүүдийг хориглож хязгаарлаж болно. Харин гэмт үйлдэлээ засч залруулахад нь эрхийг нь буцаан сэргээж болно. Мөн дээр нь хууль дагаж мөрдөж буй олон нийт дунд хэн яагаад хууль зөрчөөд байна вэ гэдэг компанийн гэмт хэрэгтэй ижил анхаарах чухал ёстой асуудал. Компанийн хандлагад шинэчлэл хийх нь гэмт хэрэгтэн бие хүний төрөлхийн занг өөрчлөн засахаас илүү хялбар байх нь мэдээж юм. Түүнчлэн компанийн үйл ажиллагаа явуулах хандлагыг засч залруулснаар ирээдүйд үүсч болох аюул заналаас урьдчилан сэргийлж чадах юм. Хэрэв компанид шийтгэл ноогдуулсны дараа тухайн компани өөрчлөгдөхгүй бол шүүхээс ноогдуулж буй ял шийтгэлийнхээ сонголтыг өөрчлөх шаардлагатай. Үүнд тухайн компанийг бүр мөсөн хааж үйл ажиллагааг зогсоох буюу татан буулгах албадлагын арга хэмжээ оногдуулах юм.

3. Татан буулгах албадлагын арга хэмжээ

Бид Эрүүгийн хуулиар нэг хүний амь насыг санамсаргүй хохироох эсвэл санаатай хохироход энэ нь онц ноцтой гэмт хэрэгт тооцоогдож цаазаар авах юмуу бүх насаар нь хорих ял оноодог атлаа яагаад компани хууль бус үйл ажиллагааны явцад олон зуун хүний амь насанд хохирол учруулахуйц эсвэл бэртээж гэмтээж болзошгүй байдгийг мэддэггүй, эсвэл мэддэг ч тэгтлээ анхаарал хандуулдаггүй юм бэ? Компанид цаазаар авах ял оногдуулж болох юм. Энэ бол компанийг бүрмөсөн “байхгүй болгож” цаазлах явдал буюу татан буулгах албадлагын арга хэмжээ юм.

Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын буюу шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгаж болдог боловч Эрүүгийн хуулиар татан буулгах ойлголт Монгол Улсад өмнө нь байгаагүй юм. Шүүх компанийг дампуурсан; нэг ч гишүүн үлдээгүй; хуульд заасан бусад үндэслэл (Иргэний хуульд зааснаар хуулийг удаа дараа /гурав буюу түүнээс дээш удаа/ буюу ноцтой зөрчсөн үндэслэлээр) татан буулгадаг байсан бол одоо гэмт хэрэг үйлдсэн бол татан буулгана. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд татан буулгах ял оногдуулна. Ингэхдээ шүүх хөрөнгө орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр хуульчилжээ.⁹²

Монгол Улсын Эрүүгийн хуулиар 2 төрлийн гэмт хэрэгт (Эрүүгийн хуулийн 29.8 Террор үйлдэх, 29.9 Террор үйлдэхэд бэлтгэх) татан буулгах албадлагын арга хэмжээг хэрэглэх ба ингэхдээ тухайн хуулийн этгээдийг татан буулгасан тохиолдолд хөрөнгө орлогыг нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэхээр тусгасан.

4. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хуулийн этгээдийн ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална. Өөрөөр хэлбэл, “хураан авсан хөрөнгө, орлогыг

⁹¹ Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

⁹² Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга), 9.5 дугаар зүйл.

бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.” гэжээ.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

Дүгнэлт

Монгол Улс түүхэндээ анх удаа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг иж бүрэн хуульчилж⁹³, эрх зүйн томоохон шинэчлэлийг авчирлаа. Хүчтэй нэгдлийг болох компанийг хүчтэй хариуцлагын тогтолцоо болох Эрүүгийн хуулиар тогтоон барих нь дэлхийн улс орнуудад сонгодог жишиг болсоор удаж байна. Олон улсын гэрээ конвенц, Дэлхийн Эрүүгийн загвар хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тодорхойлон тусгаж, түүнд оногдуулах ял шийтгэлийн төрөл, тэдгээрийн үр нөлөөг тооцох аргачлалыг боловсруулж эхлээд байна.

Хуулийн этгээдэд ялын 3 төрлийг оногдуулахаар хуульчилсан ба эдгээрээс дэлхийн улс орнуудад хамгийн үр нөлөөтэй, түгээмэл ашиглагддаг нь торгох ял юм. Гэхдээ шүүх торгох ял оногдуулахдаа ялын үр нөлөөтэй байх явдлыг нэгдүгээрт анхаарч торгуулийн хэмжээг гэмт хэрэг үйлдэж олсон ашгаас хэд дахин их хэмжээгээр оногдуулах боловч тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэргийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, давтан үйлдсэн эсэх, тухайн гэмт хэрэгтэн хуулийн этгээдийн хөрөнгийн байдал, түүний бизнес цаашид үргэлжлэхэд үзүүлэх үр нөлөө зэргийг харгалзан үзэж байх нь зүйтэй. Компанид эрүүгийн ял шийтгэлд оногдуулах асуудалд ихээхэн нухацтай хандахгүй бол ял шийтгэл оногдуулснаар компанийн нэр хүнд унах, хэрэглэгчид бүтээгдэхүүнийг нь авахаа болих, дампуурах зэрэг олон эрсдлийг дагуулж байдаг. АНУ-д нэгэн компани эрүүгийн ял шийтгэгдэж, үүнээс үүдэн сайн ажилчдаа төдийгүй хэрэглэгчдээ ч алдаж байсан түүхтэй. Энэ нь олон нийтийн зүгээс компанийг шийтгэж байгаа нэг хэлбэр бөгөөд эрүүгийн шүүхээс шийтгэж байгаагаас ялгаагүй үр дүнг бас дагуулдаг байна. Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улс эрүүгийн эрх зүйн тогтолцоондоо хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг иж бүрэн хуульчилж компанийн гэмт хэрэгтэй эрүүгийн механизмаар тэмцэж эхэлсэн нь ихээхэн сайшаалтай бөгөөд цаашид энэ тогтолцоог хэрхэн зөв ажиллуулах нь хуульчдын өмнө тулгарч байгаа асуудлын нэг боллоо гэж дүгнэж байна.

⁹³ 2002 оны Эрүүгийн хуульд 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 2 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх заалт байсан боловч хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус байсан ба практикт үр дүнгээ өгөөгүй. Зохиогч

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖИЙН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛТЫН АСУУДАЛ

Б.Мөнхзаяа

ХСИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн
ахлах багш, хошууч, докторант

Түлхүүр үг: Эх сурвалж, эрх зүйн эх сурвалж, Эрүүгийн эрх зүйн эх сурвалж, ангилал

Удиртгал:

Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн ойлголт, төрөл, ангилалтын талаарх эрдэмтдийн үзэл баримтлал, тодорхойлолтуудад дүн шинжилгээ хийх, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, гадаадын зарим эрдэмтэдийн бүтээлд хэрхэн дурьдагдсан талаар судлахад энэхүү судалгааны зорилго чиглэгдсэн.

Эрх зүйн ерөнхий онолын үндсэн асуудал, судлагдахууны чухал асуудлын нэг эрх зүйн эх сурвалж мөн. Эрүүгийн эрх зүйн онолын болон практикийн хүрээнд эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг буруу тодорхойлсноос үүдэн сөрөг үр дагавар бий болох хандлагатай байдаг. Эх сурвалж гэсэн нэр томъёоны Монгол хэлний үг зүйн үндсийг судлан үзэхэд "эх" гэдэг үгийн үндсийг юмны **үүсэн гарсан газар, бичиг зэрэг юмны анхны үүсэл**⁹⁴ гэж тодорхойлсон байдаг. Харин "сурвалж" гэдэг үгийн утгыг юмны **эх үндэс, эх үүсгэл**⁹⁵ хэмээн тайлбарласан байна.

Эрх зүйн эх сурвалжийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлохын тулд эрх зүйн эх сурвалжийн төрөл зүй (хүмүүсийн оршин ахуй- байгаль газар зүйн онцлогтой холбогдож байгаа байдал); эрх зүйн эх сурвалж- улс төрийн онцлог (төр); ёс суртахууны хэм хэмжээ, шашны хэм хэмжээ, эрх зүйн уламжлал, гадаад орнуудын эрх зүйн харилцан хамаарал, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, тухайн нийгмийн эдийн засаг, ахуйн онцлог, эрүүгийн хууль амьдралд үйлчилж байгаа байдал); шашин дээр тулгуурласан ёс суртахуун, эрх зүйн эх сурвалж); эрх зүй бүтээх үйл явц, хүчин чадал (шүтлэг, ард түмний шүтлэг бишрэл, эрх зүйн ухамсар, шудрага ёсны үзэл, төрийн эрх мэдэл); хууль тогтоомжийн үндсийг бүрдүүлж буй эх үндэс, загвар болсон хууль тогтоомжууд (жишээлбэл: Римын эрх зүй германы эрх зүйн эх сурвалж болдог)⁹⁶.

Эрх зүйн онолоор эрх зүйн эх сурвалжийг үндсэн хоёр аспектаар авч үздэг. Үүнд:

1) өргөн хүрээнд- эрх зүйн гарал үүсэл, зүй тогтолын шалтгаанаар

2) явцуу утгаар- эрх зүйн хэм хэмжээг бий болгосон эрх зүйн субъектээс⁹⁷ хамаарч авч үздэг.

Зарим судлаач, эрдэмтэд эрх зүйн эх сурвалжийг судлан үзэхдээ:

а/ нийгэмд үйлчилж буй эрх зүйн хэв загвар ба төрийн эрх мэдэл, нийгмийн амьдралын дундаж, эдийн засгийн талаас нь материаллаг байдал;

б/ эрх зүйн ухамсар, үзэл баримтлал, улс төр эрх зүйн үзэл баримтлал талаас нь;

в/ эрх зүйн хэм хэмжээний дотоод бүтцийг хэрхэн хэлбэржүүлсэн байдал;

г/ засгийн эрхэнд байгаа улс төрийн хүчнээс хуульд үзүүлж байгаа нөлөөллийн хэлбэр;

д/ эрх зүйн эх үзлийн тулгуур сурвалжууд (эрх зүйн түүхэн дурсгалт баримтууд, археологийн олдворууд г.м.)⁹⁸ зэргийг харгалзан үздэг байна.

⁹⁴ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он., 892 дахь тал

⁹⁵ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он., 490 дэх тал

⁹⁶ Проблемы общей теории права и государства М.: 2001. 265 дахь тал; Общая теория права и государства. М.: 2000. 172 дахь тал; Гурова Т.В. Актуальные проблемы теории источников права: Дис... канд. юрид. наук. — Самара, 2000. 8 дахь тал; Уголовный закон. Преступление. Уголовная ответственность /Отв. ред. И.Я. Козаченко. — Екатеринбург, 1991., 56 дахь тал; Наумов А.В. Источники уголовного права // Уголовное право: новые идеи. — М., 1994. 4 дэх тал

⁹⁷ Гранат Н.Л. Источники права // Юрист. — 1998. — № 9.6 дахь тал; Сергеевич В.И. Лекции и исследования по древней истории русского права. — М.: Зерцало, 2004., 1 дэх тал; Таганцев Н.С. Русское уголовное право: Тула: Автограф, 2001. — Т. I., 119, 129 дэх тал; Шаргородский М.Д. Уголовный закон // Избранные работы по уголовному праву. — СПб.: 2003. 120 дахь тал; Юридический энциклопедический словарь. — М., 1984. —133 дахь тал

⁹⁸ Калинин А.Ю., Комаров С.А. Форма (источник) права как категория в теории государства и права // Правоведение. — 2000. — № 6. 3 дахь тал

Манай улсын эрдэмтэд эрх зүйн эх сурвалж гэдэг ойлголтыг а/ эрх зүйн хэм хэмжээний хэвшин тогтсон хэлбэр; б/ эрх зүйн хэм хэмжээний бүрэлдэж тогтох хэлбэр; в/ эрх зүйн хэм хэмжээний гадаад илэрхийлэл; г/ эрх зүйн хэлбэржсэн байдлын дүр төрх⁹⁹ гэж үзсэн байна. Профессор Ч.Энхбаатар "...эрх зүйн эх сурвалж гэж түүний **илрэх гадаад хэлбэр**..."¹⁰⁰. Профессор Д.Баярсайхан **эрх зүйн эх сурвалж, эрх зүйн хэлбэр хоёр өөр хоорондоо ялгаатай** ойлголт гэж тэмдэглээд "...эрх зүйн эх сурвалж бол эрх зүйн бүрдлийн үр дүн, түүний норматив ба норматив бус эх үндэс, зарчим, тэдгээрийн уялдан **холбогдсон систем**..."¹⁰¹, профессор Ч.Нямсүрэн "...эрх зүйн эх сурвалж нь тухайн улс оронд үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх /түүнчлэн өөрчлөх буюу халах/ ба **илэрхийлэх албан ёсны хэлбэр**...", профессор Г.Совд "...Эрхийн эх үүсвэрийн тухай асуудал нь түүний агуулга, үндэс сурвалжийн тухай асуудлыг тодорхойлдог биш харин эрхийн агуулгаа илэрхийлж байгаа хэлбэрийг тодорхойлдог эрхийн ухааны өвөрмөц онцлогтой ойлголт юм..." гэж тус тус тодорхойлсон байна.

Харин гадаад орнуудын судлаач, эрдэмтэд Ром-германы эрх зүйн бүлд "эрх зүйн эх сурвалж" гэдгийг тодорхойлсон нэгдсэн ойлголт байхгүй, учир нь тухайн бүлд түүх, соёл, газар нутаг, эрх зүйн соёлоор өөр өөр олон орон хамаарагддаг,¹⁰² К.Эллен, эрх зүйн эх сурвалж нь «...өөрийн хэм хэмжээндээ зайлшгүй шаардлагатай, тодорхой байх шинжийг агуулсан үйл ажиллагаа...»¹⁰³, Р.Кросс эрх зүйн эх сурвалж нь – «эрх зүйн хэм хэмжээндээ хууль зүйн хүчин чадал агуулсан шууд ба дамжимал шинж чанартай байна»¹⁰⁴ гэж тодорхойлсон байна.

Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг материалаг болон хэлбэрийн эх сурвалж гэж ангилдаг. Эрх зүйн **материаллаг эх сурвалж гэдэгт** эрх зүйн үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж буй нийгмийн амьдралын орчинг /төрийн хууль тогтоох эрх мэдэл / **түүний хэлбэрийн /формаль/ эх сурвалжид** гол төлөв хууль зүйн баримт бичгийн хэлбэрээр илрэх эх сурвалжийг тус тус хамааруулан ойлгож болох юм.¹⁰⁵

Профессор С.Жанцан Монгол Улсын Үндсэн хуулийн олон хэм хэмжээ нь Эрүүгийн хуулийн **шууд материаллаг эх сурвалж** болдог гэж тэмдэглэхийн зэрэгцээ эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний материаллаг эх сурвалжийн талаар судлаачдын дотор нэг мөр ойлголт хараахан тогтоогүй явж ирсэн бөгөөд ер нь энэ асуудал ул суурьтай судлагдаагүй талаар дурьдсан байна.¹⁰⁶

Бидний үзэж байгаагаар Эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн ойлголт, ангилалт, эх сурвалжийн судлагдаж ирсэн байдал зэрэг асуудал манай улсад төдийгүй гадаадын бусад оронд өнөөг хүртэл маргаантай хэвээр байна¹⁰⁷. Тухайлбал, энэ талаар ОХУ-ын судлаач, эрдэмтэн И.Б.Новицкий¹⁰⁸ эрх зүйн эх сурвалжийн асуудал 2000 жилийн түүхтэй төдийгүй хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн түүхэн цаг үед байнгын анхаарлын төвд явсаар ирсэн гэж тэмдэглэсэн бол, профессор Б.Баярсайхан XIX зууны сүүл үеэс эрх зүйн эх сурвалжийг зааглан ялгах, ангилах асуудал эхэлсэн гэж үздэг¹⁰⁹.

Профессор Г.Совд эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг а/ Үндсэн Хууль, б/ Эрүүгийн хууль, в/ Төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас гаргасан тогтоол, зарлиг, г/ Олон улсын чанартай гэрээ хэлэлцээр гэж ангилан¹¹⁰ хуваажээ.

⁹⁹Б.Баярсайхан. Эрх зүйн эх сурвалжийг ангилан тодорхойлох асуудал. Монголын төр эрх зүй. УБ., 2000 №1. 44 дэх тал

¹⁰⁰ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ. 2007 он., 22 дахь тал

¹⁰¹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ. 2010 он., 142 дахь тал

¹⁰² Давид Р., Жоффре-Спинози К. Основные правовые системы современности. – М., - 1998. 29-56 дах тал.

¹⁰³ Allen C. K. Law in the making. – Oxford, 1958. - P. 1-2.

¹⁰⁴ Кросс Р. Прецедент в английском праве. М., - 1985. – С. 157

¹⁰⁵ Б.Баярсайхан. Эрх зүйн эх сурвалжийг ангилан тодорхойлох асуудал. Монголын төр эрх зүй. УБ., 2000 №1. 44 дэх тал

¹⁰⁶ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. I боть., УБ.2009 он., 131 дэх тал

¹⁰⁷ Ибрагимов. М. А. Нормативные акты иных отраслей права как источники уголовного права. 11 дэх тал, Д.Мөнхтуяа. Олон улсын эрүүгийн эрх зүй. УБ.2000 он., 26 дахь тал, Б.Баярсайхан. Эрх зүйн эх сурвалжийг ангилан тодорхойлох асуудал. Монголын төр эрх зүй. УБ., 2000 №1. 48 дахь тал

¹⁰⁸ Новицкий И.Б. Источники советского гражданского права. – М., 1959. – С. 6.

¹⁰⁹ Б.Баярсайхан. Эрх зүйн эх сурвалжийг ангилан тодорхойлох асуудал. Монголын төр эрх зүй. УБ., 2000 №1. 46 дахь тал

¹¹⁰ Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс. УБ., 1973 он., 82-83 дахь тал

Профессор Б.Баярсайхан эрүүгийн эрх зүйн эх сурвалжийг "...олон улсын гэрээ ба олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчимууд, Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Хуульчилсан акт, Шүүхийн прецедент, бусад эх сурвалж..." гэж **төрөлжүүлэн** авч үзжээ.¹¹¹ Харин шүүхийн практик, шашны номлол, зан заншил, онол үзэл баримтлал зэргийг **туслах чанартай буюу үүсмэл хийгээд дам эх сурвалжийн** төрөлд хамааруулж болно гэж үзсэн байна.¹¹²

Профессор Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нар Үндсэн хуулийн эх сурвалжийг хууль зүйн хүчин чадлаар нь "...Үндсэн хууль, Ердийн хуулиуд, хууль тогтоомжийн бусад акт..."¹¹³ гэж ангилжээ. Доктор Б.Нармандах Үндсэн хуулийн эх сурвалжийг "...Үндсэн эх сурвалж, бусад эх сурвалж, өвөрмөц эх сурвалж..."¹¹⁴ гэж ангилсан байна. Үндсэн хуулийн хэм хэмжээ эрүүгийн эрх зүйн эх сурвалж болох талаар профессор С.Жанцан "...Монгол Улсын Үндсэн хуулийн зарим хэм хэмжээ нь эрүүгийн эрх зүйн хэлбэрийн бус материаллаг эх сурвалжид хамаарна..." гэж үзсэн байна.

Манай улсын эрдэмтэд гадаад орны болон олон улсын хэм хэмжээг судлаж ирсэн түүхэн баримтууд нэлээдгүй байдаг. Жишээлбэл: Богд хаант засгийн үед Цэвээн, Жамсранов гэсэн судлаачид дэлхийн олон орны төр эрх зүйн судалгаа хийж байсан, 1920 оны эхээр анхны Үндсэн хуулийн төсөл боловсруулагчид барууны нэлээд олон орны үндсэн хуулийг харьцуулан судлаж байжээ¹¹⁵. Судлаач Д.Мөнхтуяа олон улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн талаар "...Олон улсын эрүүгийн эрх зүйн **үндсэн эх сурвалж нь** олон улсын гэрээнүүд болно. Дийлэнх гэрээнүүд нь олон улсын эрүүгийн гэмт хэрэг болон олон улсын шинжтэй гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцон яллах тухай, эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцах, гэмт хэрэгтнийг шилжүүлэн өгөх тухай асуудлаар байгуулсан 2 талын, бүс нутгийн болон түгээмэл гэрээ бөгөөд зарим нь гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд шууд бус хамааралтай ..." гэж үзжээ¹¹⁶. Түүнчлэн **туслах эх сурвалжид** Нюрнбергийн цэргийн шүүхийн таслан шийтгэх тогтоолыг хамааруулах талаар 1949 оны Женевийн конвенцуудад тусгасан байдаг¹¹⁷.

Олон улсын **заншлыг** эрүүгийн эрх зүйн эх сурвалжид хамааруулах эсэх тухай асуудал Олон улсын эрх зүйн номлолд маргаантай хэвээр байна.¹¹⁸

Дүгнэлт

Дээрх судлаач, эрдэмтдийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлсон үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж үзвэл:

а) эрх зүйн үйлчлэл, хүчин чадал;

б) бусад хууль тогтоомжын харилцан хамаарал;

в) хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн түүхэн шинж чанар;

г) хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэлбэр зэргээс бүрддэг төдийгүй сүүлийн жилүүдэд эрх зүйн эх сурвалжийг тодорхойлсон тайлбарууд, онолын үзэл баримтлалуудад зөрүүтэй ойлголтууд түгээмэл ажиглагдах болжээ.

Үүний зэрэгцээ дэлхийн эдийн засгийн шилжилт, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хувьсал идэвхжиж байгаа өнөө үед олон улсын эрх зүйн хэм хэмжээ үндэсний эрх зүйн хэм хэмжээнд шууд тусгалаа олж байгаа жишээ баримт нэлээдгүй гарах болсон.

Иймд эрүүгийн эрх зүйн эх сурвалжийн орчин үеийн чиг хандлага, онолын урсгалуудыг цаашид нарийвчлан судлаж, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

¹¹¹ Б.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ. 2012 он., 62-64 дэх тал

¹¹² Дурьдсан бүтээл., 66 дахь тал

¹¹³ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ. 2000 он., 13 дахь тал.

¹¹⁴ Б.Нармандах. Үндсэн хуулийн эрх зүй. УБ. 2011 он., 19 дэх тал

¹¹⁵ Б.Чимид. Төр эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудлууд. УБ. 2008 он., 98 дахь тал

¹¹⁶ Д.Мөнхтуяа. Олон улсын эрүүгийн эрх зүй. УБ.2000 он., 23 дахь тал

¹¹⁷ Дурьдсан бүтээл., 28 дахь тал

¹¹⁸ Дурьдсан бүтээл., 28 дахь тал

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН САХИЛГА, ЁС ЗҮЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Л.Нямдаваа
ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга,
цагдаагийн хурандаа

Хүмүүс өдөр тутмынхаа амьдралд хууль зүйгээс гадна ёс суртахууны хэм хэмжээг удирдлага болгодог. Юуг хийж болох, юуг болохгүй, ямар зүйл сайн, ямар нь муу, аливаа юманд яаж хандах тухай анхны төсөөллийг хүн бүр бага байхаасаа эхлэн олж авч энэ нь аажмаар төлөвшин улмаар нийгмийн харилцаанд заавал мөрдөх шинжтэй зан байдлын журам болж тогтон бэхэждэг ажээ. Ёс зүйн зохицуулалт нь нийгмийн харилцааны зохицуулалтын хамгийн анхны хэлбэр бөгөөд гарвал талаас нь үзвэл ёс суртахууны зохицуулалтаас нэлээд хожуу үед эрх зүйн зохицуулалт үүссэн байдаг.

Эртний Грекийн нэрт гүн ухаантан Аристотель “Этика” хэмээх ухагдахууныг анх шинжлэх ухаанд оруулж ирснээр түүнийг ёс зүйн ухааныг үндэслэгчийн нэг хэмээн үздэг. Аристотелийнхаар “Ёс зүй гэдэг бол хүнд юуг хийх ёстой, юунаас татгалзах хэрэгтэйг танихад тусалдаг шинжлэх ухаан¹¹⁹” ажээ. Тэгвэл Английн социологич Г.Спенсер зан суртахуунтай хүн гэдэг гадаад орчныхоо нөхцөлд дээд зэргээр зохицохыг хэлнэ гэжээ.

Ёс зүйг бүрэн ойлгохын тулд үүнд багтаж байдаг ёс, ёслол, ёс суртахуун, ёс суртахууны хариуцлага зан суртахууны хэм хэмжээ зэрэг ухагдахууныг тодруулах шаардлага гардаг.

Ёс гэдэг нь Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар тольд” бичсэнээр а) юмны зайлшгүй зүй тогтол, жам тавилан, б) хүний дагаж баримтлах хэв хууль, зарчим, заншил, суртал юм¹²⁰. Өөрөөр хэлбэл тодорхой ажил үйлс эрхэлж байгаа хүний зүгээс нийгэмтэйгээ харилцах хариуцлага хүлээх, олны дунд биеэ авч явах сайн сайхан уламжлалт хэм хэмжээний нэгдмэл системийг ёс гэдэг.

Ёс зүйн агуулгад мэргэжлийн ёс зүй тэр дундаа төрийн албаны ёс зүйн чиглэл чухал болохыг ойлгож, олон оронд төрийн албаны ёс зүйн асуудлаар мэргэжлийн болон мэдээлэл судалгааны албад бий болжээ.¹²¹ Тухайлбал, АНУ-д муж улсын төвшинд 38 ёс зүйн хороо, орон нутгийн хэмжээнд 12 комисс ажиллаж байна. Холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагад албаны ёс зүйн асуудал хариуцсан 15 мянган ажилтан байдаг¹²² байна. үүнтэй адил төсөөтэй зөвлөл, комисс, яам Франц, Ангил, Япон, Герман болон бусад улсад ажилладаг. Тэдгээрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь төрийн албан хаагчид шударга, үнэнч зан суртахууныг төлөвшүүлэх, тэднийг аливаа гэм буруутай үйлдлээс урьдчилан сэргийлэх явдал юм.

Монгол Улсын цагдаагийн байгууллага нь “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах” чиг үүргийг¹²³ хэрэгжүүлдэг төрийн тусгай алба болохын хувьд алба хаагчдынхаа ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлж ирсэн.

Цагдаагийн албан хаагчийн ёс зүй 1923 оны үеэс эрх зүйн хэм хэмжээгээр¹²⁴ зохицуулагдаж ирсэн. Өнөө үед дэлхий дахинаа ёс зүйн хэм хэмжээний зохицуулах үүрэг,

¹¹⁹ Аристотель. Этика. СБ.1., 1908., с.4

¹²⁰ Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1964 он.

¹²¹ Төрийн албан хаагчийн ёс зүй нь мэргэжлийн ёс зүйн нэг төрөл бөгөөд түүнийг янз бүрээр нэрлэсээр иржээ. Тухайлбал Монгол хэлнээ “Төрийн албаны ёс зүй”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Удирдлагын ёс зүй”, “Цагдаагийн байгууллагын ёс зүй”, Орос хэлэнд “Этика государственного службы”, “Управленческая этика”, “Административная этика”, Ангилиар “Ethics of administration” гэж нэрлэдэг ажээ.

¹²² Государственная служба: Проблемы профессиональной этики: Заружный опыт: Реферативный бюллетень. №2(98). с.21.

¹²³ Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2017 он

¹²⁴ Ардын цагдан сэргийлэхийн анхны дүрэм боловсруулахаар засгийн газрын ерөнхий сайдын жинхэнэ орлогч сайд, Гадаад яамны тэргүүн сайд Б. Цэрэндоржоор удирдуулсан комисс томилогдож “ Нийслэл

нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсээр байгаа бөгөөд Монгол улсын цагдаагийн байгууллагын хувьд ч төрийн удирдлагыг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд ёс зүйн үүрэг улам бүр нэмэгдэж байна. Иймээс өнөөгийн цагдаагийн алба хаагчид үндэсний язгуур эрх ашиг, сонирхол, хүний эрх эрх чөлөөг дээдлэх, хууль ёсыг чанд сахин мөрдөх, өөрийн мэдлэг чадвар, авьяас билэг, сэтгэл зүтгэл, амь насаа зориулж, өргөсөн тангарагтаа үнэнч, цагдаагийн албаны нэр төрийг цэвэр ариун авч явсан түүхэн уламжлалыг хэвээр хадгалагдсаар байгаа эсэхийг тогтоох, үгүй бол түүнийг цаашид энэ хэвээр нь авч явах арга замыг эрэлхийлэх нь хөгжлийн зүй тогтол юм.

Ингэхдээ нэг талаас цагдаагийн алба хаагчид хүлээлгэж буй сахилгын хариуцлагыг эрх зүйн ямар хууль, дүрэм журмаар, ямар албан тушаалтан ногдуулдаг, сахилгын зөрчил, шийтгэлийн тоо бүртгэл, шийтгэл оногдуулахтай холбоотой алба хаагчийн эрх, ашиг сонирхол зөрчигдөж байгаа эсэх, цагдаагийн алба хаагчдын нэр хүнд иргэдийн дунд ямар хэмжээнд үнэлэгдэж байгаа зэргийг судлах шаардлагатай.

Эдгээрээс цагдаагийн албан хаагчийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байдал, зөрчлийн төрөл, оногдуулсан сахилгын шийтгэлийн төрлийн судалгааг тухайлан авч үзвэл:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2017 онд 1268 сахилгын зөрчилд 1277 алба хаагч холбогдсоны 810 буюу 63 хувийг офицер бүрэлдэхүүн, 467 буюу 37 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна. Алба хаагчдын гаргасан сахилгын зөрчлийг урьд оны мөн үеийнхтэй харьцуулбал зөрчлийн тоо 297 нэгжээр буюу 19 хувиар, холбогдсон алба хаагчийн тоо 312 буюу 19.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс 105 алба хаагч сахилгын зөрчил давтан гаргажээ.

Нийт сахилгын зөрчлийн 579 буюу 45.7 хувь нь Нийслэл хотод, 689 буюу 54.3 хувь нь орон нутагт үйлдэгдэж бүртгэгдсэн байна.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл: Алба, газар, хэлтсийн дарга 23 буюу 1.8 хувь, тасаг, хэсгийн дарга 100 буюу 7.8 хувь, эрүүгийн ахлах мөрдөгч 22 буюу 1.7 хувь, эрүүгийн мөрдөгч /хэсгийн төлөөлөгч/ 133 буюу 10.4 хувь, ахлах мөрдөгч 30 буюу 2.3 хувь, мөрдөгч 95 буюу 7.4 хувь, ахлах хэрэг бүртгэгч 12 буюу 0.9 хувь, хэрэг бүртгэгч 14 буюу 1.2 хувь, хэв журмын ахлах офицер 21 буюу 1.5 хувь, хэв журмын офицер 72 буюу 5.6 хувь, хэсгийн байцаагч 82 буюу 6.4 хувь, замын цагдаагийн ахлах байцаагч 5 буюу 0.4 хувь, замын цагдаагийн байцаагч 50 буюу 3.9 хувь, бусад офицер 150 буюу 11.7 хувь, хэв журмын цагдаа 219 буюу 17.1 хувь, эргүүлийн цагдаа 50 буюу 3.9 хувь, цагдаа зохицуулагч 39 буюу 3.1 хувь, цагдаа жолооч 41 буюу 3.2 хувь, бусад цагдаа 118 буюу 9.8 хувийг тус тус эзэлж байна.

Сахилга, ёс зүйн зөрчлийн төрлөөр нь авч үзвэл:

Хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн 31 буюу 2.4 хувь, ажлын хариуцлага алдсан 337 буюу 26.6 хувь, архидан согтуурсан 219 буюу 17.3 хувь, ЭБШХ зөрчсөн 157 буюу 12.4, бусад хууль, тогтоомж зөрчсөн 69 буюу 5.4 хувь, ЦАХ-чийн сахилгын дүрмийг зөрчсөн 220 буюу 17.4, үүрэг даалгавар үл биелүүлсэн 78 буюу 6.2, төсвийн хөрөнгийг ашигласан 1 буюу 0.1 хувь, хээл хахууль, шан харамж авсан 5 буюу 0.4 хувь, бусад 5 буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна.


Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг дараах хүчин зүйлээс үүдсэн гэж тодорхойлсон байна. Үүнд:

- хувь хүний буруутай үйл ажиллагаанаас 800 буюу 81.9 хувь;
- хууль дүрэм, журам, зааврын мэдлэг дутмаг, мэргэжлийн ур чадвар сулаас 44 буюу 4.5 хувь;
- ёс зүй хангалттай төлөвшөөгүй 38 буюу 3.9 хувь;
- цагдаагийн алба хаагчдын бие биедээ тавих зарчимч шаардлага сулаас 32 буюу 3.3 хувь;
- найз, нөхдийн уруу таталтаас 21 буюу 2.1 хувь;
- хяналт шалгалт сулаас 27 буюу 2.8 хувь;
- нийгмийн баталгаа хангалтгүйгээс 1 буюу 0.1 хувь;
- судлах, сонгон шалгаруулалт сулаас 3 буюу 0.3 хувь;
- ажлын ачаалал их, сэтгэл санааны тогтворгүй байдлаас 2 буюу 0.2 хувь;

хүрээний цагдан сэргийлэхийн эрх хэмжээний дүрэм", "Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль"- ийн төслийг боловсруулж МАХН-ын Төв Хороогоор зөвшөөрүүлэн засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн XVIII дугаар Хурлын 10 дугаар зүйлд хэлэлцэн баталсан байна.

- ар гэрээс нөлөөлөх шалтгаанаас 4 буюу 0.4 хувийг эзэлж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэлийн төрлөөр авч үзвэл:



Нийт сахилгын шийтгэлийн 8.5 хувийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар, 87.9 хувийг тухайн байгууллагын даргын тушаалаар, 3.4 хувийг бусад байгууллагын даргын тушаалаар тус тус оногдуулсан байна.

Нийт үйлдэгдсэн сахилгын зөрчлийн 1003 буюу 79.1 хувийг дотоодын хяналтаар, 265 буюу 20.9 хувийг гадны хяналтаар илрүүлсэн бөгөөд урьд оны мөн үеийнхээс дотоод хяналтаар илрүүлсэн зөрчил 5 хувиар өсөж, гадны хяналтаар илрүүлсэн зөрчил 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Албан хаагчдаас гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байдал:

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан алба хаагчдыг урьд оны мөн үетэй харьцуулбал: Авлигатай тэмцэх газраас авсан гэмт хэрэгт холбогдон шалгагдсан алба хаагчдын



мэдээнээс үзэхэд 2017 онд 127 эрүүгийн хэрэгт 141 алба хаагч холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үеийнхээс гэмт хэрэг, холбогдсон алба хаагч тус бүр 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсээс 18 алба хаагчид холбогдох гэмт хэргийн шинжтэй үйлдлийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн

шалгуулсан нь дээрх тоонд нэгтгэгдсэн болно. Албан хаагчдын холбогдсон гэмт хэргийг төрлөөр нь дурдвал:

- Замын цагдаагаас жолооны сургалттай холбогдуулан хуурамч баримт бичиг бүрдүүлэн жолоодох эрхийн үнэмлэх гаргах
- Хэв журмын цагдаагаас хуулиар олгогдоогүй чиг үүргийг хэрэгжүүлж замын хөдөлгөөний журам зөрчсөн иргэдийг торгох
- Мөрдөгчөөс хэргийн нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, бусдын гарын үсгийг дуурайлган үйлдэх
- Эрүүгийн мөрдөгч иргэнийг хэрэгт холбогдуулан шалгах явцдаа, зодож, цахилгаан бороохойгоор цохиулж, эрүү шүүлт тулгах зэрэг гэмт хэрэгт холбогдсон байна.

Цагдаагийн байгууллага нь албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор нэлээдгүй арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

1. Цагдаагийн байгууллагын дотоод хяналтын цахим системийг боловсруулж Мэдээллийн технологи, холбооны төвтэй хамтран “Алба хаагчидтай холбоотой өргөдөл, гомдлыг бүртгэх”, “Гэмт хэрэгт холбогдсон алба хаагчийн бүртгэх”, “Зөрчил гаргасан алба хаагчийг бүртгэх”, “Гэмт хэрэгт өртөж хохирсон алба хаагчийг бүртгэх”, “Зөрчилд өртөж хохирсон алба хаагчийг бүртгэх”, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй, учирсан эрсдэлийг бүртгэх, алба хаагч бүр эрсдэлийг мэдээлэгч байх боломжийг олгох “Эрсдэлийн програм”, “Албаны шалгалтыг бүртгэх, гарсан шалтгаан нөхцөлийг тодорхойлох програм”-ыг ашиглалтад оруулах

2. Цагдаагийн байгууллагын хэмжээнд алба хаагчдын сахилга ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийх, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, өртөж хохирсон, иргэд байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбогдуулан гаргасан өргөдөл гомдлыг бүртгэх, албаны шалгалт явуулсан мэдээг нэгтгэх, дүгнэлт хийх

3. Харилцааны соёлыг дээшлүүлэх дэд хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангах

4. Цагдаагийн алба хаагчийн харилцаа, сахилга ёс зүй, төлөвшил хандлага, удирдлагын манлайллыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

2017 онд 356 алба хаагчдыг мэргэжлийн түвшний аргачлалуудыг ашиглан сэтгэл зүйн шинжилгээнд хамруулахад ажлын хариуцлагаа мэдэрч, ухамсарласан, нийгмийн хэм хэмжээг сахидаг, бусдад туслалцаа үзүүлэхэд бэлэн, хамтран ажиллах сонирхолтой, нөхөрсөг, хамтран ажиллах чадвартай, аливаа зүйлд сонирхолтой ханддаг, санаачилгатай, өөрчлөлтийг түвэггүй хүлээж авдаг, бүтээлч, уян хатан зэрэг сайн чанар шинжилгээнд хамрагдсан алба хаагчдын талаас илүү хувьд илэрч байна. Гэхдээ цагдаагийн албанд ажиллаж байгаа нийт алба хаагчид дээрх сайн чанаруудтай байх ёстой боловч 35-40 хувьд түрэмгийлэл болон нейротизмын¹²⁵ үзүүлэлт илэрч байна.

Энэ нь сэтгэл зүйн дотоод асуудалтай, үүнийгээ зарим нь гадагшаа түрэмгийлэл байдлаар ил гаргах, эсвэл зарим нь аливаа зүйлийг хэт эмзэглэж тусгаж авах, гүнзгий хямрах зэргээр сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар сул байгаатай холбоотой.

Стресс бухимдал, сэтгэл зүйн ачаалал ихэссэн, ядаргаанд орсон, нойрны хэм алдагдсан, идэвх эрч хүч суларсан шинж судалгаанд оролцогчдын 3 хүн тутмын нэгд илэрч байна.

Энэ нь зарим мэргэжлийн хүмүүстэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Үүнд нэг талаас цаг наргүй ажиллах шаардлагатай болдог мэргэжлийн онцлог, үүнийг нь ойлгож хүлээн зөвшөөрөх гэр бүлийн харилцаа дутмаг, нөгөө талаас удирдлагын шинжлэх ухааны үндэстэй арга барил ашигладаггүй, ажлын байрны дарамт нөлөөлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон.

Ажилласан жил болон настай харьцуулж үзэхэд цагдаагийн албанд 5-10 жил ажилласан, түүнчлэн 26-30 насны хүмүүсийн хувьд ядралт эрс өндөр, олон жил ажиллах тусам энэ үзүүлэлт буурах зүй тогтолтой байна. Үүнээс харахад мэргэжилд дасан зохицох явц, мэргэжлийн чухал чанар удаан төлөвшиж байгаатай холбоотой байх боломжтой. Ядаргааны шинжүүд илрэх, нойргүйдэх зэрэг өөрчлөлт нь яваандаа хувь хүний эрүүл

¹²⁵ Сэтгэлийн хөдөлгөөний тогтворт чанар, сэтгэлийн хөдөлгөөний хариу үйлдэл гэж томъёолдог. Ямар нэг цочроолын хариуд илрэх сэтгэлийн хөдөлгөөний шинж чанар бөгөөд энэ шинж их тохиолдолд санаа зовох, ургуулан бодох, тайван бус болох, энэ шинж бага тохиолдолд тайван, хэнэггүй байх зэрэг сэтгэл зүйн тогтвортой байдлыг илэрхийлнэ.

мэнд, гэр бүлийн харилцаа, зан суртахуун, ажлын бүтээмж зэрэгт сөргөөр нөлөөлдөг байна.

Шинжилгээнд хамрагдсан хүмүүсийн 5 хүн тутмын нэгд ипохондри,¹²⁶ психоастени¹²⁷ хэв шинж илэрч байна.

Энэ нь дээр дурдсанчлан ядарсан мэдрэмж үүсдэг, өөрийн биеийн эрүүл мэндэд зовсон, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар сул, тайван байх, амрах эрмэлзэлтэй, ажлын ачаалал даах чадвар сул, дарамттай, хэт ачаалалтай нөхцөлд стресст ордог, стресст орсон үедээ биеийн зовуурь давхар илэрдэг, сульдсан мэдрэмж байнга төрдөг байдлыг илэрхийлнэ. Түүнчлэн паранойя¹²⁸ үзүүлэлт багагүй хувиар илэрч байна. Эдгээр шинжүүд нь ажлаас халшрах хам шинж, шүүмжлэлт хандлага бий болгох сөрөг үр дагавартай байдаг.

Дүгнэлт

Цагдаагийн албан хаагчид үндэсний язгуур эрх ашиг, сонирхол, хүний эрх эрх чөлөөг дээдлэх, хууль ёсыг чанд сахин мөрдөх, өөрийн мэдлэг чадвар, авьяас билэг, сэтгэл зүтгэл, амь насаа зориулж, өргөсөн тангарагтаа үнэнч, цагдаагийн албаны нэр төрийг цэвэр ариун авч явсан түүхэн уламжлалыг хэвээр хадгалагдсаар байгаа эсэхийг тогтоох, үгүй бол түүнийг цаашид энэ хэвээр нь авч явах арга замыг эрэлхийлэх нь хөгжлийн зүй тогтол юм.

Цагдаагийн албан хаагчийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байдал, зөрчлийн төрөл, оногдуулсан сахилгын шийтгэлийн төрлийн судалгааг тухайлан авч үзсэн.

Судалгааны дүнгээс харахад гэмт хэрэг, зөрчилд холбогдсон нийт алба хаагчдын 63 хувийг офицер бүрэлдэхүүн тэр дундаа тасаг, хэсгийн дарга, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч эзэлж байгаа нь, нийт зөрчил гаргасан алба хаагчдын 10 орчим хувь нь зөрчлийг давтан үйлдсэн байгаа нь анхаарал татаж байна.

Зөрчлийн төрлөөр нь авч үзвэл ажлын хариуцлага алдсан, архи дан согтуурсан, Эрүүгийн процессын хууль зөрчсөн, сахилгын дүрэм зөрчсөн зөрчил 73,7 хувийг эзэлж байгаа ба шалтгаан нөхцөл нь хувь хүний буруутай үйл ажиллагаа 81,9 хувийг эзэлж байна. Гэхдээ ажлын хариуцлага алдсан, сахилгын дүрэм зөрчсөн гэсэн тоо баримтаас цагдаагийн албан хаагч ямар зөрчил үйлдээд байгааг, хувь хүний буруутай үйл ажиллагаа гэдэгт юунаас болж зөрчил гаргах болов гэдгийг тодорхой гаргах боломжгүй байна. Тиймээс эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан шийдвэр гаргахдаа үйлдсэн зөрчлийг тодорхой бичих шаардлагатай байгаа ба энэ нь тухайн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, улмаар ёс зүйтэй цагдаагийн алба хаагчтай байх нэг нөхцөл болно.

Мөн гэмт хэрэгт холбогдсон судалгааг авч үзвэл ямар албан тушаалтан ямар гэмт хэргийг үйлдэж байгаа нь тодорхой байх тул тухайн гэмт хэрэг үйлдэхгүй байх ёс зүй төлөвшүүлэх чиглэлээр анхаарах шаардлагатай.

Сэтгэл зүйн судалгааны дүнг харахад хувь хүний темпрамент цагдаагийн алба хаагч байхад нөлөөлөх эсэх, ямар темпрамент бүхий хүн тохирох эсэх, цаашилбал ямар

¹²⁶ Өөрийн биеийн эрүүл мэндэд хэт зовсон, анхаарал хандуулсан, мэдрэмтгий, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар сул, тайван байх, амрах эрмэлзэлтэй, ажлын ачаалал даах чадвар сул, дарамттай, хэт ачаалалтай нөхцөлд стресст ордог, стресст орсон үедээ биеийн зовуурь давхар илэрдэг, ядарсан, сульдсан мэдрэмж байнга төрдөг, бусдын үл анзаарах зүйлийг анхаарч ажиглах, чадвартай, жижиг сажиг зүйлд баримжаалах талтай сэтгэл зүйн хэв шинж

¹²⁷ Сэтгэц сульдал гэсэн утгатай. Тодруулбал, шийдвэр гаргахдаа эргэлздэг, нягталж шалгаж үздэг, өөрийн боломжинд итгэдэггүй, болгоомжтой, таагүй зүйлийг хэт үнэлж хүлээж авдаг, зарим үед ач холбогдолгүй зүйлийг дөвийлгөн бэрхшээл мэдэрдэг, аюулгүй байх, хамгаалуулах, эмх цэгцтэй, тодорхой байхыг эрмэлзсэн, аюул занал, шинэ зүйл, тодорхойгүй, урьдаас мэдэх аргагүй болон эмх цэгцгүй байдлаас стресс үүсдэг, стрессийн үед амжилтгүй байдлаас зайлсхийх, үр дүнд хүрэх эсэх нь тодорхойгүй зүйл хийхээс татгалзах, өөрийн үйлдлийг нарийн төлөвлөх, хянах, залруулах онцлог бүхий сэтгэл зүйн хэв шинж

¹²⁸ Хэт үнэлэх бодол санаа гэсэн утгатай. Тодруулбал, сэтгэл хүчтэй догдолж, тэр мэдрэмж удаан үргэлжилдэг, сэтгэл зүйн ачаалал хуримтлагдах хандлагатай, шударга бус зүйлд мэдрэмтгий, өөрийн эрх зөрчигдөхөд хүчтэй хариу үйлдэл үзүүлдэг, бусдад үл итгэх хандлагатай, өөрийн нэр хүндэд илүү анхаардаг, үл тоомсорлоход дургүй, тогтвортой байдлыг эрхэмлэдэг, өөрийн давуу тал, байр суурийг улам дээшлүүлэх сонирхолтой, азгүйдэх, нэр хүнд унах үед сэтгэл хямардаг, стресст орсон үедээ бусдыг шүүмжлэх, бусдыг буруутгах талтай, зарим хүнд тохиолдолд бодит байдлаас хэтийдсэн бодол санаа үүсэх, энэ нь бараг өөрчлөгдөхгүй тогтонгишсон байх хандлагатай, гомдох, өс санах мэдрэмж үүсдэг, зорилгодоо хүрэхийн тулд тууштай, бага ч зүйлийг орхигдуулалгүй аливааг анхаардаг, усдын нөлөөг сөрж чаддаг, өөрийн үзэл бодлыг хамгаалдаг, бусдад шаардлага тавьдаг онцлог бүхий сэтгэл зүйн хэв шинж

албан тушаалд тохирох эсэхийг тодорхойлох, сонгон шалгаруулалтад анхаарах шаардлагатай.

Байгууллагын зүгээс албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр нэлээдгүй ажил хийж байгаа боловч цаашид эрх зүйн зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэхэд, технологийн дэвшлийг ашиглах замаар зохион байгуулалтын хувьд анхаарах, ялангуяа зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага байгааг үгүйсгэхгүй.

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ НУЛИМС АСГАРУУЛАГЧ, АМЬСГАЛ БООГДУУЛАГЧ БОДИС ХЭРЭГЛЭХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Албаны тусгай бэлтгэлийн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны үйл ажиллагаанд цагдаагийн алба хаагчаас нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисыг хэрэглэх эрх зүйн зохицуулалт, хэрэглэх арга аргачлал, анхаарвал зохих асуудлын талаар авч үзсэн болно.

Түлхүүр үг: Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, үндэслэл, хэрэглэх, арга, аргачлал

Хүч хэрэглэх ажиллагаа нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны таслан зогсоох тусгай албадлага бөгөөд захиргааны таслан зогсоох албадлага нь эрх зүйн зөрчил үйлдэгдсэнтэй холбоотойгоор түүнийг үргэлжлэн гаргахгүй болгох, учирч болзошгүй аюулыг арилгах зорилготой төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хуульд заасан үндэслэлээр хэрэглэж байгаа шууд албадах ажиллагаа¹²⁹ учир хүний эрх, эрх чөлөө хөндөгддөг онцгой арга хэмжээ юм.

Хүний эрхийг дээдэлсэн эрх зүйт төрийг хэвшүүлэх зорилт бүхий өнөөгийн нийгэмд төрийн зүгээс зайлшгүй тохиолдолд хүч хэрэглэх явдлыг хуульчлан зохицуулж аль болох хязгаарлах болжээ.

НҮБ-аас 1990 онд гаргасан “Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчим” эрх зүйн баримт бичигт тусгагдснаар хүч хэрэглэх явдал нь:

- Хууль ёсны дагуу байх
- Хамгийн эцсийн арга хэмжээ болгон хэрэглэх
- Хэрэглэж буй хүч нь хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй байх шаардлагыг наад захын жишиг стандарт болгон заасан байдаг.

Тэгвэл дээр дурдсан олон улсын жишиг стандартыг цагдаагийн байгууллага нь дотоодын хууль, эрх зүйн баримт бичигт тодорхой тусгаж цагдаагийн алба хаагч нь албаны үйл ажиллагаандаа нэг мөр баримтлан ажиллахыг шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуульд¹³⁰ тусгаж өгчээ. **Үүнийг тодотговол:**

Цагдаагийн алба хаагч албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ дараах нийтлэг шаардлагыг баримтлана. Үүнд:

- ✓ Зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх
- ✓ Нэн тэргүүнд хэрэглэхгүй байх
- ✓ Тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх гэж тусгайлан заалт болгон оруулжээ.

Хүч хэрэглэх нь хуулиар зөвшөөрсөн нөхцөлд хэв журам, иргэдийн аюулгүй байдал, амь нас, эд хөрөнгө хамгаалах зорилготой хийгддэг боловч нөгөө талаас сөрөг үр дагаварыг бий болгох боломжтой байдаг.

Иймээс хүчийг хэрэглэхдээ тусгайлан боловсруулж баталсан журам, нарийн заавар, удирдамжийг баримтлах шаардлага тавигддаг бөгөөд түүнчлэн галт зэвсэг, тусгай хэрэгслийг удирдах албан тушаалтан байнгын хяналтандаа байлгаж, гагцхүү зайлшгүй шаардлагатай үед ашиглах ёстой юм.

Манай улсын хувьд ч төрийн зүгээс хүч хэрэглэх хүрээг хуульчлан хориглохын зэрэгцээ зайлшгүй нөхцөлд хэн, ямар үндэслэлээр, хаана, ямар нөхцөл байдалд хэрхэн хэрэглэж болох талаарх хязгаарлалтыг хуульчилсан байна.

¹²⁹ Долгорсүрэн.Ж. “Цагдаагийн эрх зүй”, УБ хот, 2004., 242 дахь тал

¹³⁰ 2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 48-р зүйлийн 48.1 дэх хэсэг

Албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх нь гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй шууд холбоотой арга хэмжээг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй үед хийгддэг хүний эрх, эрх чөлөөг ихээр хөнддөг онцгой албадлагын арга хэмжээ юм.

Иймд цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр алба хэрэгцээнд хүлээн авч, бүртгэсэн галт зэвсэг, тусгай хэрэгслийг¹³¹ үндэслэл бүхий нөхцөл нэгэнт бий болсон тохиолдолд ашиглах ингэхдээ тохирсон хүчийг зөв сонгож хэрэглэх нь алба хаагч эрхээ хэтрүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлэх нөгөө талаас гэмт этгээд, зөрчил гаргагчид бага хохирол учруулахад чиглэгдсэн байна.

Цагдаагийн албаны тухай хуулинд заасан үндсэн чиг үүргийг алба хаагч биелүүлэх явцдаа өөрийн болон бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд хохирох аюултай тулгарч байдаг. Ийм үед цагдаагийн алба хаагчид хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд цагдаагийн хүч хэрэглэх тусгай эрх олгогдсон байдаг байна.

Цагдаагийн алба хаагч нь үүрэг гүйцэтгэх үедээ гав, бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, **нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч**, холбооны хэрэгсэл, гар чийдэн, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хэрэгсэл зэрэг иж бүрдэл бүхий агсамжаар хангагдах бөгөөд тэдгээрийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэглэнэ¹³² гэжээ.

Мөн Хууль зүйн сайдын А/126 тоот тушаалд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисыг дараах нэр томъёогоор тодорхойлж өгсөн байна.¹³³ Үүнд:

“Нулимс асгаруулагч” -Хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодис /гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно.

“Амьсгал боогдуулагч” -Амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодисгэж тус тус тусгайлан заасан байна.

Цагдаагийн төрөл, мэргэжлийн албаны үйл ажиллагаанд олон янзын загвар, хэлбэр, хэмжээтэй нэг хүнд болон олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр/газ/, гранат, сум шидэгч төхөөрөмжийг хэрэглэж байна.

Дээр дурдсан нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч тусгай хэрэгслүүд дотроос цагдаагийн өдөр тутмын хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, эргүүл, харуул, хамгаалалтын үйл ажиллагаанд ОХУ-д улсад үйлдвэрлэсэн ИЖ-79-8, ИЖ-78-8 загварын хийн бууг төв, орон нутгийн цагдаагийн байгууллага, алба хаагч нь түгээмэл албандаа ашиглаж байна.

Тийм учраас тус хийн бууны тактик техникийн өгөгдөхүүн, эд ангиудын бүтэц зохион байгуулалт, ажиллах зарчим, анхаарах асуудлын талаар авч үзье.



ИЖ-79-8 загварын хийн бууны техникийн үзүүлэлт:

¹³¹2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 48-р зүйлийн 48.3 дахь хэсэг

¹³²2017.02.09-ны өдөр шинэчлэн баталсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 60-р зүйлийн 60.1 дэх хэсэг


¹³³Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”-ын 1.3.2, 1.3.5 дахь заалт

- ✓ Урт-161 мм
- ✓ Өргөн- 30.5 мм
- ✓ Өндөр- 127 мм
- ✓ Жин- 625 грамм
- ✓ Калибр- 8мм
- ✓ Дайзны багтаамж- 8 сум
- ✓ Ашигтай тусгал- 3-5 метр
- ✓ Хийн болон дуут дохионы сумаар буудлага хийнэ
- ✓ Автомат ажиллагаатай

Иж бүрдэлд:

1. Буу- 1ш
2. Бууны гэр- 1ш
3. Гэрчилгээ
4. Зүлгүүр-1ш

Бүтэц ба ажиллах зарчим.



Бууны механизмын бүдүүвч зураглалын тайлбар:

- | | |
|----------------------------|-------------------------|
| 1. Бариул | 10. Гол төмөр |
| 2. Пүршний оньс | 11. Гол төмрийн халхавч |
| 3. Бариул тогтоох шураг | 12. Замагны түгжээ |
| 4. Пүрш | 13. Буцаах пүрш |
| 5. Бялт цохих чавх | 14. Гох |
| 6. Хараа | 15. Их бие |
| 7. Буцаах пүрштэй тээглүүр | 16. Дайз |
| 8. Сойх татуурга | 17. Тусгай арлагч |
| 9. Шидэгч /хаягч/ | 18. Тусгал овоо |

Тус хийн буу нь ашиглахад хялбар, авч явахад хөнгөн, ямар ч үед гацахгүй ажилладаг сайн талтайгаас гадна буцаах механизмын тусламжтайгаар автоматаар ажилладаг юм. Автомат үйл ажиллагаагаар буудсаны дараа гол төмрийг чөлөөлж, цохигч чавхийг дараагийн ажиллагаанд сойж, ээлжийн сумыг дайзнаас саадгүй шилжүүлдэг үйл ажиллагааны цогц юм.

Өөрөөр хэлбэл сум хооронд ямар нэгэн нэмэлт ажиллагаа шаардагдахгүй. Бүх сумаар буудаж дууссаны дараа замаг замаг баригчинд баригдан арын байрлалд түгжигддэг онцлогтой. Бууг ажиллах үед аюулгүй байдлыг хангаж дарцаг хэлбэртэй найдвартай ажиллагаатай механизмыг /гал хамгаалагч/ замганд хийж угсарч өгсөн байдаг.¹³⁴

Хийн бууг ашиглах журам:

- Буудахад бэлтгэх ажиллагаа
 - ✓ Дайзыг 8 ш сумаар цэнэглэнэ.
 - ✓ Сумтай дайзыг буунд угсрана.
 - ✓ Замгийг татуургаар хамгийн арын байрлалд сойно.
- Буудсаны дараа:
 - ✓ Дайзыг буунаас салгах
 - ✓ Дайзанд сум үлдсэн эсэхийг шалгах
 - ✓ Бууны аюулгүй байдлыг шалгах
 - ✓ Хагас задаргаа хийх
 - ✓ Арчиж цэвэрлээд, тослох
 - ✓ Бууны эвлүүлгээг хийгээд ажиллагааг шалгах
 - ✓ Замгийн хамгаалалт буюу гал хамгаалагчийг хаах

Хийн бууны сумыг ямар бодисоор цэнэглэснийг нь дараах 2 аргаар мэдэж болно.

Үүнд:

- ✓ Сумны пластмасан тагны өнгө
- ✓ Сумны хонгионы ёроолд бичигдсэн товчилсон үсэглэл /англи/

Сумны пластмасан тагны өнгө нь:

- ✓ Шар өнгөтэй бол амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн сум
- ✓ Улаан, цэнхэр, ягаан, цагаан өнгөтэй бол нулимс асгаруулагч бодисоор цэнэглэсэн сум
- ✓ Ногоон өнгөтэй бол дуут дохионы сум байна.

Сумны хонгионы ёроолд бичигдсэн товчилсон үсэглэл /англи/ нь:

- ✓ CS гэсэн үсэгтэй байвал амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн сум
- ✓ CN гэсэн үсэгтэй байвал нулимс асгаруулагч бодисоор цэнэглэсэн сум
- ✓ PS гэсэн үсэгтэй байвал амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч бодисыг давхар агуулсан байна.¹³⁵

Нулимс асгаруулагч бодис нь хүнд үйлчлэхдээ нүд, хамрын хөндийг гүн хорсгож, их хэмжээний нулимс асгаруулна. Харин амьсгал боогдуулагч бодис нь хордуулах бодис бөгөөд нүдний салст бүрхүүл болон амьсгалын замыг хүчтэй цочроож их хэмжээний нулимс асгарах, хамар, багалзуур хорсож цээжний хөндийгөөр өвдөх үйлчилгээг үзүүлнэ.

Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчийг давхар агуулсан бодис нь дээрхи үйлчлэлийг давхар агуулахаас гадна зовхи анилдах, хүндээр ханиалгуулах, дотор муухайрах, огиулах шинж тэмдгийг үзүүлнэ.

Дээрхи бодисуудыг битүү орчинд их хэмжээгээр хэрэглэх нь хүнийг гүн хордлогонд оруулах, ухаан алдуулах, цаашлаад үхэлд хүргэх аюултай нөхцлийг бүрдүүлдэг байна.

Иймд битүү өрөө тасалгаанд хийн буугаар буудсан тохиолдолд тухайн өрөө тасалгааг түргэн орхин гарч аль болох цонх хаалгыг онгойлгон агаарын солилцоо хийлгүүлэн хэвийн болгох арга хэмжээг авбал зохино.

Агаарын солилцоо муу орчинтой тухайн өрөө тасалгаанд сэнс залгаж агаарын солилцоог сайжруулж болно.

Гадаа задгай талбайд хийн буугаар буудлага хийхдээ алба хаагч салхины чигийг сайтар анхаарч салхины дээд талаас нь буудахыг анхаарах хэрэгтэй.

¹³⁴ Н.Ганбадрал, Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл., УБ хот, 2002 он 25 дахь тал

¹³⁵ Ш.Чулуун, Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл., УБ хот, 2016 он 162 дахь тал

Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн үйлчлэл нөлөөлсөн хүний эсэргүүцэл, довтолгоо зогссон тохиолдолд түүнд бодисын үйлчилгээг саармагжуулах боломж олгоно.

Өөрөөр хэлбэл тухайн этгээд эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсон үед та өөрийн болон орчны аюулгүй байдлыг сахин хамгаалсны дараа түүнд нүүр гараа угааж арчих, цэвэрлэх боломжийг олгосон байна.

Хийн буу, сумыг хэрэглэхэд дараах зүйлийг анхаарсан байна¹³⁶. Үүнд:

- Сумыг зөвхөн зориулалтын саванд авч явах /Үйлдвэрийн пластмасан сав эсвэл бууны дайз/
- Сумны ашиглалтыг хугацааг анхаарах /Ашиглалтын хугацаа нь 3 жил байна./
- Сумыг тоос шороо, бохирдох зүйлээс сайн хамгаалж ил галд ойр болон бусад шатах тослох материалтай цуг хадгалахгүй бөгөөд +5-аас +40 градусын температуртай байр саванд хадгалах
- Хийн буугаар буудлага үйлдэхдээ гарыг шулуун байлгах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа буутай харьцсан гараа нүүрний хэсэг, ялангуяа нүдэндээ хүргэж болохгүй
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа буутай харьцсан гараа спирт болон спиртэн төрлийн уусмалаар арчих, бүлээн усаар угаах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа бууны эд ангиудыг салгажспирт болон спиртэн төрлийн уусмалаар арчиж цэвэрлэх, ялангуяа бууны гол төмрийг спиртийг уусмалаар угаах
- Хийн буугаар буудлага үйлдсэний дараа цэвэрлэх боломжгүй тохиолдолд битүү хайрцаг саванд юмуу эсвэл гялгар уутанд хийж түр хадгалах
- Бодис хүний нүдэнд орсон үед бүлээн усны урсгалд угаах энэ нь хангалтгүй тохиолдолд 3-4%-ийн новокайны уусмал, 1%-ийн атропины уусмалыг 1*1 хэмжээтэйгээр найруулж түүний холимогоор цэвэрлэнэ.

Хийн буу, сумыг дараах тохиолдолд ашиглахыг хориглоно¹³⁷. Үүнд:

- Гэмтэл гацаатай буу, сумыг хэрэглэх
- Хугацаа дууссан, байлдааны болон өөр төрлийн сум ашиглах
- 1 метрээс ойр зайд хүний нүүр лүү шууд чиглүүлэн буудах/Хүний эрүүл мэндэд хохирол учруулах магадлал өндөр/
- 0.5 метрээс дотогш зайд буудлага үйлдэх /Сумны хуванцар пластмасан таг нь 0.5 метр зайд бууны гол төмрөөс шидэгдэн гардаг тул хүний биед шигдэх ялангуяа нүдэнд хүнд гэмтэл учруулах магадлал өндөр/
- Салхины эсрэг чиглэлд буудах /Гадаа задгай талбайд хийн буугаар буудлага хийхдээ алба хаагч салхины чигийг сайтар анхаарах/
- Жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүн
- Хүүхэд /насанд хүрээгүй/
- Өндөр настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн

Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр хэрэглэхэд дараах зүйлийг анхаарсан байна.¹³⁸

- Цагдаагийн алба хаагч нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг хэрэглэх зорилгоо тодорхойлж барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох ба гадна орчинд салхины чиглэл дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах зэргээр хэрэглэх
- Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн шүршүүрийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж, биеийн байдал нь муудсан этгээдэд эмнэлгийн туслалцаа үзүүлэх нөхцөл бололцоог хангах
- Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийн үйлчлэл нөлөөлсөн

¹³⁶ Мөн тэнд 163 дахь тал

¹³⁷ Ш.Чулуун, Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл., УБ хот, 2016 он 164 дэх тал

¹³⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтран баталсан 2017.09.06-ны өдрийн А-126/А-102 тоот тушаалын 1-р хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.15 дахь хэсэг

хүний эсэргүүцэл, довтолгоо зогссон тохиолдолд түүнд тусгай хэрэгслийн үйлчилгээг саармагжуулах боломж олгох

➤ Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хэрэглэсэн тухайгаа цагдаагийн алба хаагч шууд захирах даргадаа илтгэх

➤ Салхины эсрэг чиглэлд, мөн 8 метрээс хол зайд хэрэглэвэл үйлчлэхгүй болохыг тооцоолох

Тухайн этгээдийн гаргасан хэрэг, зөрчлийн байдлаас шалтгаалж түүнд ямар төрлийн хийн бууны сумыг хэрэглэвэл илүү үр дүнтэй болохыг тооцон буудлага үйлдэх нь нэг талаас цагдаагийн алба хаагчийн хийн буга ашиглах мэргэжлийн ур чадварыг илтгэн харуулах, нөгөө талаас тухайн этгээд нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хэдий боловч түүнд аль болох бага хохирол учруулахыг эрмэлзэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн, үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа төрөл бүрийн хэлбэр хийц, бүтэц зохион байгуулалттай нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисоор цэнэглэсэн буу, шүршүүр, гранат, сум шидэгч төхөөрөмжийн талаархи нэгдсэн дадлага, сургалтыг алба хаагчдад зохион байгуулж тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч бодисыг хэрэглэхдээ тусгай хэрэгслийн үйлдвэрлэгчийн ашиглах зааврыг дагаж мөрдөх, аюулгүй байдлыг сахин хамгаалж ажиллах шаардлагатай байна.

Санал

1. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс нь алба хаагчдадаа сургалтыг тухай бүр зохион байгуулж тэдний онолын болон практик туршлагыг нэмэгдүүлэн зөв хэрэглэх арга зүйд сургах
2. Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч бодисын үзүүлэлт, чанар, стандартыг тодорхойлсон албан ёсны мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулан үндэсний стандартыг бий болгох
3. Амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагч бодисоор цэнэглэсэн тусгай хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэдэггүй тул үйлдвэрлэгчийн ашиглах заавар нь тухайн орны хэл дээр эсхүл англи хэл дээр байдаг. Иймд тусгай хэрэгслийг алба, нэгж рүү хангалтаар тавьж олгохдоо ашиглах зааврыг цагдаагийн төв байгууллагын холбогдох нэгжээс албан ёсны орчуулгыг монгол хэлээр хийлгүүлэн хамт олгох шаардлагатай байна.

Ном зүй

1. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09.
2. ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
3. Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”
4. Долгорсүрэн.Ж., “Цагдаагийн эрх зүй”. УБ хот., 2004 он
5. Чулуун.Ш., “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ хот., 2015 он
6. Ганбадрал.Н., “Цагдаагийн зэвсэг, тусгай хэрэгсэл”. УБ хот., 2002 он
7. Аминд халгүй зэвсэг-2010 сургалт /Зэвсэгт хүчний жанжин штаб, АНУ-ын тэнгисийн явган цэргийн сургагч багш нарын хамтарсан/

НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХАД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ НЬ

*Б.Мэндбаяр
ОХУ-ын Дотоод хэргийн яамны Удирдлагын
академийн суралцагч, цагдаагийн хошууч*

Оршил

Дэлхийн шим мандалд амьдрал үүссэн цагаас байгалийн араншинг удамших хувьслын зүй тогтлоор шалгаран давж үлдсэн хоёр сая гаруй төрөл зүйлийн амьтдын дотроос хүн төрөлхтөн ухамсарт сэтгэлгээ, оюуны хөгжлөөрөө онцгойрон тодроод гал манан, зэвсэг хийж, хувцас өмсөн, зэрлэг амьтныг гэршүүлж ахуйгаа бүтээлчээр тордохын сацуу хамтын аж ахуй өрнүүлж, өөр хоорондоо харилцаж, хүмүүний нийгмийг бий болгожээ.

Ингэж үүсэн нийгмийн хөгжил нь яван явсаар овог аймгаас улс үндэснийг бий болгож, улмаар улс нийгмийн хөгжил нь аж үйлдвэржилт, шинжлэх ухаан технологийг хөгжлийг туулсаар өнөөгийн техник, технологийн үсрэнгүй эрин зуунд хүргэжээ. Техник технологийн үсрэнгүй хөгжил дэлхий дахиныг хамрахдаа өөрийн замд тааралдсан бүх зүйлийг өөрчлөн байгуулж, даяаршил хөгжлийн түвшингээс үл хамааран улс орон бүрийг хамарч, тэдгээрийн хүн ам, соёл, зан заншил, эдийн засаг, хууль журам, амьдралын хэв маяг, улс төрийн шийдвэр, үйл ажиллагааг хөдөлгөөнд оруулж байна. Энэхүү хөгжил нь бидний өмнө хүрч чадахгүй байсан олон бэрхшээлийг даван туулахад хүргэж чадсан. Тухайлбал, шинжлэх ухаан технологийн хөгжлийн тусламжтайгаар улс орнууд өөрсдийн иргэдийн аюулгүй байдлыг гэмт хэрэг, зөрчил, гадна дотны гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн хэв журмыг хамгаалах ажилд онцгой дэвшилт гарч гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг, гэмт халдлагаас хамгаалах, түүнчлэн нийгэмд өрнөж буй үйл явдлыг шууд хянаж болохуй хяналтын системийг өдгөө нэвтрүүлээд байна.

Гэсэн хэдий ч өдгөө дэлхий дээр байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, осол, сүйрэл, эмх замбараагүй байдал, гэмт хэрэг, зөрчил, террорист халдлага, бүс нутгийн зөрчилдөөн жилээс жилд өсөж, түүнээс гарах хор уршиг, үр дагавар улам бүр нэмэгдэж байгаа нь улс гүрнүүдийг өмнө тулгамдаж буй томоохон асуудлын нэг болж байна.

Нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн дэвшилтэд техник технологийг ашиглах нь илүү үр дүн хүргэж буйг техник технологийг нэвтрүүлж чадсан богинохон цаг хугацаа харуулсан боловч техник, технологийн хөгжлийн хариу урвал болж гэмт хэрэг, зөрчил, халдлага үйлдэгчдийн үйлдэл улам боловсронгуй, техник хэрэгсэл ашигласан, нуугдмал, зохион байгуулалттай, түүнчлэн цахим хэлбэрт шилжиж илүү хор хөнөөл учруулж байгаа нь нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн техник технологийг маш оновчтой, зүй зохистой нэтрүүлж, зохион байгуулалттай ашиглах нь нэн чухал болохыг харуулсаар байна.

Тиймээс нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн техник, технологийг ашиглах асуудлыг эрх зүйн зохицуулалт болон техник технологийн хэрэглээ талаас нь судлан үзэхийг зорьсон юм.

Нийгмийн хэв журам хамгаалах ажлын ойлголт, хамрах хүрээ

Юуны өмнө нийгмийн хэв журам хамгаалах ажлын ойлголт, шинж, агуулгыг тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн. Нийгмийн хэв журмын ойлголтын талаар Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “Нийгмийн хэв журам гэж хүн амын аж төрөн амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, ёс заншил, бүх нийтээр хүлээн зөвшөөрч хэвшсэн буюу хуулиар тогтоосон нийгмийн хэм хэмжээний нийлбэр цогц¹³⁹” гэж тодорхойлсон бол Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Таванжин “Нийгмийн хэв журам нь хүний ухамсарт амьдралын үр дүн болох зан үйл, үйлдлээр илрэх хүмүүсийн хүсэл зоригийн харилцаанаас бүрэлдэн бий болно” гэж үзээд “Нийгмийн хэв журам нь нийгэм, төрийн тогтолцоонд баталгаажин нийгмийн харилцааг социал хэм хэмжээ /эрх

¹³⁹ Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга. УБ, 1993.дэх тал.

зүй, ёс суртахууны зан заншлын хамтын аж байдлын, бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ гэх мэт¹⁴⁰ -гээр хэлбэржүүлэн бүрэлдүүлж тогтоосон нийгмийн учир шалтгаан үндэс бүхий социали эрх зүйн ухагдахуун юм¹⁴⁰ гэж бичсэн байна.

Харин хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн “Нийгмийн хэв журам гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх, бололцоог хангах, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан, монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэл тогтолцоо мөн¹⁴¹” гэж өргөн утгаар нь авч үзсэн байна. Мөн тэрээр нийгмийн хэв журам хамгаалах гэдэгт “Төрийн байгууллагаас олон түмэнтэй нягт холбоотойгоор хүний эрх эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, өмч хөрөнгө хамгаалах, олон нийтийн газарт хүн амын амгалан тайван байдлыг хангах, төрийн захиргааны болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллах хэвийн нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээний бүхэл тогтолцоо мөн¹⁴²” гэж үзсэн.

Нийгмийн хэв журмын шинжийг зөв танин мэдэхийн тулд түүний бүтцийг судлан үзэх нь онол-арга зүйн хувьд чухал ач холбогдолтой. Энэ нь түүний агуулга, зорилго, зохицуулалтын хэрэгсэл, баталгаа гэсэн ойлголтуудаар илэрхийлэгдэнэ. Тодруулбал:

А. Нийгмийн хэв журам нь материаллаг болон эрх зүйн агуулгатай: Нийгмийн хэв журмын материаллаг агуулгыг нийгмийн хэв журмын ойлголтын талаар өгсөн бидний дээрх тодорхойлолтыг эш үндэс болгон үзвэл нийгмийн бүхий л гишүүдэд тогтсон нийтлэг үнэлэмжид нийцсэн шаардлагатай нөхцөлдсөн байдгаар илэрхийлэгдэнэ. Түүний эрх зүйн агуулга нь төрийн байгууллагаас олон түмэнтэй нягт холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, өмч хөрөнгө хамгаалах, олон нийтийн газарт хүн амын амгалан тайван байдлыг хангах, төрийн захиргааны болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллах хэвийн нөхцлийг бүрдүүлэхийн тулд төрийн эрх бүхий байгууллагаас эрх зүйн хэм хэмжээ тогтоодог явдлаар тайлбарлагдана.

Б. Нийгмийн хэв журмын зорилго нь бидний үзэж байгаагаар бүтцийн хувьд:

- Нийгмийн хэв журмыг хангах зорилго
- Нийгмийн хэв журмыг хамгаалах зорилготой байна.

Өөрөөр хэлбэл төрөөс иргэд, аж ахуй нэгж байгууллагийн үйл ажиллагаанд өөрийн хууль ёсны эрх ашиг, эрх, эрх чөлөөгөө ашиглах бүхий л боломжийг хангах, эдгээр эрх ашиг нь зөрчигдсэн тохиолдолд найдвартай хамгаалахад чиглэгдэнэ.

В. Нийгмийн хэв журмын зохицуулах хэрэгсэл нь нийгмийн хэв журамтай холбогдон бий болсон нийгмийн харилцааг зохицуулж байгаа ёс суртахууны хэм хэмжээ, зан заншлын хэм хэмжээ байна. Ёс суртахууны хэм хэмжээ нь нийгмийн ухамсарт бий болж байгаа сайн ба муу, шударга ба шударга бус, нэр төр, алдар хүнд, ёс журам гэх зэрэг ойлголт төсөөлөлд тулгуурлана.

Нийгмийн хэв журам нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана. Төрийн байгууллагаас нийгмийн хэв журмыг хангах, хамгаалах зорилгоор эрх зүйн хэм хэмжээ тогтоогддог бөгөөд энэ нь түүний эрх зүйн агуулгыг бүрдүүлдэг болохыг дээр дурьдсан. Нийгмийн хэв журмын зохицуулах зүйл нь эрх зүйн хэм хэмжээ болох бөгөөд эрх зүйн хэм хэмжээг тогтоох зөвшөөрөх, замаар зан үйлийн горим журмыг тогтоож өгнө.

Нийгмийн хэв журмын эрх зүйн зохицуулалтын эх сурвалжийг хууль зүйн хүчин чадал, эрх зүйн эх сурвалжийн тогтолцоот байдлыг харгалзан:

- 1 Нийтлэг эх сурвалж
- 2 Гол эх сурвалж
- 3 Бусад эх сурвалж гэсэн төрөлд ангилан авч үзэж болно.

Үндсэн хууль нь эрх зүйн дээд хүчин чадалтай эрх зүйн хэм хэмжээний акт болохынхоо хувьд нийгмийн хэв журам хамгаалах төрийн үүрэг, төрийн байгууллагуудын тогтолцоо, чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зарчмын үндсийг хуульчлан зааж нийгмийн хэв журмыг хамгаалах, хангахтай холбогдон үүссэн нийгмийн харилцааг

¹⁴⁰ Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006 он. 45 дахь тал.

¹⁴¹ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2004 он. 36 дахь тал.

¹⁴² Ж. Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ.: 2003 он.14 дахь тал

зохицуулж буй бусад хууль, тогтоомж түүнд нийцэж гарах утгаараа нийтлэг эх сурвалж болно.

Нийгмийн хэв журмыг хангах, хамгаалахад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын оролцоог оновчтой болгох, бодит шаардлагын үүднээс Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд "...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг" гэж заасан заалтыг хэрэгжүүлэх ерөнхий чиг баримтлалыг тодорхойлж өгсөн нь Үндсэн хууль нийгмийн хэв журмын эрх зүйн зохицуулалтын нийтлэг эх сурвалж болохыг харуулж байна.

Нийгмийн хэв журмын эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалжид энэ төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний актын үндсэн төрлийн нэг болох хууль хамаарна. Нийгмийн хэв журмын эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалж гэдэг нь зохицуулж буй нийгмийн хэв журамтай холбогдон үүссэн нийгмийн харилцаанд голлох шинжтэй үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээний илэрхийлэгдэх гадаад хэлбэр юм. Нийгмийн хэв журмын эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалжийн хувьд нягт уялдаа холбоотойгоор авч үзэх зайлшгүй шаардлагаар нөхцөлдсөн олон тооны эх сурвалжууд байдгаар түүний онцлог илэрнэ. Энэ нь түүнийг гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд үүссэн харилцааг зохицуулж буй захиргааны эрх зүйтэй нягт уялдаатай байгааг харуулж байна.

Г. Нийгмийн хэв журмын баталгаа нь эрх зүйн ухамсар, соёл, хууль ёсны зан үйлээр тодорхойлогдоно. Иргэдийн эрх зүйн ухамсар, соёлын тасралтгүй өсөлт нь нийгмийн хэв журмыг бэхжүүлэх баталгаа болохыг судлаачид судлан бичсэн байна.

Нийгмийн ухамсарын нэг төрөл нь эрх зүйн ухамсар бөгөөд нийгэм, эрх зүйн бодит байдлын тусгал юм¹⁴³: "Зан суртахуун нь "нийгмийн ухамсарын хамгийн анхны хэлбэр"¹⁴⁴ мөн бөгөөд эрх зүйн ухамсар нь эрх зүй хэрэгжихэд чухал ач холбогдолтой бөгөөд түүний түвшингөөс шалтгаалан нийгмийн гишүүдийн зан үйл зохицуулагдаж тэр хирээр нийгмийн хэв журам бэхжигдэнэ гэсэн үг юм. Тухайлбал: Үйл ажиллагаа нийгмийн хэв журамд нийцсэн хууль ёсны байх эсхүл нийгмийн хэв журмыг зөрчих гэх мэтээр илэрнэ. Эрх зүйн соёлын хамгийн идэвхитэй хэлбэр нь хуулийг нийгмийн үнэт зүйл гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан өөрийн зан үйлдийг түүнд тохируулах байдлаар илэрнэ.

Эрх зүйн дэг журам нь нийгмийн хэв журмын хүрээнд оршиж эрх зүйн хэм хэмжээгээр тогтоогдож, эрх зүйн хэрэгжилт, түүний үр дүнгээр тодорхойлогдож байгаа эрх зүйн харилцааны бодит харилцаа мөн гэж тодорхойлоод Монгол Улсын Үндсэн Хуульд "нийгмийн хэв журам" "Нийгмийн дэг журам" гэсэн нэр томъёо орсон бөгөөд "нийгмийн дэг журам" гэсэн ойлголтыг "төрийн дэг журам" биш харин "эрх зүйн дэг журам" гэж тайлбарлаад эрх зүйн дэг журам нь хууль ёс, эрх зүйн үндсэн дээр журамлагдсан нийгмийн харилцааны бодит байдлын хувьд хууль ёстой салшгүй холбоотой болохыг онцлон үзжээ¹⁴⁵.

Өөрөөр хэлбэл үндсэн хуулийн дэг журам нь нийгмийн хэв журам, нийгмийн дэг журмаар нөхцөлддөг нийгмийн амгалан тайван байдал, хүн амын амь бие, эрүүл мэнд, халдашгүй эрх, иргэдийн хөдөлмөрлөх, амьдрах хэвийн нөхцөл, төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан нийгмийн харилцааны тогтолцоо юм. Харин нийгмийн дэг журам нь Үндсэн Хуульд тусгагдан бэхжигдсэн "төр"-д хамааралтай эрх зүйн заалт, Олон нийтийн хэв журам¹¹ нь эрх зүйн төдийгүй зан заншил, ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулагдсан социали эрх зүйн өргөн хүрээтэй ойлголт болох нь харагдаж байна.

Нийгмийн дэг журам нь өргөн агуулгатай, харин нийгмийн хэв журам нь түүний доторхи бүрэлдэхүүн хэсэг бол нийгмийн дэг журмыг төрийн дэг журам гэж ойлгож зөвхөн хэрэгжүүлэгч субъектын талаас нь авч үзэх нь оновчтой байна.

Нийгмийн хэв журмын ойлголтын талаар хийсэн судалгаандаа тулгуурлан үзвэл "Нийгмийн хэв журам гэдэг нь төр, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид өөрийн хууль ёсны эрх ашиг, эрх, эрх чөлөөгөө ашиглах бүхий л боломжийг хангах, эдгээр эрх ашиг нь зөрчигдсэн тохиолдолд найдвартай хамгаалах, нийтийн зарчимд үндэслэсэн зорилго бүхий нийгмийн гишүүдэд тогтсон нийтлэг үнэлэмжид нийцсэн эрх зүй, ёс суртахуун, зан

¹⁴³ Б.Самбуу, Нийгэм судлалын үндсэн ойлголтын товч толь УБ, 1983 он., 117-дахь тал.

¹⁴⁴ Философийн үндсүүд УБ., 1960 он, 612 дахь тал.

¹⁴⁵ Ч.Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онол УБ, 2004 он 319 дахь тал

заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцааны өвөрмөц бүрдэл” гэж тодорхойлж болохоор байна.

Нийгмийн хэв журам хамгаалах гэдэг нь иргэдийн эрх, эрх чөлөө, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, эрх зүйн зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт хэргийг илрүүлэхэд идэвхитэй оролцох ажлыг харилцан холбоотой хамтран хэрэгжүүлэх цагдаагийн алба, салбар тэдгээрийн хүч хэрэгслийн нийлбэр цогц бөгөөд цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны бие даасан нэг төрөл мөн. Харин цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах үүргээ биелүүлэх гэдэг нь хүмүүс олноор цугларсан газар болон гудамж талбайд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэм хэмжээг сахиулах, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

Нийгмийн дэг журам хангах төрийн чиг үүргийн хүрээнд нийгмийн хэв журмыг хамгаалах салбарыг удирдах бүрэн эрхийг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн “Хүний эрх эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх гэсэн 14-дүгээр зүйлийн 14.7-д “нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна” гэж хуульчлан заажээ. Түүнчлэн Засгийн газар нь:

- ✓ Хүний эрх эрх чөлөөг хангах, эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээг авах,
- ✓ Хэрэг бүртгэх, мөрдөн байцаахаас бусад асуудлаар цагдаагийн төв байгууллагыг удирдаж, үйл ажиллагааг нь шалгаж, үүрэг даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавих.
- ✓ Хүний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг бүрэн эрхүүдийг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд зааснаар Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллагын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал нь хуульд заасны дагуу нийгмийн хэв журам хамгаалах талаар хуульд заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээр нь нийгмийн хэв журам хамгаалах бодлого боловсруулах, хууль тогтоомжийн биелэлийг зохион байгуулах, хянаж шалгах, нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий төрийн байгууллагуудыг удирдлагаар хангах, үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийн дагуу гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах хяналт үнэлгээ хийх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Нийгмийн хэв журам хамгаалах салбарыг удирдах удирдлагын субъект нь Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөн.

Дээрхи байдлаас үзвэл нийгмийн хэв журам хамгаалах нэгдмэл тогтолцоо нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлага, Цагдаагийн байгууллага түүнд харъяалагдах албадаас бүрдэж байна.

Нийгмийн хэв журам хамгаалах олон талтай нарийн төвөгтэй ажлыг цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэдэг. Цагдаагийн албаны тухай тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т **“Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”** гэж тодорхойлсон

Цагдаагийн албаны нийгмийн хэв журам хамгаалах ажлын онцлог нь Монгол Улсын Үндсэн Хууль бусад хууль тогтоомжийн актыг амьдралд хэрэгжүүлэх, нийгмийн хэв журам, хууль ёсыг бэхжүүлэх үйл хэрэгт захиргааны үйл ажиллагааны бусад төрөлтэй харьцуулбал тэргүүлэх байр эзэлж хуулиар хүлээлгэсэн олон үүрэг гүйцэтгэж үлэмж хэмжээний хүч, хэрэгслийг өөртөө нэгтгэж байдагт оршино.

Цагдаагийн албаны нийгмийн хэв журам хамгаалах ажлын зорилт нь тухайн байгууллагын захиргааны үйл ажиллагааны явцад хүрвэл зохих үр дүнг илэрхийлдэг бол чиг үүрэг нь захиргааны үйл ажиллагааны гол чиглэл, хийвэл зохих ажлын бүрэлдэхүүн хэсэг юм. Цагдаагийн албаны нийгмийн хэв журам хамгаалах ажлын зорилт, чиг үүрэг удирдлагын шинж байдлыг тодорхойлохын тулд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилго, стратегийн зорилтуудыг авч үзэх нь зүйтэй юм.

Цагдаагийн байгууллагын алсын хараа нь Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болохыг тодорхойлсон байна.

Цагдаагийн байгууллага нь нийгмийн хэв журам хамгаалах ажлын үндсэн зорилтоо биелүүлэх чиг үүргийг үйл ажиллагааны чиглэл, шинжийг харгалзан бүтцийн хувьд дараах байдлаар ангилан үзэж болно.

- Зохион байгуулах чиг үүрэг
- Удирдах чиг үүрэг
- Хяналтын чиг үүрэг гэж ангилж болохоор байна. Эдгээрийг дэлгэрүүлбэл:
 - **Зохион байгуулах чиг үүргийн хүрээнд:**
 - ✓ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
 - ✓ Олон улсын болон гадаад орны цагдаагийн байгууллагатай харилцаа тогтоох, хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр байгуулах, мэдээлэл солилцох, санал боловсруулж Цагдаагийн Ерөнхий Газрын даргын зөвшөөрлөөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах гэх мэт.
 - **Удирлагын чиг үүргийн хүрээнд:**
 - ✓ Албаны хэтийн бодлого, зорилтыг тодорхойлж ялангуяа гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгож, алба хаагчдын мэргэшил дээшлүүлэх бодлого баримтлах
 - ✓ Гэмт хэрэг илрүүлэхэд туслах урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг цагдаагийн бусад байгууллага, албадын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах тэднийг мэргэжлийн удирдлагаар хангах, гэх мэт.
 - **Хяналтын чиг үүргийн хүрээнд:**
 - ✓ Албаны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын биелэлтэнд хяналт тавих,
 - ✓ Алба хаагчдын үйл ажиллагааг Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлж байгаад хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах
 - ✓ Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, тамга тэмдэг, өнгөт хувилагчийг бүртгэж зөвшөөрлийн системийн үйл ажиллагаанд хяналт тавих гэх мэт
 - ✓ Нийгмийн хэв журам хамгаалах албанаас Цагдаагийн албаны тухай хууль, албаны дүрэмд заасан дээрх чиг үүргийг өөрийн зохион байгуулалтын бүтцийн нэгж бүрт хэрэгжүүлж байгаа практик нь нилээд өргөн агуулгаар тодорхойлогдож байна.

Цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах ажлын зохион байгуулалт нь цагдаагийн албаны захиргааны үйл ажиллагааны үр дүнд зохион байгуулалтын оновчтой бүтэц, ажил үүргийн төрлийг зөв зохион байгуулах, цагдаагийн байгууллагын бусад албадын ажил үүргийн харилцан зохистой уялдаа холбоо, олон нийтийн идэвхитэй дэмжлэг туслалцаанд тулгуурлана.

Нийгмийн хэв журам хамгаалах ажлын техник, технологийн хэрэглээ

Цагдаагийн байгууллагаас олон төрөл, хэлбэрийн нийтийг хамарсан арга хэмжээний хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон техник хэрэгсэл, технологи ашиглах ажлын эрх зүйн үндэслэл Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Инновацийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэр, ЦЕГ-ын даргын тушаал, заавар, журам, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан журам, Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги зэргээр тодорхойлогдож байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ Монгол улсын Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэн албадлагын арга хэмжээг хэрэглэх, үйл ажиллагаанд нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч-тэмдэглэгч хэрэгсэл,

согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгагч, тээврийн хэрэгслийн хурд хэмжигч болон бусад тусгай хэрэгсэл ашиглах болохоор хуульчилсан.

Нийгмийн хэв журам хамгаалах ажилд цагдаагийн байгууллагын хамгаалах тусгай хэрэгслыг олон улсын стандартад нийцүүлэх, техник хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг сүүлийн үеийн судалгаанууд харуулж байна.

Манай улсын цагдаагийн байгууллага нь нийгмийн хэв журмын хамгаалах ажилд гадаад орнуудын цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа дэвшилтэт техник хэрэгсэл, технологи нэвтрүүлэх асуудал нь улс орны төсөв, санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалаад шаардлагатай түвшинд шийдвэрлэгдэж чадахгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нөхцөл боломжуудыг ашиглан техник хэрэгсэл, технологи худалдан авч үйл ажиллагаандаа ашиглах бүрэн боломжтой заалтууд олон байдаг. Тухайлбал, тус хуулийн 7 дугаар зүйлийн 6.2 дэх заалтад Нутгийн захиргааны бүх шатны байгууллага нь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлнэ.” мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7 дэх заалтад “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батална.” гэж заасан.

Гэвч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд энэ ажлыг өөрсдийн идэвхи санаачлага дээр тулгуурлан хийж чадахгүй, нутгийн захиргааны байгууллагуудтайгаа хамтран ажиллах тал дээр сул байна гэж үзэж болохоор байна. Жишээ дурьдахад Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн хэлтэс нь дүүргийнхээ Засаг дарга болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай байнгын харилцан, хамтын ажиллагаатай байж “Дрон” нисгэгчгүй хяналтын камерыг худалдан авч дүүргийнхээ нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд ашиглаж байгаа нь сайшаалтай байна.

Түүнчлэн жил болгон шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд төвлөрүүлж байгаа билээ. Гэвч дээрхи хөрөнгийн ихэнхи хэсэг нь зориулалтын бус өөр ажилд зарцуулагдаж, түүнд хяналт тавих Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн хууль тогтоомжид хяналт тавих албан тушаалтан нь хяналтын ажлаа бүрэн дүүрэн хийхгүй байгаагаас зориулалтаар нь ашиглаж бүрэн чадахгүй байна.

Иймд хуулиар цугларсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж байгаад тавих хяналтыг цагдаагийн байгууллагад өгөх, санд цугларсан хөрөнгийн 20 хувийг цагдаагийн байгууллагад шаардлагатай техник хэрэгсэл худалдан авахад зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай юм.

Түүнчлэн цагдаагийн алба хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болохоор хуульчлан өгсөн байдаг. Цагдаагийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дах хэсэгт “цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч-тэмдэглэгч хэрэгсэл, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгагч, тээврийн хэрэгслийн хурд хэмжигч болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно”⁴⁴ гэж заасан боловч цагдаагийн байгууллагын хэмжээнд дээрх техник хэрэгслээс тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, согтуурсан, мансуурсан байдалтай эсэхийг шалгагч, тээврийн хэрэгслийн хурд хэмжигчийг Замын цагдаагийн алба, Тусгай ажиллагааны газар тус тус ашиглаж байна. Бусад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Мөн цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх талаар хуульд заасан байх тул тооцоо, судалгаа хийгдсэн нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгслийг аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс нисдэг тэрэг, тусгай зориулалтын хуягт

тээвэрлэгч, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх боломжтой юм..

Дүгнэлт

2017 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсад гарсан гэмт хэргийн талаархи судалгаатай танилцая. 2017 оны хагас жил буюу 2017 оны 01-06 дугаар сард улсын хэмжээнд нийт 12969 гэмт хэрэг бүртгэгдсэн /нийт 11019 хүн холбогдсон/ ба урьд оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 13.3 хувиар буурч, нийслэл Улаанбаатар хотод 17.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 211 нэгжээр буюу 7.3 хувиар буурсан үзүүлэлтэй бол хүүхэд оролцсон гэмт хэрэг 40 нэгжээр буюу 8.4 хувиар, галт зэвсэг хэрэглэж үйлдсэн гэмт хэрэг 11 нэгжээр буюу 52.4 хувиар тус тус өссөн байна.

Дээрхи үйлдэгдсэн гэмт хэргийн дийлэнхи хэсэг болох 4122 буюу 31.7 хувь нь “Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”, 3842 буюу 29.6 хувь нь “Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг”, 6269 буюу 48.3 хувь нь “Бусдын өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” тус тус эзэлж байна.

Эдгээр гэмт хэргүүдээс нь 19.5 хувь нь гудамж талбайд, 32.8 хувь нь гэр орон сууцанд, 15.5 хувь нь олон нийтийн газарт, 7.1 хувь нь гэр хорооллын гудамжинд, 5.5 хувь нь орон сууцны хорооллын гудамжинд, 6.8 хувь нь зочид буудал, ресторан, бааранд тус тус үйлдэгдсэн байдаг бол үйлдэгдсэн цаг хугацааны хувьд 2754 буюу 21.2 хувь нь 06-14 цагт, 3840 буюу 29.6 хувь нь 14-19 цагт, 2028 буюу 15.6 хувь нь 19-22 цагт, 4347 буюу 33.5 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгдсэн байна. Үүнээс харахад гэмт хэрэг нь шөнийн цагаар буюу 22-06 цагт хамгийн ихээр үйлдэгддэг болохыг энэхүү судалгаа харуулж байна. Мөн үйлдэгдэж байгаа гэмт хэргийн ихэнхи хувийг эзэлж байгаа хүнийг санаатай алах, хүчиндэх, бусдын бие махбодид гэмтэл учруулах, бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, танхайрах, хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих, зэрэг зонхилон үйлдэгддэг тодорхой төрлийн гэмт хэргийн дийлэнх нь архидан согтуурсаны улмаас үйлдэгдэж байна.

Бүртгэгдсэн бүх хэргийн 63.9 хувь нь нийслэл хотод, 36.1 хувь нь орон нутаг дахь газарт үйлдэгдсэн байна. Бүртгэгдсэн бүх хэргийн 50.8 хувь нь хөнгөн, 42.1 хувь нь хүндэвтэр, 5.7 хувь нь хүнд, 1.9 хувь нь онц хүнд хэрэг байна¹⁴⁶.

Хэв журмын нөхцөл байдлыг авч үзвэл Цагдаагийн байгууллага 2017 оны эхний хагас жилд нийт 739283 захиргааны зөрчил илрүүлж, давхардсан тоогоор 679940 иргэн /үүнээс 262 нь гадаадын иргэн/-д торгуулийн хуудсаар шийтгэл ногдуулсан байна.

Мөн 59343 зөрчилд холбогдуулан 44 албан тушаалтан, 709 аж ахуйн нэгж байгууллагыг 7 тэрбум 813 сая 64 мянга 900 төгрөгөөр шийтгэврээр торгож, 13508 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 7031 иргэнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Дээрхи судалгаанд дурьдагдсан тоо баримтаас харахад гэмт хэргийн дийлэнхи хувийг нийгмийн хэв журмыг хамгаалах ажлыг хангалтгүй зохион байгуулах болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оновчтой үр дүнтэй арга барилыг хэрэглээгүйгээс үүдэн гарсан гэмт хэргүүд эзэлж байна.

Зам тээврийн ослын зонхилох шалтгаан нь хурд хэтрүүлэх, анхаарал болгоомжгүй байдлаас болж байгаа бөгөөд ялангуяа орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож байгаа автомашины хурдыг хянахад анхаарлаа хандуулах шаардлага бидэнд тулгараад байна.

Нийслэл хот болон орон нутгийн замд хурдны камерыг өргөнөөр суурилуулан камержуулснаар жолооч нар өндөр хурдтай явж торгуулахаас эмээж хурдаа тохируулан хууль тогтоомжоор зөвшөөрсөн хурдны хязгаарт багтаан явж хэвшинэ. Ингэснээр жилээс жилд буурахгүй гарсаар байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо буурч иргэд амь нас, эд хөрөнгөөрөө хохирохгүй байх ач холбогдолтой юм.

Орон нутгийн засаг захиргааны нэгж болон цагдаагийн байгууллага хамтран төсөв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн зам тээврийн осол ихээр гардаг газруудыг судлан тогтоож тэнд хурд хэмжигчтэй камер байрлуулан хяналт тавьж, жолооч нарын мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах нь зүйтэй юм.

¹⁴⁶www.police.gov.mn

Камер худалдан авч ажиллуулах зардал, хурд хэтрүүлснээс үүдэн гарах хор уршгийг таниулах, иргэдийн соёл, эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд анхаарч сургалт зохион байгуулахад шаардлагатай төсвийг тухайн нутаг дэвсгэрт гарсан зам тээврийн зөрчлийн торгуулиас бий болсон мөнгө, мөн замын цагдаагийн постууд дээр хураан авдаг татвараас тодорхой хэмжээний хувийг гаргуулан авч санхүүжүүлж болох юм.

Түүнчлэн нийсэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон сүлжээ дэлгүүр, зах, олон нийтийн үзвэр үйлчилгээ, хоолны газрууд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийг нэгдсэн журмаар камержуулан камерын нэгдсэн нэг сүлжээнд холбон төв серверийг цагдаагийн байгууллагад ашиглахуйц байдлаар зохион байгуулах шаардлагатай юм. Ингэснээр хулгай, дээрэм тэр ч байтугай хүн амины гэх мэт бүхий л гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд нэн ач тустай бөгөөд энэ нь гэмт хэргийг таслан зогсоох, түргэн шуурай илрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгмийн хэв журмыг сахиулан хамгаалахад үр өгөөжөө өгөх нь дамжиггүй.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр¹⁴⁷-ийн эмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний “5.4.9-д Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулах” ажил арга хэмжээг хэрэгжүүлэн хэмээн тусгасан. Энэхүү ажлын хүрээнд нийслэл болон орон нутагт камерийн системийг тодорхой хэмжээгээр нэвтрүүлэн ашиглаж байгаа хэдий ч хангалттай хүрэлцээтэй биш болон техникийн бүрэн шаардлага хангахуйц камерыг цаашид худалдан авч ашиглах шаардлагатай байгаа юм.

Одоогийн ашиглаж буй системийн тухайд Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабд Баянзүрх дүүрэг-90, Сүхбаатар дүүрэг-294, Чингэлтэй дүүрэг -445, Баянгол дүүрэг-315, Сонгино хайрхан дүүрэг-187, Мэдээллийн шуурай удирдлагын төв-36, ЭТӨЧ -102, Замын хөдөлгөөний удирдлагын төв -52, Зөврийн төхөөрөмжийн -36, шаардлагатай цэгт суурилуулах -86 ширхэг буюу 10 өөр төрлийн техник үзүүлэлт бүхий нийт 1643 камерыг NUUO программ хангамжаар нэгтгэн, 30 хоногын хугацаатай (demo хувилбар) дээр ажиллуулж байна.

Цаашид Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабд сүлжээгээр холбогдсон төвийн 1643 ширхэг камерыг нэгтгэх программ хангамжийн албан ёсны лицензтэйгээр ашиглах шаардлагатай бөгөөд төвийн 23 (2139 ширхэг камер), орон нутгын 21 (1120 ширхэг камер) газар хэлтсийн дэд хяналтын төвийн камер, камерын системүүдийг нэгтгэн харуулахад штабд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар холбогдох байгууллагаас судалгаа гаргасан байна.

Түүнчлэн гадаадын улс орнуудад өргөнөөр ашиглаж буй орчин үеийн хүчин чадал сайтай техник хэрэгслийг худалдан авч, албаны үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай байгаа талаар дурьдсан байна. Тухайлбал:

✓ Тайвань Улсад үйлдвэрлэгдсэн “NUUO” телекамерын нэгдсэн систем нь дэлхийн тэргүүлэх 71 хяналтын IP камер үйлдвэрлэгч, брэндүүдийн 1700 гаруй төрлийн загварын камеруудын нэгтгэн удирдах боломжийг олгодог теле хяналтын удирдлагын програм хангамж юм. Камерын байршлыг тэмдэглэсэн газрын зургийн функцтэй. Программ хангамжийг албан ёсны эрхтэйгээр ашиглахад 271,920,264 төгрөгийн зардал шаардлагатай.

✓ Испани Улсад үйлдвэрлэгдсэн “Herta Security” компаний хүний царай таних систем нь хүн ихээр цугларсан олон нийтийн газар царайг таних, боловсруулах, нэвтрэх системтэй хоршин ажиллах, видео архиваас шүүлт хийх, сэжигтэн этгээдийн хайлтын өгөгдлийг бүртгэх, харьцуулан таних зэрэг үйлдлүүдийг гүйцэтгэдэг, цогц систем юм. Сүлжээнд холбогдсон телекамеруудаас сонгосон бичлэгээр царай таних, аман зураг боловсруулж, хайлт хийх боломжтой болно. Уг системийг албан ёсны эрхтэйгээр ашиглахад 540,153,068 төгрөгийн зардал шаардлагатай.

Нийслэлд нэгдсэн сүлжээний ашиглалтын тухайд нийслэлийн төвийн 5 дүүргийн цагдаагийн хэлтэс дээр байрлах теле хяналтын дэд төвүүдийг Мэдээллийн шуурхай удирдлагын төвийн шилэн кабелийн сүлжээн дэх нөөц 1 корыг ашиглан өндөр хурдны 10 Gbps хурдтай сүлжээнд холбож, төгсгөлийн свитч, роутер төхөөрөмжүүдийг шинэчлэн,

¹⁴⁷“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УБ., 2009 он. 5.4.9 дэх тал.

тохируулан тавьсан байна. Гэвч уг ашиглагдаж байгаа сүлжээний төхөөрөмжүүд нь анх суурилуулалт хийснээс дахин шинэчилж, сайжруулаагүй учир шинээр суурилуулагдсан сүлжээний тоног төхөөрөмжүүдэд холболт тасрах, шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмжинд алдаа гарах эрсдэл байнга гарч байна. Мэдээллийн шуурхай удирдлагын төвийн хэвийн ажиллагаа алдагдах, үүсэж буй эрсдлээс сэргийлж төвийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтсээс штаб хүртэлх камерын сүлжээний холболтыг түр салгасан байна.

Орон нутагт нэгдсэн сүлжээ ашиглалтын тухайд орон нутгын цагдаагийн газар хэлтэс дээр байрлах теле хяналтын дэд төвүүдийг холбоход одоо түрээсээр авч байгаа 1Mbps сүлжээний хурд нь камерын дүрс дамжуулах техникийн нөхцөл хангахгүй ба 10 Mbps хүртэл нэмэгдүүлсэнээр камерын программ хангамжийн хэрэглэгчийн горимоор хандах, бага дүрсний нягтарлаар харах боломж бүрдэнэ.

Монгол улсын 21 аймаг дэхь цагдаагийн газар хэлтсийн нэгдсэн сүлжээнд авч буй 1 Mbps хурдыг нэг жилийн төлбөрт 94.500.000 төгрөгийн түрээс төлдөг, 10 Mbps хурд болгон нэмэгдүүлсэнээр зах зээлийн үнээр 945.000.000 төгрөгийн түрээс төлөх тооцоо гарч байгаа нь урсгал зардлыг 850.500.000 төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа талаар албан хүмүүс мэдээлсэн байна.

Мэргэшсэн боловсон хүчний тухайд орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд 1997 оноос “Холбооны инженер” гэсэн 1 орон тоотой, ТТ-9 цалингийн зэрэглэлтэй байхаар батлагдсан. Анх батлагдсанаас хойш 20 жилийн хугацаанд орон тоо нэмэгдээгүй боловч ажлын ачаалал, хариуцаж байгаа техник хэрэгсэл нь нь 5-8 дахин нэмэгдсэн байна.

Мөн орон нутгын цагдаагийн газар, хэлтсээс холбооны инженерийн ажлын ачаалал, орон тоо нэмэгдүүлэх талаар судалгаа авахад 18 аймгаас 16 нь (Сүхбаатар, Говьсүмбэрээс бусад) ажлын ачаалал их байгаа, орон тоо, ажлын байрны шаардлагыг тусгаарлаж “холбооны ахлах инженер”, “сүлжээний инженер” гэх байдлаар нэмэгдүүлэх санал ирүүлсэн. Дархан, Булган, Орхон аймгийн цагдаагийн газрууд холбооны ахлах, сүлжээний инженер гэсэн байдлаар батлуулан ажиллаж байна.

Төв, орон нутгийн теле хяналтын системүүдийн засвар үйлчилгээ, цахилгаан, худаг сувагчлалын түрээсийн зардлыг тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газраас хариуцдаг боловч Багануур, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс гэх мэт зарим цагдаагийн газар хэлтсүүд гарч буй урсгал зардлыг өөрсдөө тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Теле хяналтын дэд төвүүдэд оператор цагдаа гэсэн орон тоо албан ёсоор батлагдаагүй, төв, орон нутгын цагдаагийн газар хэлтсүүд дотоод зохион байгуулалтаараа ажлын цагаар 2 алба хаагч ажлуулдаг, шөнийн цагаар жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид хариуцан ажилладаг.

Ийнхүү тусгайлан бэлтгэсэн мэргэшсэн албан хаагч байхгүйгээс орчин үеийн техник хэрэгслийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн ашиглахад хүндрэл тулгардаг байна. Иймд дан ганц үнэтэй, хүчин чадал сайтай гадаадын техник хэрэгслийг худалдан аваад зогсохгүй түүнийг ашиглаж хэрэглэж чадахуйц мэргэшсэн албан хаагчийг сурган бэлтгэх шаардлагатай юм.

Өнөөгийн Монгол Улсын эрүүгийн нөхцөл байдал нь шинэ, сайжруулсан, илүү үр дүнтэй гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, хянах цогц систем, загварыг шаардаж байна. Одоогийн хэрэглэж байгаа системийг бид илүү сайжруулж, боловсронгуй болгож нөхцөл байдалдаа тохируулж хэрэглэх боломжтой. Хэрвээ CompStat-аас манай нөхцөлд тохирсон аргуудыг авч ашиглавал нөхцөл байдлыг үнэлэх, дүн шинжилгээ хийх ингэснээр гэмт хэрэгтэй тэмцэх ажилд мэдэгдэхүйц ахиц гарна. CompStat нь цагдаагийн байгууллагад гэмт хэргийн гаралтыг бууруулж, гэмт хэрэгтэй тэмцэх явдалд илүү үр дүнтэй бодлого, стратегийг хэрэгжүүлэх боломж олгоно.

Түүнчлэн тухайн хот, нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн мэдээг 7 хоног, сар, жилээр гаргаж өмнөх 7 хоног, сар, жилүүдтэй харьцуулалт хийдэг. Ингэснээр тухайн хот, нутаг дэвсгэрт ямар газар, ямар төрлийн гэмт хэргийн гаралт ихэсч, буурч байгааг богино хугацаанд бодитойгоор тодорхойлох боломжийг удирдлагад олгодог. Үүнийг тодорхойлж чадсанаар шийдвэр гаргагчид ямар хүн хүчээр, ямар тактикаар гэмт хэрэгтэй тэмцэх оновчтой стратеги, бодлогыг төлөвлөж хэрэгжүүлснээр эерэг үр дүн гардаг.

ComStat-ийн технологи нь тухайн хот, нутаг дэвсгэрт хаана, ямар гэмт хэрэг гарч байгааг болон гэмт хэргийн өсөлт, бууралт, хэргийн өнгө, гаралтын байршлыг тухай бүр тодорхойлох боломж олгодог. Энэ нь газрын зураг, хүснэгт, график хэлбэрээр байж

удирдлагуудыг нөхцөл байдлаа бодитойгоор, шуурхай хянаж, үнэлж, зөв шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлдэг.

Нийслэл хотын гэмт хэргийн хяналтын системийг сайжруулах шаардлага бидэнтэй байнга тулгарч байна. Тухайлбал:

- ✓ Хүн амын огцом өсөлт
- ✓ Гэмт хэргийн гаралт
- ✓ Нийгэм, эдийн засаг, иргэдийн ядуурал, ухамсар, соёлын өөрчлөлт
- ✓ Улс төрийн нөхцөл байдал
- ✓ Нийслэл хотын хэт их төвлөрөлт
- ✓ Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх технологийн хоцрогдол
- ✓ Тухайн нутаг дэвсгэрийн гэмт хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор түргэн хугацаанд тодорхойлох боломжгүй байгаа
- ✓ Нийслэлийн 1 дүүрэгт 2-3 цагдаагийн хэлтэс ажиллаж байгаа тухайн дүүргийн онцлогт тохирсон нэгдмэл гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлэх боломжгүй болгож байгаа
- ✓ Одоогийн гэмт хэргийн дүн шинжилгээ хийх хугацаа хол /14 хоног/
- ✓ Үйлдэгдсэн гэмт хэргийг бодит хугацаанд үнэлэлт, дүгнэлт хийж ашиглах боломжгүй байгаа гэх мэт.

Түүнчлэн орон нутагт буюу нутаг дэвсгэрийн Цагдаагийн байгууллагад CompStat-ийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн, давуу талууд гарч болох юм. Үүнд:

- ✓ Гэмт хэргийн гаралтын байрлал, цаг хугацаа, хэргийн өнгийг зөв тодорхойлж, дүн шижилгээ хийж чадсанаар тохирсон оновчтой гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг явуулах.
- ✓ Тухайн нутаг дэвсгэр дахь урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна
- ✓ Цагдаагийн нэгжүүдийн удирдлагын манлайллыг сайжруулж, ажлын үр дүнг бодитойгоор тооцох
- ✓ Цагдаагийн байгууллагын нэгжийн уялдаа холбоог сайжруулж, эргүүлийн чиглэл, маршрутыг нөхцөл байдалд тохируулан оновчтой зохион байгуулах гэх мэт.

Эрх зүйт төр, иргэний нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхагласан Монгол Улс маань эрх зүйн шинэтгэлийг тасралтгүй хийсээр байна. Энэхүү шинэтгэлд дэвшилттэй тал байгаа хэдий ч хэрэгжүүлэх механизмын бүрдэл хараахан сайн бус, техник технологийн хөгжлийн хоцронгуй байдал зэргээс шалтгаалан шинэтгэлийн үр нөлөөг төдийлөн сайн хүртэж чадахгүй байна гэж хэлж болно.

Учир нь техник технологийн эрин зуун гэгдэх өнөө үед хүн төрөлхтөн бүхий л зүйлд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах болсон. Бид өдөр тутам ахуй амьдралдаа техник технологийн ололт амжилтыг ашиглан ихээхэн ач тусыг мэдэрч байгаа ч эсрэгээр хохирох тохиолдолд ч байсаар байна.

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.” хэмээн хуульчлан өгсөн. Цагдаагийн байгууллагад хуулиар хүлээлгэсэн энэхүү үүргийг гүйцэтгэх үндсэн төрөл алба нь нийгмийн хэв журам хамгаалах алба бөгөөд нийгмийн хэв журам хамгаалах албаны эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалж нь Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль гэж хэлж болно.

Иймд бид энэхүү дипломын ажилдаа нийгмийн хэв журам хамгаалах ажлын ойлголт, мөн чанар, эрх зүйн орчин, нийгмийн хэв журам хамгаалах ажлын удирдлага, зохион байгуулалт, хамрах хүрээ болон нийгмийн хэв журам хамгаалахад орчин үеийн техник технологийг хэрэглэх эрх зүйн үндсийг онолын үүднээс судлан үзсэн бөгөөд нийгмийн хэв журам хамгаалах ажилд орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслийг ашиглаж буй гадаад орнуудын туршлага, орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслийг ашиглах замаар нийгмийн хэв журмын хамгаалах ажлын үр нөлөөг хэрхэн дээшлүүлж болох талаар практик түвшинд судлан өөрийн санал дэвшүүлэхийг хичээсэн болно.